



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ

Ерөнхий боловсролын салбарын чиглэлээр 2020 онд баталсан баримт бичгийн эмхэтгэл





БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР
2020 ОНД БАТАЛСАН
БАРИМТ БИЧГИЙН ЭМХЭТГЭЛ**

Улаанбаатар хот
2021 он

№	Баримт бичгийн нэр	Дугаар	Огноо	Хуудасны дугаар
1	“Нийтлэг шаардлага батлах тухай” Сайдын тушаал Багшийн мэдээлэл харилцаа, холбооны технологийн цогц чадамжийн нийтлэг шаардлага	A/67	2020.02.05	5
2	“Шалгалтын зохицуулалт хийх тухай” Сайдын тушаал	A/118	2020.03.15	9
3	Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Үндэсний хөтөлбөр батлах тухай”	96	2020.03.18	10
4	“Төлөвлөгөө удирдамж батлах тухай” Сайдын тушаал Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө	A/140	2020.03.20	20
5	“Сургалтын бодлого батлах тухай” Сайдын тушаал Монгол хэлний сургалтын талаар баримтлах бодлого	A/144	2020.03.23	41
6	“Нийтлэг шаардлага батлах тухай” Сайдын тушаал Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага	A/152	2020.03.27	53
7	Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Коронавируст халдварт (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”	139	2020.04.15	59
8	“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” Сайдын тушаал	A/194	2020.04.17	60
9	“Элсэлтийн тухай” Сайдын тушаал	A/201	2020.04.21	63
10	“Заавар батлах тухай” сайдын тушаал Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлага зохион байгуулахад мөрдөх заавар	A/220	2020.05.07	64
11	“Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай” Сайдын тушаал	A/224	2020.05.20	74
12	“Чиглэл батлах тухай” Сайдын тушаал Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл	A/249	2020.05.21	76
13	Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Үндэсний хөтөлбөр батлах тухай”	207	2020.06.01	82
14	Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”	208	2020.06.01	90
15	“Хичээлийн жилийн бэлтгэл хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Сайдын тушаал	A/286	2020.06.02	91
16	“Заавар батлах тухай” Сайдын тушаал Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар	A/296	2020.06.25	95
17	“Жишиг хөтөлбөр батлах тухай” Сайдын тушаал “Хэл ярианы хөгжил” сургалтын жишиг хөтөлбөр	A/305	2020.07.01	98

18	Монгол Улсын Засгийн газрын тогтоол “Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”	32	2020.07.29	104
19	“Албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт батлах тухай” Сайдын тушаал	Б/03	2020.07.30	105
20	Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай /5 сайдын хамтарсан тушаал/	78,149,А/164, А14, А/391	2020.08.05	126
21	“Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” Сайдын тушаал	А/17	2020.08.06	128
22	Улсын Онцгой комиссын Албан даалгавар “Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай”	02	2020.08.07	143
23	Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарын 2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилт	---	---	145
24	2020-2021 оны хичээлийн жилийн хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын зөвлөмж	---	---	146
25	2020-2021 оны хичээлийн жилийн хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан эцэг эх, асран хамгаалагчид өгөх зөвлөмж	---	---	150
26	Төлөвлөгөө батлах тухай Сайдын тушаал Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III	А/176	2020.12.04	160
27	Журам батлах тухай Сайдын тушаал Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам	А/184	2020.12.11	181
28	Үлгэрчилсэн хөтөлбөр батлах тухай Сайдын тушаал Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр	А/199	2020.12.22	186
29	Тушаал хүчингүй болгох тухай /2 сайдын хамтарсан тушаал/	А/211, А/628	2020.12.28	195



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Нийтлэг шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ын 3.18 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэдээлэл харилцаа, холбооны технологийн цогц чадамжийн нийтлэг шаардлагыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү нийтлэг шаардлагыг 2019-2020 оны хичээлийн жилийн 3 дугаар улирлаас эхлэн үе шаттай хэрэгжүүлэхэд анхаарч багш нарыг дэмжин ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн дарга нар, өмчийн хэлбэр харгалзахгүй ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох албан тушаалтан нарт үүрэг болгосугай:

3.1. Нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т;

3.2. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт мэдээлэл харилцаа, холбооны цогц чадамжийн нийтлэг шаардлагыг танилцуулан, сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэн, хэрэгжүүлэх арга зүй, зөвлөмжөөр хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/, Багшийн хөтөлбөрөөр сургалт эрхэлж буй их, дээд сургуулийн захирал нарт;

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.

САЙД



У. БААТАРБИЛЭГ

142010268

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 187 дугаар тушаалын хавсралт



Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэдээлэл харилцаа, холбооны технологийн цогц чадамжийн нийтлэг шаардлага

№	Ай	Чадвар	Анхан шат	Гүйцэтгэлийн шалтгаур үзүүлэлт	Гүнзгийүүлсэн шат
1	Боловсрол дахь МХХТ-ийн бодлого	1.1. Боловсролын шинэчлэл, боловсрол дахь МХХТ-ийн үндэсний болон сургалтын байгууллагын бодлогыг судлах, тэдгээрийн үндсэн зарчмыг сургалтад тусгах.	T1-1.1.1. Боловсролын салбар дахь МХХТ-ийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн зарчмыг ойлгох. T1-1.1.2. Үндэсний, орон нутгийн болон сургалтын байгууллагын МХХТ-ийн бодлогын үндсэн зарчмыг хичээл сургалтад хэрхэн тусгах талаар тодорхойлох.	T2-1.1.1. Үндэсний, орон нутгийн болон сургуулийн МХХТ-ийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хичээл, сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх. T2-1.1.2. Боловсролын салбар дахь МХХТ-ийн бодлогын шинэчлэлд оролцох, саналаа илэрхийлэх.	T3-1.1.1. Үндэсний, орон нутгийн болон сургуулийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, алсын харгаа тодорхойлоход оролцох. T3-1.1.2. Сургалтын үйл ажиллагааг боловсролын шинэчлэл, МХХТ-ийн хөгжлийн бодлоготой уялдуулах талаар багш, суралцагчдад зөвлөх.
2	Хөтөлбөр, үнэлгээ	2.1. Хөтөлбөрийг МХХТ-той уялдуулан боловсруулах, хэрэгжүүлэх. 2.2. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчийн суралцахуйн үйлийг дэмжиж байхаар МХХТ-ийн нөөц материал, хэрэгсэлдэхүүнийг хөтөлбөрт тусган төлөвлөх, хэрэгжүүлэх.	T1-2.1.1. Үндэсний хөтөлбөр, стандартыг задлан шинжлэх, сургалтын хөтөлбөрийн тодорхой хэсгийг МХХТ-той уялдуулан боловсруулах. T1-2.2.1. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчийн суралцахуйн үйлийг дэмжиж байхаар МХХТ-ийг хэрэгжүүлэх.	T2-2.1.1. Сургалтын хөтөлбөрийг тодорхой програми, хэрэгслийг тусган төлөвлөж хэрэгжүүлэх T2-2.1.2. Ээлжит хичээлийн үйлийг суралцагчийн суралцахуйн үйлийг дэмжиж байхаар МХХТ-ийг тусган хэрэгжүүлэх.	T3-2.1.1. Суралцагч суралцахуйн үйлээ төлөвлөх, эргэцүүлэх, мэдлэг бүтээх, харилцаа, хамтын ажиллагааны мэдлэг, чадвар суралцаж байхаар МХХТ-ийг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, багш нартай хамтран ажиллах.
3	Арга зүй	2.3. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэхэд МХХТ-ийг ашиглах. 3.1. Төсөлд суурилсан, асуудал дөвшүүлэн шийдвэрлэх зэрэг суралцагч төвтэй арга зүйд МХХТ-ийг ашиглах. 3.2. Суралцагчийн бие даасан болон хамтын ажиллагааг дэмжих сургалтын арга зүйд МХХТ-ийн нөөц, хэрэгслийг уялдуулан ашиглах.	T1-2.3.1. МХХТ-д суурилан хөтөлбөр дэх явцын болон эсийн үнэлгээ хийх. T1-3.1.1. Суралцагч төвтэй сургалтад суралцагч бие даасан эсвэл хамтын ажиллагаанд МХХТ-ийг ашиглах талаар судлан тайлбарлах. T1-3.2.1. Суралцагчийн бие даан болон хамтран суралцахуйг дэмжих арга зүйг МХХТ-ийг тусган төлөвлөх. T1-3.2.2. Сургалтын агуулга, бусад шаардлагатай мэдээллийг бүтлийн гишүүд дунд хуваалцахад цахим хэрэгсэл, эх үүсвэр ашиглах талаар тодорхойлох.	T2-2.3.1. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх, сургалтын үр дүнгийн талаар мэдээлэл өгдөг байхаар МХХТ-д суурилсан үнэлгээг хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх. T2-3.1.1. Асуудал дөвшүүлэн шийдвэрлэх, төсөлд суурилсан болон бусад мэдлэг бүтээх сургалтад МХХТ-ийг ашиглах арга зүйг боловсруулж, сургалтад туршиж, хэрэгжүүлэх.	T3-2.3.1. Хөтөлбөрийн болон сургалтын үнэлгээг МХХТ-д суурилан хэрэгжүүлэх, энэ талаар багш нарт зөвлөх. T3-3.1.1. Сургалтын явцад бие даан болон хамтран суралцахуйн үйлээ эргэцүүлж сурахад суралцагчид зөвлөн туслах. T3-3.1.2. Асуудлыг шийдвэрлэх, судлан шинжлэх, бүтээл хийхэд чиглэсэн хамтын сургалтын арга зүйг МХХТ-д суурилан хэрэгжүүлэх. T3-3.2.1. Сургалтын харилцаа, хамтын ажиллагааг дэмжих үүднээс МХХТ-ийг сургалтад тусган хэрэгжүүлэх, багш нарт зөвлөх. T3-3.2.2. Сургалтад оролцогч талуудын мэдээллийн урсгалыг МХХТ-д суурилан хэрэгжүүлэх.

<p>4.1. МХХТ-ийн техникийн болон программ хэрэгсэл, дигитал нөөцийн үнэн зөв, сургалтад ашиг тустай байдлыг тодорхойлон үнэлэх.</p>	<p>T1-4.1.1. Сургуулийн орчин дахь техник болон програм хангамжийн нөөцийг тодорхойлох. T1-4.1.2. Компьютер, гар утас, зөврийн төхөөрөмж зэрэг төрөл бүрийн технологийг сургалтад хэрэглэхэд тохиромжтой болон тохиромжгүй нөхцөл, байдлыг судлан тодорхойлох.</p>	<p>T2-4.1.1. Сургалтын зорилго, стратегийг дэмжихүйц техникийн болон програмын хэрэгсэл, онлайн, оффлайн мэдээллийн үнэн зөв, үр ашгтай байдлыг үнэлэх. T2-4.1.2. Суралцагчийн суралцахуйн үйлдлийг дэмжихүйц чөлөөт, нээлттэй эхийн програмын хэрэгсэл, цахим нөөцийг оновчтой сонгон сан бүрдүүлэх, сургалтад ашиглах.</p>	<p>T3-4.1.1. Боловсролын салбарт хэрэглэж буй онлайн, оффлайн цахим агуулга, хэрэглэгдэхүүний санг хичээл сургалтад хэрэглэх талаар багш нарт зөвлөх. T3-4.1.2. Нээлттэй нөөц, программ, хэрэгслийг сургалтад оновчтой сонгон хэрэглэх, багш суралцагчдад зөвлөн туслах.</p>
<p>4.2. Сургалтын үйл ажиллагааг дэмжих орчин бүрдүүлэх, сургалтын арга зүйг хэрэгжүүлэхэд МХХТ-ийг ашиглах.</p>	<p>T1-4.2.1. Суралцагчийн мэдлэг бүтээх үйлдлийг дэмжсэн сургалтад МХХТ-ийн техникийн болон програмын хэрэгсэл, нөөцийг ашиглах арга замыг судлан тодорхойлох.</p>	<p>T2-4.2.1. Суралцагчийг асуудал шийдвэрлэх, бичил судалгаа болон бүтээл хийхээр бие даан эсвэл багаар ажиллахад нь дэмжлэг болохор цахим нөөц, хэрэглэгдэхүүн бүтээх, сургалтад хэрэглжүүлэх.</p>	<p>T3-4.2.1. Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, бичил судалгаа эсвэл бүтээл хийх зэрэг суралцагчийн бүтээлч үйлдлийг дэмжсэн сургалтад МХХТ-ийг ашиглах, багш нарт зөвлөх.</p>
<p>4.3. МХХТ-ийн хэрэглээнд өс зүйтэй, хариуцлагатай хандах, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалалтын талаар судлах, хэрэгжүүлэх.</p>	<p>T1-4.3.1. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, мэдээллийн хэрэглээний өс зүй, зохиогчийн эрхийн талаар тайлбарлах. T1-4.3.2. Техникийн болон програмын хэрэгсэл, мэдээллийн нөөцөд, хариуцлагатай хандах.</p>	<p>T2-4.3.1. Технологи болон цахим мэдээллийг хууль эрх зүйн хүрээнд өс зүйтэй ашиглах. T2-4.3.2. Цахим хандлагаас сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар баримтлах Бодлого, журмыг судлан хэрэгжүүлэх.</p>	<p>T3-4.3.1. Цахим мэдээлэл, технологийг аюулгүй, өс зүйтэй, хууль эрх зүйн хүрээнд хэрэглэх талаар багш, суралцагчдад зөвлөх. T3-4.3.2. Интернет, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цахим эрсдэлээс хамгаалах талаар багш, суралцагч, эцэг эхтэй ярилцах, тэдэнд зөвлөх.</p>
<p>4.4. Үндэсний болон сургалтын байгууллагын мэдээллийн системд ажиллах, системийн мэдээллийг сургалтын төлөвлөлт, сургалтын төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд ашиглах.</p>	<p>T1-4.4.1. Боловсролын салбарт хэрэглэж буй мэдээллийн системийн ач холбогдлыг тодорхойлох. T1-4.4.2. Боловсролын салбарын мэдээллийн систем, нөөцөд зөвшөөрөгдсөн эрхээр хандаж ажиллах.</p>	<p>T2-4.4.1. Боловсролын салбарт хэрэглэж буй мэдээллийн системийн зөвшөөрөгдсөн, нээлттэй мэдээллийг хууль эрх зүйн хүрээнд өс зүйтэй ашиглах T2-4.4.2. Сургалтын зориулалттай цахим санг хичээл сургалтад төлөвлөн ашиглах.</p>	<p>T3-4.4.1. Боловсролын салбарт хэрэглэж буй мэдээллийн системийн ажиллагааг үнэлэх, сайжруулах талаар санал гаргах, мэдээллийг сургалтын төлөвлөлт, чанарын үнэлгээнд ашиглах. T3-4.4.2. Боловсролын салбарын мэдээллийн системийн нээлттэй мэдээллийг сургалтын үйл ажиллагаанд ашиглах талаар багш нарт зөвлөх.</p>
<p>5.1. Суралцагчдын ялгаатай хэрэгцээг сургалтад тооцох, бие даан, бүлгээр эсвэл анги нийтээрээ ажиллахад тохируулан анги танхимыг зохион байгуулахад МХХТ-ийг ашиглах.</p>	<p>T1-5.1.1. Суралцагчийн чадварын ялгаа эсвэл тэдний нас, хүйс, нийгэм, хэл соёлын онцлогийг харгалзан анги, бүлэг, хувь суралцагчид тохирсон арга зүйгээр сургалтыг зохион байгуулахад МХХТ-ийг ашиглах.</p>	<p>T2-5.1.1. Анги нийтийн, багийн эсвэл суралцагч нэг бүрийн онцлогт тохирсон орчин бүрдүүлж байгаар МХХТ-ийг хичээл сургалтад төлөвлөх, хэрэгжүүлэх.</p>	<p>T3-5.1.1. Суралцагч нь сургалтын үйл ажиллагааг өөрийн хэрэгцээнд тулгуурлан төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх боломжийг бүрдүүлэхэд МХХТ-ийг ашиглах, энэ талаар багш нарт зөвлөх.</p>

<p>6 Багшийн хөгжил</p>	<p>6.1. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээндээ МХХТ-ийг ашиглах.</p>	<p>T1-6.1.1. Суралцахуйн хэрэгцээг хангах цахим хэрэгсэл, нөөцийг тодорхойлох үүднээс сургалтын практик үйлд ажиллалт хийх. T1-6.1.2. Багшийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд МХХТ-ийг ашиглах талаар судлан тодорхойлох.</p>	<p>T2-6.1.1. Сургалтын чанарыг сайжруулах, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх үүднээс МХХТ-ийг ашиглах.</p>	<p>T3-6.1.1. Мэргэжлийн тасралтгүй хөгжлөө хангах үүднээс МХХТ-ийг сургалтад хэрэглэж буй практик үйл ажиллагаандаа эргэцүүлэл хийх, тасралтгүй сайжруулах.</p>
	<p>6.2. Сургалт дахь МХХТ-ийн бүтээлч хэрэглээг судлах, хэлэлцэх, туршлагаа хуваалцах.</p>	<p>T1-6.2.1. МХХТ ашиглан бусад багш нартай санаа бодол, нөөц материаллаа хуваалцах. T1-6.2.2. Мэргэжлийн хөгжлөө дэмжих үүднээс багш нарын онлайн болон бусад хэлбэрийн бүлгэмд гишүүнээр элсэх.</p>	<p>T2-6.2.1. Мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн чиглэлээр онлайн-аар суралцах, бие даан хөгжих. T2-6.2.2. Мэргэжлийн хөгжилд хэрэглэж болохуйц мэдээллийг хайх, удирдах, боловсруулах, үнэлэхэдээ МХХТ-ийг ашиглах.</p>	<p>T3-6.2.1. Үйлийн судалгаа хийж, үр дүнг орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд хуваалцах зэрэгээр сургалтын чанарыг дээшлүүлэхэд МХХТ-ийг ашиглах. T3-6.2.2. Мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн чиглэлээр онлайн-аар суралцах, багш нартай хамтран ажиллах.</p>

Жич: Энэхүү нийтлэг шаардлага "Чадвар, шалгуур"-ыг Олон улсын боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-аас гаргасан "Багшийн мэдээлэл харилцаа холбооны технологийн цогц чөдэмжийн хүрээ" (UNESCO ICT-CFT)-ний үзэл санаанд үндэслэн боловсруулсан. Багшийн мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн нийтлэг шаардлагад: Боловсрол дахь МХХТ-ийн хэрэглээ, Хөтөлбөр, үнэлгээ, Арга зүй, Мэдээлэл харилцаа холбооны технологи, Суралцахуйн зохион байгуулалт, Удирдлага, Багшийн хөгжил гэсэн зургаан аймаг, ай тус бүрт харгалзах чадвар, шалгуурыг анхан, дунд, гүнзгийрүүлсэн 3 түвшинд тодорхойллоо.



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Шалгалтын зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 30, 64 дүгээр тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 3.13, 3.14, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн 2019-2020 оны хичээлийн жилийн анги дэвших болон улсын шалгалтыг цуцалж, шалгалтын дүнг жилийн эцсийн дүнгээр тооцсугай.

2. Нэгдмэл агуулга бүхий шалгалтын үнэлгээ /дүн/-г тооцох аргачлал, хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулж аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газарт 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хүргүүлэхийг Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг 2019-2020 оны хичээлийн жилд мөрдсүгэй.

4. Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сургуулийн удирдлага, багш нарыг арга зүй, удирдамжаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Г.Ням-Очир/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэнд даалгасугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

142010426

D:MD/RI/2020/Tushaa



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 3 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, 10.5, Монгол хэлний тухай хуулийн 11.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар ханган, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн дэмжлэгээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 196 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Боловсрол, соёл, шинжлэх
ухаан, спортын сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ё.БААТАРБИЛЭГ



Засгийн газрын 2020 оны 96 дугаар
тогтоолын хавсралт

МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР III

Нэг. Ерөнхий мэдээлэл

XIII зуунаас эхлэн монголчууд монгол бичгийг төрийн үйл хэрэгт болон шинжлэх ухааны бүтээл туурвилыг бүтээхэд хэрэглэсээр ирсэн, албан ёсны сонгодог төдийгүй дэлхийн бичиг соёлын нандин өв юм.

Монгол үндэстэн оршин тогтнох соёл, сэтгэлгээний баталгаа болсон монгол бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, өвлүүлэх, хөгжүүлэх нь Монгол хүн бүрийн төдийгүй дэлхийн бичиг соёлын өв сангийн өмнө монголчуудын хүлээж байгаа эрхэм үүрэг юм.

1946 оноос хойш төрийн албан хэргийг кирилл бичгээр хөтлөн явуулж байгаа ч төрийн байгууллагын тамга, тэмдгийг монгол бичгээр үйлдэн хэрэглэж, иргэний болон боловсролын бичиг баримтыг кирилл болон монгол бичгээр зэрэгцүүлэн бичиж байгаа нь монгол бичиг төрийн хэрэгт зохих үүргээ гүйцэтгэсээр байгаагийн нэгэн бодит жишээ болно.

Монгол Улсын Засгийн газраас 1995-2005 онд "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I", 2008-2015 онд "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II"-ийг тус тус хэрэгжүүлсэн. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I, II" хэрэгжсэнээр ерөнхий боловсролын сургуулийн VI-IX ангид монгол бичиг хичээлийг судалж, иргэний болон боловсролын баримт бичгийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдэх, ном, сурах бичиг зохиох, хөрвүүлэх, түүх, соёлын бүтээлийг нийтийн хүртээл болгох зэрэг үр дүн бий болсон.

Гэвч "Бүх нийтэд монгол бичгийг сургах, нийтийн хэрэглээний бичиг болгох, хэрэглэх орчин бий болгох" зэрэг зорилтууд хангалтгүй хэрэгжиж иржээ.

Өнөөгийн монгол бичгийн сургалт, хэрэглээний нөхцөл байдалд хийсэн шинжилгээний дүнгээр цаашид монгол бичгийн сургалтыг дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсролын салбарт эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэхэд технологийн дэвшлийг нэвтрүүлэх, стандарт дүрэм, журмыг шинэчлэн батлах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, уялдуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Мөн Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Монгол хэлний тухай хуулийн 11 дүгээр зүйлд Монгол Улсын Засгийн газрын хүлээх үүргийг тодорхойлохдоо "монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх" гэж, мөн хуулийн 7.2-т "Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна" гэж, 24.2-т "Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын

01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө" гэж тус тус заасан нь энэхүү хөтөлбөрийг шинэчлэн батлуулах эрх зүйн үндэслэл болж байна.

Иймд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлэхэд боловсрол, соёл, шинжлэх ухаан, мэдээллийн технологи, хэвлэл мэдээллийн салбарын бодлогын зорилтуудыг цогц байдлаар уялдуулж, шинээр авч үзэх нь энэ хөтөлбөрийг боловсруулах нийгмийн хэрэгцээ, нэгэн чухал хүчин зүйл болсон байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1. 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлж, бэлтгэлийг бүрэн хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

2.2.1. монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх;

2.2.2. монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх;

2.2.3. албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах;

2.2.4. монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох.

2.3. Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. монгол бичгийн кодчилал, стандартыг боловсронгуй болгож, олон улсын жишигт хүргэх;

3.1.2. албан хэргийг кирилл, монгол бичгээр хөтлөх стандартыг боловсруулж батлуулах;

3.1.3. монгол бичгийн үндэсний нэгдсэн цахим хуудас (порталсайт) нээж, хэрэглээг тогтмолжуулах;

3.1.4. нийгмийн сүлжээнд монгол бичгээ хэрэглэх технологийг нэвтрүүлж, контентын төрөл, хэлбэрийг олшруулах;

3.1.5. суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан монгол бичгийн сурах бичиг, толь бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүнийг шинэлэг арга зүйгээр боловсруулж гаргах;

3.1.6. цахим хичээл, цахим сурах бичиг, толь бичиг, сургалтын хэрэгсэл боловсруулж, нэвтрүүлэх;

3.1.7. цахим орчинд монгол бичгээр бичвэр боловсруулах чиглэлийн мэргэшүүлэх сургалтыг эрчимжүүлэх;

3.1.8. монгол бичгээр уламжлан ирсэн түүх соёлын үнэт дурсгалуудыг хамгаалах, хэвлэн нийтлэх, олшруулах;

3.1.9. утга зохиолын бүтээлийг монгол бичгээр хэвлэхийг дэмжих;

3.1.10. “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг 2021 оноос эхлэн хос бичгээр хэвлэж, 2023 оноос зөвхөн монгол бичгээр хэвлэх бэлтгэл хангаж, хэрэгжүүлэх;

3.1.11. монгол бичгээр дагнан гардаг сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлийн тоог нэмэгдүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх;

3.1.12. тогтмол хэвлэл мэдээллийн байгууллага сонин, сэтгүүл, нийтлэл, мэдээллийн агуулгын 30-аас доошгүй хувийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн гаргах, номын нэрийг нуруу хэсэгт монгол бичгээр бичиж хэвшүүлэх;

3.1.13. албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, нэрийн хуудас, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүлэх;

3.1.14. Монголын үндэсний олон нийтийн телевизийн дэлгэцийн бичвэрийг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн бичих ажлыг эхлүүлэх.

3.2. Монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарын бүсийн зөвлөгөөнийг 2 жилд тутам, улсын зөвлөгөөнийг 4 жил тутам зохион байгуулах;

3.2.2. бүх нийтийн монгол хэл, бичгийн хэрэглээ, хандлага, үнэлэмжийн судалгаанд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл, арга замыг тодорхойлох;

3.2.3. Боловсролын хүрээлэнгийн бүтцэд монгол бичгийн сургалт, судалгаа, арга зүйн нэгж ажиллуулах;

3.2.4. ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн монгол хэл, монголын түүх, уран зохиол, иргэний боловсрол, ёс суртахууны хичээлийн сурах бичгийг нэн түрүүнд, бусад хичээлийн сурах бичиг, нэмэлт хэрэглэгдэхүүнийг үе шаттайгаар монгол бичигт хөрвүүлэн хэвлэх;

3.2.5. монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийг нягт уялдуулан заах арга зүйн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх;

3.2.6. хилийн чанадад амьдарч байгаа монгол иргэд, хүүхэд, залууст монгол бичгийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх эрх зүйн болон материаллаг орчин бүрдүүлэх;

3.2.7. Монгол Улсад сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн сургуульд монгол хэл, бичгийн хичээлийг заавал судлах эрх зүйн зохицуулалтыг бүрэн хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.8. багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн ангид монгол бичиг заах аргын хичээлийг тусгайлан оруулах;

3.2.9. ерөнхий боловсролын сургууль төгсөгчид монгол хэл, бичгийн шалгалтыг заавал өгөх, шалгалтын тестийн монгол бичгийн агуулгыг 30-аас доошгүй хувьд хүргэх, шалгалтын босго оноог 400-аас эхлүүлж цаашид тодорхой хугацаанд үе шаттай нэмэгдүүлэх;

3.2.10. 2020-2021 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах;

3.2.11. их, дээд сургуульд суралцагчдаас монгол бичгийн чадварын шалгалт заавал авч, дүнг бакалаврын дипломд баталгаажуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3.2.12. монгол бичиг заах арга зүй, технологийг шинэчлэн боловсруулах;

3.2.13. монгол бичгийн улсын олимпиадыг жил бүр зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, 2021 оноос эхлэн хэрэгжүүлэх;

3.2.14. монгол бичгийн албан бус сургалт явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжих;

3.2.15. байгууллага, хамт олноороо монгол бичигтэн болох аян, хөдөлгөөн өрнүүлэх.

3.3. Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. Төрийн албаны зөвлөл, Хэлний бодлогын үндэсний зөвлөл хамтран төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварын түвшин тогтоох шалгалтын агуулгыг тогтоож, баталгаажуулах;

3.3.2. төрийн албан хаагчийн анкет (маягт-1)-д монгол бичгээр унших бичих чадварыг тэмдэглэх хэсгийг нэмэх;

3.3.3. төрийн албанд анх орох иргэдийн монгол хэл, бичгийн шалгалтын 20-аас доошгүй хувь нь монгол бичгийн агуулгаас бүрдсэн байх;

3.3.4. төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагад монгол бичгийн мэдлэг чадварыг нэмж тусгах;

3.3.5. төрийн байгууллагууд байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын сургалтын хөтөлбөрт ажилтны монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг жил бүр төлөвлөх, тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж тайлагнах;

3.3.6. төрийн болон хувийн хэвшлийн байгууллага бүр монгол хэл, бичгийн хянан найруулах чиг үүргийг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгах;

3.3.7. төрийн байгууллагууд албан бичиг хэргээ 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хөтлөх орчин бүрдүүлэх, туршиж эхлэх;

3.3.8. хөтөлбөрийн холбогдох арга хэмжээг бүх шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулан хэрэгжүүлж, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд санаачилга, үр дүнтэй ажилласан төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, ажилтан, иргэдийг урамшуулах.

3.4. Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. монгол бичиг, сурвалж судлалыг монгол судлалын бие даасан чиглэл болгож, онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх;

3.4.2. монгол бичгийн сургалт, арга зүй, судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулах;

3.4.3. монгол хэл, бичгийн дурсгал, соёлын өвийг хамгаалах, сургалтад хэрэглэх, судлан түгээх төслүүдийг Шинжлэх ухаан, технологийн сан болон бусад эх үүсвэрээс жил бүр санхүүжүүлэх;

3.4.4. монгол бичгийн өв, үндэсний соёл сэтгэлгээг хадгалах, хамгаалах, хөгжүүлэх үндэсний сан байгуулах;

3.4.5. монгол бичгийн контентыг төрийн бодлогоор дэмжиж, нэр төрлийг олшруулах;

3.4.6. монгол бичиг сурч судлах, түгээн дэлгэрүүлэхэд иргэд, олон нийтийн идэвхийг өрнүүлэх, үндэсний аяныг зохион байгуулах;

3.4.7. насан туршийн боловсролын төвд албан бус сургалтаар иргэдэд монгол бичиг сургахыг дэмжих;

3.4.8. үндэсний хэмжээнд монгол бичгийн судалгаа, сурталчилгааг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжих;

3.4.9. гадаадад монгол бичгийг сурталчлах, монгол уран бичлэг, монгол бичгээрх өв соёлын үзэсгэлэн зохион байгуулах, монгол иргэд, хүүхэд залууст монгол бичиг сургах үйл ажиллагааг Монгол Улсаас гадаад орнуудад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд, Монгол судлалын төвүүд дэмжин ажиллах.

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2020)	Зорилтот түвшин	
					2022 онд	2024 онд
1 дүгээр зорилт. Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх						
1.	Монгол бичгийн кодчилол, стандартыг олон улсын жишигт хүргэн боловсронгуй болгож батлуулна.	Батлагдсан монгол бичгийн кодчилол, стандартын тоо	тоо	-	1	-
2.	Цахим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нэвтрүүлэг, нийтлэл, мэдээллийнхээ 30-аас доошгүй хувийг монгол бичгээр тогтмол хөтлөн явуулна.	Нийтлэл мэдээллийн 30-аас доошгүй хувийг монгол бичгээр хөтөлж байгаа байгууллагын тоонд эзлэх хувь	хувь	0.3	20	30
3.	Монгол бичгийн үндэсний нэгдсэн цахим хуудас (порталсайт) нээж, цахим сурах бичиг, толь бичиг, цахим хичээл сургалтын хэрэгсэл, хөрвүүлэх програм нэвтрүүлнэ.	Цахим сан	тоо	-	1	-
		Цахим толь бичиг	тоо	-	1	-
		Хөрвүүлэгч програм	тоо	-	1	2
		Цахим хичээл	тоо	-	1	5
4.	"Төрийн мэдээлэл" сэтгүүлийг 2020 оноос эхлэн хос бичгээр хэвлэнэ.	Монгол бичгээр зэрэгцүүлсэн агуулгын эзлэх хувь	хувь	-	30	100
5.	Монгол бичгээр дагнан гардаг сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлийн тоог нэмэгдүүлнэ.	Тогтмол хэвлэлийн тоо	тоо	-	2	4
6.	Цахимд монгол бичгээр боловсруулах чиглэлийн мэргэшүүлэх сургалт зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан ажилтан/иргэдийн тоо	тоо	-	2000	2500
7.	Албан байгууллага, аж ахуй нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, нэрийн хуудас, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг	Албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийн судалгааны маягтын тоо	тоо	-	1	-
		Нэр, хаягаа монгол бичгээр бичиж байршуулсан байгууллагын эзлэх хувь	хувь	5	80	100

	монгол бичгээр бичиж хэвшүүлнэ.					
2 дугаар зорилт. Монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүрэх						
1.	Боловсролын хүрээлэнгийн бүтцэд монгол бичгийн судалгаа, арга зүйн нэгж ажиллуулна.	Байгуулагдсан нэгжийн тоо	тоо	-	1	-
2.	Монгол хэл, бичгийн багш нарын онол, заах арга зүйн төвлөрсөн болон бүсчилсэн сургалт зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан багш нарын нийт монгол хэлний багш нарт эзлэх хувь	хувь	-	50	100
3.	Монгол хэл бичгийн сургалтын чанарын үнэлгээнд дунд ахлах анги төгсөгчдийг хамруулна.	Суурь, бүрэн дунд боловсролын төгсөх ангийн сурагчдын тоонд эзлэх хувь	хувь	-	100	100
4.	Монгол бичиг заах арга зүй, технологийг шинэчлэн нэвтрүүлнэ.	Багш нарт түгээсэн заах аргазүйн технологийн гарын авлага, зөвлөмжийн тоо	тоо	-	2600	3000
5.	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын монгол бичгийн хичээлийн сургалтын хөтөлбөр, үнэлгээний аргачлалыг шинэчлэн баталж, хэрэгжүүлнэ.	Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэвлүүлж түгээсэн тоо	тоо	-	4000	5000
		Үнэлгээний аргачлалыг баталгаажуулсан баримт бичиг	тоо	-	1	-
6.	2020-2021 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах нөхцөл бүрдүүлнэ.	Монгол бичгийн хичээл судалдаг их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн хувь	хувь	-	50	80
3 дугаар зорилт. Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах						
1.	Албан бичгийг хос бичгээр хөтлөх стандарт батлагдсан байна.	Батлагдсан стандартын тоо	тоо	-	1	-
2.	Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг шалгах,	Төрийн албан хаагчийн анкетын тодорхой хэсэгт нэмэлт оруулах	хувь	-	-	100

	үнэлэх, дээшлүүлэх эрх зүйн орчин, тогтолцоо бий болгосон байна.	Төрийн албаны ерөнхий шалгалтын үнэлгээнд монгол бичгийн мэдлэг, чадварыг оноогоор үнэлэх зохицуулалт	хувь	10	-	20
		Монгол бичгийн сургалтад хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь	хувь	-	50	70
3.	Төрийн байгууллагад албан хэрэг хөтөлтийг хос бичгээр явуулах эрх зүй, технологийн нөхцөл бүрдүүлнэ.	Хос бичгээр албан хэрэг хөтлөх журмыг туршсан байгууллагын тоо	тоо	-	10	50
		Монгол бичгийн цахим бичвэрийн сургалтад хамрагдсан бичиг хэргийн ажилтны тоо	тоо	-	500	1000
4 дүгээр зорилт. Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох						
1.	Монгол бичгийн судалгааны ажил, төсөл хөтөлбөрийг төрөөс дэмжинэ.	Улсын захиалгат төсөл, санхүүжилтийн дүн	тоо	-	1	2
2.	Монгол бичгийн цахим контентыг төрийн бодлогоор дэмжиж, хэрэглээнд нэвтрүүлнэ.	Хэрэглээнд нэвтрүүлсэн цахим контентын төрөл, тоо	тоо	-	5	10
3.	Орон нутагт монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр өрнүүлсэн аян, арга хэмжээ, урамшуулал.	Арга хэмжээний тоо	тоо	-	22	30
4.	Насан туршийн боловсролын төвүүдэд монгол бичиг заах сургалтын эрх зүйн орчин бүрдүүлнэ.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	тоо	-	1500	5000
5.	Гадаадад монгол бичгийг сурталчлах үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	тоо	-	10	15

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. гадаадын зээл, тусламж;

5.1.3. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;

5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

5.2. Төрийн байгууллагууд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгаж хэрэгжүүлэх бөгөөд түүний хэрэгжилтэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

5.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн холбогдох үйл ажиллагааг төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээнд тусгаж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газарт танилцуулна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, хөтөлбөрийн үр дүнг Засгийн газрын баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

6.3. Хэвлэл мэдээллийн байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийг энэ журмын 6.2-т заасан журмын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тайлагнана.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний болон хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

----o0o----



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/140

Улаанбаатар хот

Төлөвлөгөө, удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө"-г нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжийг цэцэрлэг, сургуулийн орчинд хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

3. Батлагдсан төлөвлөгөө, удирдамжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад зориулсан онлайн сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар (Ж.Мягмар), Ерөнхий боловсролын газар (Т.Ням-Очир), Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (Ж.Болормаа), аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (С.Нансалмаа)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэнд даалгасугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

142010507



ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ОРЧИНД ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
Үйл ажиллагааны чиглэл 1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх (Халдварт болон томиу, томиу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлтгэл хангах)				
1	Цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний нөхцөл байдлын түргэвчилсэн үнэлгээний аргачлал боловсруулах, үнэлгээг жил бүр хийх	Аргачлалын дагуу үнэлгээ хийгдсэн байх	БСШУСЯ	НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийг Ивээх сан
2	Цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх удирдамж боловсруулж батлах	Төлөвлөгөө, удирдамж батлагдсан байх	БСШУСЯ	НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийг Ивээх сан, Боловсролын кластерын бусад гишүүд
3	Цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээг удирдан зохицуулах бүтцийг бүх түвшинд бий болгох	Удирдлага, зохион байгуулалтын бүтэц бий болсон байх	БСШУСЯ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар
4	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээг удирдан зохицуулах баг, бүрэлдэхүүнийг бэлтгэх, дадлага сургуулиалт хийх замаар хүний нөөцийг чадавхижуулах	Бэлтгэгдсэн хүний нөөц (тоогоор)	БСШУСЯ ОБЕГ Аймаг, нийслэлийн	НҮБ-ын Хүүхдийн сан Хүүхдийг Ивээх сан ЭМЯ,

			Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
5	Салбар хоорондын мэдээллийн шуурхай байдлыг хангах баг байгуулж, нотолгоонд суурилсан мэдээллийн сүлжээг бий болгох	Мэдээлэл солилцох байнгын ажиллагаатай сүлжээ бий болсон байх	БСШУ ЭМЯ,	ЭМЯ, Боловсролын кластерийн гишүүд, Салбарын хэмжээнд
6	Халдварт өвчин гарсан тохиолдолд сургалтын байгууллагуудтай онлайн уулзалт, ярилцлага зохион байгуулж, тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох	Зохион байгуулсан уулзалт, ярилцлага (тоогоор) Шийдвэрлэсэн асуудал	БСШУСЯ, Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
7	Хүүхдэд эрүүл ахуйн зөв зан үйл төлөвшүүлэх сургалтын агуулгыг үр дүнтэй хэрэгжүүлэх орчин бүрдүүлэх, багшийг давтан бэлтгэх, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ Зарцуулсан санхүүжилт	БСШУСЯ	ЭМЯ, Аймаг, нийслэлийн Боловсролын газар Цэцэрлэг, сургуулийн удирдлага
8	Цэцэрлэг, сургуулийн хүүхдэд сургалтаар дамжуулан дархлаажуулалт болон халдварт өвчнөөс өвөрмөц бус сэргийлэлтийн аргыг ашиглан (халуун хэмжих, амны хаалт хэрэглэх, гарын ариун цэвэр сахиж, анги танхимын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, агааржуулалт г.м) хүүхдийн хөгжлийн ялгаатай байдал, онцлогт тохирсон хэлбэрээр эзэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эрүүл ахуйн зөв зан үйл төлөвшүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	БСШУСЯ	ЭМЯ, Цэцэрлэг, сургуулийн удирдлага
9	Цэцэрлэг, сургууль, дотуур байранд тогтоосон норм, нормативт нийцүүлэн гар угаах орчин, нөхцөлийг бүрдүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ/зарцуулсан санхүүжилт	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Цэцэрлэг, сургуулийн удирдлага

10	Гарын ариун цэвэр сахиx хэрэгцээ, шаардлага, ач холбогдол, арга аргачлал /хэзээ, яаж хэрэглэх, хэрхэн хянах/, түүний хэрэглээ, дадал хэвшлийг хяналтын хуудсаар үнэлэх	Үнэлгээний үр дүн	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
11	Амны хаалт хэрэглэх хэрэгцээ шаардлага, ач холбогдол, амны хаалт сонгох, зөв хэрэглэх /тогтмол зүүх, солих хугацаа, аюулгүйгээр хаях, угааж индүүдэх/ дадал хэвшлийг хяналтын хуудсаар үнэлэх	Үнэлгээний үр дүн	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
12	Халуун хэмжих хэрэгцээ шаардлага, ач холбогдол, арга аргачлал /давтамж, ямар үед ямар багажаар, яаж хэмжих/, биеийн халууны хэвийн, хэвийн бус хэмжээ, халуунтай тохиолдолд нэн тэргүүнд авах арга хэмжээний талаарх мэдлэг, түүний хэрэгжилтийн байдлыг хяналтын хуудсаар үнэлэх	Үнэлгээний үр дүн	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
13	Ханиаж найтаахдаа амны алчуураар ам, хамраа дарах, гарын шуу, тохойгоор халхлах, амны алчуураа угаах эсвэл хогийн саванд хаях, ханиаж, найтаасны дараа гараа угаах дадал хэвшлийг хяналтын хуудсаар үнэлэх	Үнэлгээний үр дүн	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
14	Шүлс, нус, цэрийг ил задгай хаяхгүй, ил задгай бие засахгүй байх, хогийг хогийн саванд хийх дадал хэвшлийг хяналтын хуудсаар үнэлэх	Үнэлгээний үр дүн	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
15	Халуурсан, өвчний бусад шинж илэрсэн болон эмч зөвлөсөн тохиолдолд халуун буурч, өвчний шинж арилснаас хойш 24 цагийн турш гэрийн дэглэм үргэлжлүүлэн баримтлах, түүний ач холбогдлын талаарх мэдлэгийг хяналтын хуудсаар үнэлэх	Үнэлгээний үр дүн	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
16	Анги танхим, өрөө, тасалгаанд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, агааржуулалтыг зааврын дагуу хийж хэвшсэн байдлыг хяналтын хуудсаар үнэлэх	Үнэлгээний үр дүн	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
17	Хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалтын горимыг баримтлах, хүмүүсийн уулзалт, бөөгнөрлийн тоог бууруулах, хүмүүс	Үнэлгээний үр дүн	Аймаг, нийслэлийн	Цэцэрлэг, сургуулийн удирдлага

	хоорондын зайг нэмэгдүүлэх, халдвар тархалтыг хязгаарлах, ач холбогдлыг ойлгосон эсэхийг үнэлэх		Боловсролын газар	
18	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээ авахад шаардлагатай нөөц /цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодис, халуун хэмжих багаж, хичээлийн хэрэгсэл/, тэдгээрийг хадгалах байр, нөхөн хангалт хийх гэрээ хэлцэл хийх зохицуулалтыг шийдвэрлэсэн байдлыг үнэлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, Зарцуулсан санхүүжилт	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
19	Цэцэрлэг, дотуур байрны болон нийт хүүхдүүдийн хоолой зайлах уусмалыг бэлтгэн өглөө, өдөр, оройд хоолойг зайлуулах, гэртээ амьдардаг хүүхэд тэдний эцэг эх, асран хамгаалагчид зааж зөвлөх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Цэцэрлэг, сургуулийн удирдлага	Эцэг, эх, асран хамгаалагч
Үйл ажиллагааны чиглэл 2. Халдварт өвчний дэгдэлтийн түвшнүүр үүссэн үед (Халдварт болон томуу, томуу төст өвчин бүртгэгдэж эхэлнэ)				
1	Халдварт болон томуу, томуу төст өвчний талаарх мэдээ, мэдээллийг салбар хооронд болон олон улсын байгууллагуудтай тогтмол солилцох	Салбар хооронд солилцсон мэдээний тоо	БСШУСЯ	ЭМЯ, Боловсролын кластерийн гишүүн байгууллага
2	Халдварт болон томуу, томуу төст өвчний талаарх мэдээ, мэдээлэлд үндэслэн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийх	Төлөвлөгөөнд тодотгол хийсэн байдал	БСШУСЯ	Боловсролын кластерийн гишүүн байгууллага
3	Халдварт болон томуу, томуу төст өвчний тандалтын 7 хоног тутмын мэдээ, өвчлөлийн цар хүрээтэй уялдуулан холбогдох арга хэмжээг авах	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	БСШУСЯ	Аймаг, нийслэлийн Засаг дарга
4	Цэцэрлэг, сургууль, дотуур байрын анги танхим, өрөө тасалгаа, биеийн тамир, хурлын зааланд чийгтэй цэвэрлэгээ, агааржуулалтыг өдөрт 2-3 удаа хийх, халдваргүйжүүлэх, 18-20 хэмийн дулаантай байлгах	Бүртгэл, хяналтын хуудас	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага

5	Халдварт болон томуу, томуу төст өвчнөөр өвчилсэн багш, ажилчид, хүүхдийг ажил, хичээллэс эмчийн магадлагаагаар чөлөөлж, гэрийн дэглэм сахиулах	Ирцийн мэдээ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
6	Цэцэрлэг, сургууль, дотуур байрын хүүхдийн хоолны цэсэнд илчлэг, шим тэжээллэг, амин дэмээр баялаг хоол хүнсийг түлхүү оруулах, хэрэгжүүлэх	Хоолны цэсэнд хийсэн шинжилгээний дүн, Хүнсний бүтээгдэхүүний хангалтын мэдээ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
7	Цэцэрлэг, сургууль, дотуур байр түүний орчинд хурал, уралдаан тэмцээн, олимпиад, уулзалт, үдэшлэг, спортын болон бусад арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах	Холбогдох газраас гаргасан шийдвэр, Жижүүрийн тэмдэглэл	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
8	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл ахуйн зан үйл, гарын ариун цэвэр сахиу, амны хаалт хэрэглэх, зөв ханиаж найтаах, халуун хэмжих, гэрийн дэглэм сахиу, дархлаа дэмжих, хөл хорионы дэглэм сахиу, дархлаажуулах, эмнэлэгт хандах зэрэг аргуудыг хүүхдийн хөгжлийн ялгаатай байдал, онцлогт тохирсон хэлбэрээр таниулах, сурталчлах	Зохион байгуулсан нөлөөллийн үйл ажиллагаа, хамрагдсан хүний тоо	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
9	Цэцэрлэг, сургууль, дотуур байрын цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн нөхцөл байдлыг өөрийн үнэлгээний хуудсаар үнэлэх, шаардлагатай арга хэмжээ авах	Нөхцөл байдлыг үнэлсэн тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
10	Хөл хорио тогтоосон нөхцөлд хичээл, сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн теле, онлайн, радио зэрэг зайн сургалт зохион байгуулах бэлтгэл хангах	Зайн сургалтын зохион байгуулах төлөвлөгөө, санхүүжилт	БСШУСЯ	НҮБ-ын Хүүхдийн сан Хүүхдийг Ивээх сан Аймаг, нийслэлийн Боловсролын газар

11	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах, хөгжих онцлогийг дэмжсэн сургалтын гарын авлага, постер, зураг карт боловсруулан хэвлүүлэх, брайль болон сонсдог аудио хэлбэрээр бэлтгэх	Бэлтгэсэн гарын авлага, постер, зураг карт, брайль болон сонсдог аудио бичлэгийн тоо	БСШУСЯ Боловсролын хүрээлэн	МУБИС Олон Улсын байгууллага
12	Халдварт өвчин, хөл хорио, гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх зөвлөмж боловсруулах, түгээн дэлгэрүүлэх	Зөвлөмж боловсруулсан байна	БСШУСЯ Боловсролын хүрээлэн	Олон Улсын байгууллага
13	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд зориулсан ганцаарчилсан сургалтын видео хичээлийн сан бүрдүүлэх	Бүрдүүлсэн видео хичээлийн тоо	БСШУСЯ Боловсролын хүрээлэн, БСШУСЯ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, МУБИС
14	Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан зайн сургалт, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан зөвлөгөө мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр боловсруулах	Бэлтгэсэн зайн сургалт, зөвлөгөө, мэдээллийн тоо	БСШУСЯ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар
Үйл ажиллагааны чиглэл 3. Халдварт өвчний дэгдэлтийн үед (Халдварт өвчин хүн амын дунд өргөн тархаж, хүн амыг олноор өвчлүүлнэ)				
1	Халдварт өвчний түгшүүрийн үеийн арга хэмжээг эрчимжүүлэх, гамшгийн цагийн байдлын нөхцөлд шилжүүлсэн шийдвэрийг хэрэгжүүлэх	Улсын Онцгой комисс, Засгийн газрын шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ	БСШУСЯ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар
2	Хичээл, сургалтын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж буй үед цэцэрлэг, сургууль, дотуур байрн анги танхим, өрөө тасалгаа, биеийн тамир, хурлын зааланд чийгтэй цэвэрлэгээ, агааржуулалтыг өдөрт 2-3 удаа хийх, халдваргүйжүүлэх, 18-20 хэмийн дулаантай байлгах	Бүртгэл, хяналтын хуудас	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
3	Хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон үед хичээл, сургалтын үйл ажиллагааг теле, онлайн, радио зэрэг зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулах	Зайн сургалтаар зохион байгуулсан	БСШУСЯ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар

	хичээлийн тоо, санхүүжилт		хичээлийн тоо, санхүүжилт	
4	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд тэдний эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан теле, онлайн, радио, видео сургалт, зөвлөгөө мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах		Зайн сургалтаар зохион байгуулсан хичээлийн, зөвлөгөө, мэдээллийн тоо, санхүүжилт	БШУСЯ Аймаг, нийслэлийн Боловсролын газар
5	Халдварт өвчний тархалтын нөхцөл байдалд үндэслэн зарим цэцэрлэг, сургуулийг ердийн болон богиносгосон цагийн хуваарьар ажиллуулах боломжийг судалж шийдвэрлэх		Өвчлөлийн мэдээнд үндэслэн гаргасан шийдвэр	БШУСЯ Аймаг, нийслэлийн Боловсролын газар
6	Хорио, хөдөлгөөний хязгаарлалтын үед баримтлах дэглэм, журам, хугацаа, хэрэгжүүлж буй арга хэмжээ, илэрч буй зөрчил, анхаарах асуудлыг олон нийтэд мэдээлэх		Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэсэн мэдээллийн тоо	БШУСЯ Аймаг, нийслэлийн Боловсролын газар
7	Хорио, хөдөлгөөний хязгаарлалтын үед үзүүлж буй боловсролын үйлчилгээний талаар сурагчид, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн санал, хүсэлтийг хүлээн авах байнгын ажиллагаатай утас, хаяг ажиллуулах		Иргэдээс ирсэн санал, хүсэлтийн тоо, шийдвэрлэсэн байдал	БШУСЯ Аймаг, нийслэлийн Боловсролын газар
8	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын анги дэвших болон улсын шалгалт, их дээд сургуульд элсэгчдээс авах шалгалтын зохицуулалт хийх		Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр	БШУСЯ Боловсролын Үнэлгээний төв Аймаг, нийслэлийн Боловсролын газар
9	Хорио, хөдөлгөөний хязгаарлалтын хугацаанд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, асран хамгаалах, гэр бүлийн орчинд зайнаас суралцахад нь дэмжин туслах, дархлааг дэмжих, хөл хорионы дэглэмийг сахих талаар эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах		Зохион байгуулсан арга хэмжээний болон хамрагдсан хүний тоо	Аймаг, нийслэлийн Боловсролын газар

	Эрүүл мэнд, хүүхэд хамгааллын болон бусад байгууллагаас гаргаж байгаа сэрэмжлүүлэг, зөвлөмж мэдээллийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдад сурталчлах, түгээх	Арга хэмжээний тоо Хэвлэж түгээсэн материалын тоо	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
10	Үйл ажиллагааны чиглэл 4. Хорио, хөдөлгөөний хязгаарлалтын дараа хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлэн байдлыг хангах			
1	Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх бэлтгэл хангах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх	Батлагдсан төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	БСШУСЯ	Аймаг, нийслэлийн БСУГ, Боловсролын кластерын гишүүд
2	Хэвийн горимд шилжих хугацаанд халуун хэмжих, амины хаалт хэрэглэх, гарын ариун цэвэр сахиу, анги танхимын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, агааржуулалт, хоол хүнс, хүүхэд, багш, ажилтнуудын эрүүл мэндийн хяналтыг 14 хоног үргэлжлүүлэх, холбогдох заавар зөвлөмжөөр хангах, хэрэгжүүлэх	Зохихон байгуулсан арга хэмжээний болон хамрагдсан хүний тоо	БСШУСЯ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар, Боловсролын кластерын гишүүд
3	Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжсэн эхний сард суралцагч, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад сургалтын байгууллага "АЮУЛГҮЙ" гэсэн итгэлийг төрүүлэх, айдас, түгшүүр, эргэлзээг тайлах, тайвшруулах сургалт, нийгэм-сэтгэл зүйн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Зохихон байгуулсан арга хэмжээний болон хамрагдсан хүний тоо	БСШУСЯ Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага, Боловсролын кластерын гишүүд
4	Хорио, хөдөлгөөний хязгаарлалтын үед зохион байгуулсан сургалтын үр дүнд үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, холбогдох арга хэмжээ авах	Үнэлгээний үр дүнд, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	БСШУСЯ, Боловсролын Хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	НҮБ Хүүхдийн Сан, Хүүхдийн Ивээх Сан, Цэцэрлэг, сургуулийн удирдлага

5	Хөл хорио хязгаарлалтын үед зайн сургалтаар зохион байгуулсан сургалтын хөтөлбөрийн агуулгыг бататгах төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх	Батлагдсан төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	БСШУСЯ Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
6	Цэцэрлэг, сургууль, дотуур байрын орчинд гарын ариун цэвэр сахиу зөвлөмж, зааварчилгааг хэрэгжүүлэх, хяналт тавих, холбогдох арга хэмжээ авах	Зохион байгуулсан арга хэмжээний болон хамрагдсан хүний тоо	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
7	Халдварт өвчнөөс сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээ авахад шаардлагатай нөөц /цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодис, халуун хэмжих багаж, хичээлийн хэрэгсэл, хоол хүнсний хангалт/ тэдгээрийг хадгалах байр, нөхөн хангалт хийх гэрээ хэлцэл, зохицуулалт хийх, хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, Зарцуулсан санхүүжилт	БСШУСЯ Аймаг, нийслэлийн Боловсролын газар	Цэцэрлэг, сургуулийн удирдлага
8	Цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоолой зайлах уусмал бэлтгэн өглөө, өдөр, оройд хоолойг зайлуулах, гэртээ амьдардаг хүүхэд, тэдний эцэг эхэд зааж зөвлөх, хэвшүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний болон хамрагдсан хүний тоо	Цэцэрлэг, сургуулийн удирдлага	Эцэг эх, асран хамгаалагч

Тайлбар:

Цэцэрлэг, сургуулийн орчин гэдэгт – Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрыг ойлгоно.

Халдварт өвчнөөс сэргийлэх гэдэгт – Цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт болон томуу, томуу төст өвчний дэгдэлт, халдвар, цар тахлаас сэргийлэх арга хэмжээг ойлгоно.

----oOo----

9

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2020 оны 03
дугаар сарын 20-ний өдрийн А/АЧО
дугаар тушаалын хоёрдугаар
хэвсрэлт

**Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд
халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал,
хариу арга хэмжээний удирдамж**

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд энэхүү удирдамжийг мөрдөнө.

Нэг. Үндэслэл

Халдварт болон томуу, томуу төст өвчин, томуугийн цартахал хүн амын эрүүл мэнд төдийгүй эдийн засаг, нийгмийн харилцаанд ноцтой үр дагавар учруулдаг. Иймээс аливаа халдварт өвчин, цартахлын улмаас үүсэх аюул гамшгийг хохирол багатай даван гарахад болзошгүй тохиолдлыг урьдчилан төлөвлөж бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх цогц үйл ажиллагааны чадавхийг бүрдүүлэх шаардлага салбар бүрт тулгарч байна.

Халдварт болон томуу, томуу төст өвчний үед өвчний тархалтыг хязгаарлах олон арга байдаг бөгөөд түүнийг ерөнхийд нь өвөрмөц, өвөрмөц бус гэж ангилж болно.

Өвөрмөц арга гэдэгт эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагаас авч хэрэгжүүлэх дархлаажуулалт, шинжилгээ, оношилгоо, тандалт судалгаа, эмчилгээ, тусгаарлалт зэрэг арга хэмжээ багтана.

Өвөрмөц бус арга гэдэгт хувь хүний эрүүл аж төрөх амьдралын хэв маягийн хүрээнд өдөр тутамд хэрэгжүүлдэг болон олон нийт, нийгмийг хамарсан хөл хорио, нийгмийн дайчилгаа, олон нийтэд мэдээлэл харилцаагаар дамжуулан өгөх мэдээлэл сэргийлэлт зэрэг арга хэмжээ багтдаг.

Хувь хүний түвшинд гарын ариун цэвэр сахиу, амны хаалт хэрэглэх, ханиаж, найтаахдаа цаасан алчуураар ам хамраа дарах эсвэл гарын шуу, тохойгоор халхлах, нус, шүлс, цэрээ ил задгай хаяхгүй, ил задгай бие засахгүй байх, хог хаягдлыг хогийн саванд хийх, гэр орон байр, анги танхим, амьдарч буй орчноо цэвэрлэх, агааржуулах, халдваргүйжүүлэх, өвчилсөн бол гэрийн дэглэм сахиу, өвчин халдвар гарсан улс орон, газар руу явахгүй байх, дархлаагаа дэмжих, зөв хооллох, сайн унтаж амрах, тайван байх зэрэг нь халдварт болон томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх бэлэн байдлаа хангаж, дэгдэлтийн эсрэг авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээ юм.

Өвөрмөц бус сэргийлэлтийн арга хэмжээний үр дүн нь оношилгооны найдвартай арга, оношлуур, вирусний эсрэг эм гарган авах, вакцин үйлдвэрлэх зэрэг бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах хүчин чармайлтад



шаардлагатай цаг хугацааг бий болгох замаар аливаа халдварт өвчин, томуугийн цартахлын хор нөлөөг бууруулдаг.

Цэцэрлэг, сургуулийн орчинд хэрэгжүүлэх энэхүү удирдамжийг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, шийдвэр, тушаал, Дэлхийн эрүүл мэндийн чуулганы 64.10 дугаар шийдвэр, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын цартахлын эрсдэлийн менежментийн стратеги, Олон улсын эрүүл мэндийн дүрэм, НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргасан сургууль, цэцэрлэгийн аюулгүй үйл ажиллагааны удирдамж, АНУ-ын Өвчний хяналт сэргийлэлтийн төвөөс боловсруулан гаргасан улирлын томуугийн үед цэцэрлэг, сургуулийн орчинд хийх цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн гарын авлага, Ковид-19 вирусийн халдварын дэгдэлтийн өнөөгийн нөхцөл байдлын мэдээлэл, эрх бүхий байгууллагуудаас гаргаж байгаа шийдвэрийг тус тус үндэслэн боловсрууллаа.

Хоёр. Зорилго

Цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт болон томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх бэлэн байдлыг хангах, дэгдэлтийг хохирол багатай даван туулах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, хичээл, сургалтын үйл ажиллагааг хэвийн нөхцөлд шилжүүлэх ажлыг зохион байгуулах

Гурав.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

3.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангах:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг үүсэж буй нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх;
2. Гарaa тогтмол угаах болон гарын эрүүл ахуйг сахихыг хөхиүлэн дэмжиж, шаардлагатай хангамж хэрэгсэл, материалыг худалдах авах, нөөцлөх;
3. Саван, усаар хангагдсан гар угаах газруудыг бэлтгэж, тэдгээрийг байнгын ажиллагаатай байлгахад анхаарч, хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэх;
4. Боломжтой тохиолдолд спиртэн суурьтай гар ариутгагчийг бүх анги танхим, орц, гарцын хаалга, хоолны газар болон ариун цэврийн ерөөний ойролцоо байрлуулах;
5. Анги танхим болон ариун цэврийн ерөөг өдөрт хамгийн багадаа нэг удаа цэвэрлэж, халдваргүйжүүлэх. Энэ тохиолдолд олон хүний гар хүрдэг шатны бариул, хоолны ширээ, спортын тоног хэрэгсэл, хаалга, цонхны бариул, хүүхдийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг хатуу гадаргууг онцгойлон цэвэрлэж, халдваргүйжүүлэх;
6. Хичээл эхлэх болон тарах цагийг өөр, өөр байхаар зөрүүлж зохицуулах;
7. Боломжтой тохиолдолд хүүхдийн ширээ, сандал, ор өөр хоорондоо хамгийн багадаа нэг метр зайтай байхаар байрлуулах;
8. Хоорондоо хол зайнаас харилцах, шаардлагагүй үед нэгнийхээ биед хүрэхгүй бага насны хүүхэд, суралцагчдад заах, багш, насанд хүрэгчид биеэр үлгэрлэх;

9. Бага насны хүүхэд, суралцагч, багш, ажилтанд цэцэрлэг, сургууль дээр байх үед нь өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд хэрэгжүүлж ажиллах горим, дэг гаргах, хамт олонд танилцуулах, мөрдөх;
10. Харьяа эрүүл мэндийн байгууллага, сургуулийн эмчтэй хамтран урьдчилан төлөвлөлт хийх, яаралтай үед холбоо барих эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, эмчийн утасны дугаар гэх мэт мэдээллийг шинэчлэн бүрдүүлэх;
11. Өвчний шинж тэмдэг илэрсэн бага насны хүүхэд, суралцагч, багш, ажилчдыг эвгүй байдалд оруулахгүйгээр бусад хүмүүсээс тусгаарлах, эцэг эх, асран хамгаалагчид нь мэдээлэх;
12. Боломжтой тохиолдолд эрүүл мэндийн байгууллагатай зөвлөлдөн эмнэлэгт шилжүүлэх эсвэл гэрт нь хүргэх.

3.2. Мэдээлэл хуваалцах:

1. Эрүүл мэндийн болон боловсролын удирдах байгууллагаас гаргасан журам, зааврыг мөрдөх;
2. Цэцэрлэг, сургууль дээр хийгдэж буй урьдчилан сэргийлэх болон хяналт тавих арга хэмжээ, өвчний нөхцөл байдлын талаарх шинэ мэдээллийг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд, суралцагчдад хүргэх;
3. Гэрт нь хэн нэгэн халдварт өвчнөөр өвчилсөн гэж оношлогдсон тохиолдолд энэ талаар цэцэрлэг, сургууль болон эмнэлгийн байгууллагад мэдэгдэж, хүүхдээ цэцэрлэг, сургуульд явуулахгүй байхыг эцэг эх, асран хамгаалагчдад анхааруулах;
4. Мэдээлэл хуваалцах явдлыг дэмжихэд боломжит арга хэлбэрийг ашиглах, зарлалын самбар, төв гарц, ариун цэврийн өрөө, коридор болон бусад газарт зурагт хуудас, холбогдох материалыг байрлуулах;
5. Бага насны хүүхэд, суралцагч, багш, ажилтны ирцийг бүртгэж, түүнд хяналт-шинжилгээ хийх, ердийн үеийн ирцтэй харьцуулалт хийж хэвших, амьсгалын замын өвчнөөс үүдэн хүүхэд, багш, ажилтны ирцэд өөрчлөлт гарсан тохиолдолд удирдах шатны болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх.

3.3. Шаардлагатай тохиолдолд цэцэрлэг, сургуулийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах:

1. Бага насны хүүхэд, суралцагч, багш, ажилтан өөрөө өвчилсөн буюу өвчтэй хүн асрахаар гэртээ байх явдлыг нь дэмжихийн тулд ажиллах болон хичээлд хамрагдах, өвчний чөлөө авах талаар уян хатан бодлого баримтлах;
2. Ажил, хичээл огт таслаагүй үед олгодог шагнал, урамшууллын тогтолцоог энэ үед мөрдөхийг түр зогсоох;
3. Чухал ажил үүрэг болон албан тушаалыг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд эдгээр үүргийг орлон гүйцэтгэх хүмүүсийг сургах;
4. Хичээлийн жилийн төлөвлөгөөнд орж болзошгүй өөрчлөлтийг цэцэрлэг, сургуулийн дүрэмд тусгаж, ялангуяа сургуулийн хичээллэх хуваарь, амралт, шалгалттай холбоотой өөрчлөлтийг холбогдох удирдамж, зааврыг үндэслэн дахин төлөвлөх.

Дөрөв. Халдварт өвчний дэгдэлтийн үед авах хариу арга хэмжээ

4.1. Сургалтын үйл ажиллагааг зайн сургалтаар зохион байгуулах:

1. Цахим, онлайн сургалт, теле хичээл зэрэг зайн сургалтын хэлбэрийг ашиглах;
2. Гэртээ унших, судалж суралцах дасгал, даалгаврыг онлайнаар болон гар утсаар өгөх;
3. Сургалтын агуулга бүхий нэвтрүүлгийг үндэсний болон орон нутгийн радио, подкаст, телевизээр дамжуулах;
4. Үндэсний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан агуулга бүхий хичээл, сургалтын хуваарийг боломжтой сувгаар, олон давтамжтайгаар хүргэх;
5. Суралцагчидтай өдөр бүр эсвэл долоо хоног бүр холбогдох багшийг томилох, ажлын хуваарь гаргаж мөрдөх;
6. Бага насны хүүхэд, суралцагчаас гадна эцэг, эх, асран хамгаалагч, насанд хүрэгчдэд зайн сургалт, теле хичээлийг заавал үзэж, хүүхэдтэйгээ хамтран хичээллэх шаардлагатайг ойлгуулах, зөвлөх;
7. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөл хорионы дэглэм сахих, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг бүх насны иргэдэд ойлгуулах арга хэмжээг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
8. Халдварт өвчний эрсдэлгүй гэж үзсэн алслагдмал орон нутгийн зарим цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх боломжийг судлах.

4.2. Сэтгэцийн эрүүл мэнд ба сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх:

1. Хөл хорионд байгаа хүүхдүүдэд тэдний асуусан зүйл болон сэтгэл санааг нь зовоож буй асуудлын талаар ярилцаж байх, тухайн эцэг, эх, асран хамгаалагчдад анхааруулах;
2. Хүүхдийн хувьд асуудалд өөр, өөр байдлаар хандах нь хэвийн зүйл бөгөөд аливаа асуух зүйлс эсвэл санааг нь зовоож байгаа асуудал байвал багштайгаа утсаар болон онлайнаар ярилцахыг дэмжих;
3. Мэдээллийг хүүхдийн насны онцлогт тохирсон байдлаар илэн далангүй хүргэх;
4. Найз нөхөд, үе тэнгийнхнээ хэрхэн дэмжих болон ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох, дээрэлхэлтээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сурагчдад ойлгуулах;
5. Өөрийнх нь сайн сайхан байдалд хэрэг болохуйц мэдээлэл, ажлын болон амьдралын туршлага, нөөц боломж, арга замыг багш, эцэг эх, асран хамгаалагчид мэддэг гэдгийг итгүүлэн үнэмшүүлэх;
6. Сэтгэлийн зовиур, шаналгаатай шинж тэмдэг илэрсэн бага насны хүүхэд, суралцагч, багш, ажилтныг таних, тэдэнд дэмжлэг үзүүлэх чиглэлээр сургуулийн эмч/нийгмийн ажилтан, удирдлага хамтран ажиллах;
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, хоол хүнсний хөтөлбөр, эмчилгээ заслын үйлчилгээ зэрэг цэцэрлэг, сургууль

дээр үзүүлдэг үйлчилгээг гэрт нь үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн тулд нийгмийн халамж үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллах;

8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд халдварт өвчин, түүний хоёрдогч нөлөөлөлд илүү их ертөмтгий байна гэдгийг анхаарах;
9. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа зогссон үед гэртээ өвчтэй хүн асрах үүрэг хүлээх, аливаа хүчирхийлэл мөлжлөгт өртөх зэрэг эрсдэл хүүхдэд, ялангуяа охидод нэмэгдэж болзошгүйг анхаарах.

4.3. Хүүхдэд өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд авах арга хэмжээ:

1. Халдвар, вирусийн гаралтай томуу , төст өвчлөлийн үед ханиалгах, халуурах зэрэг шинж тэмдэг нь илүү түгээмэл байдаг энгийн ханиад томуу, томуу төст өвчнүүдийн шинж тэмдэгтэй ижил төстэй байдгийг санах;
2. Хүүхэд тань өвчтэй бол түүнийг гэртээ байлгаж, энэ талаар болон өвчний шинж тэмдгийг цэцэрлэг, сургуульд заавал мэдэгдэхийг эцэг, эх, асран хамгаалагчдад ойлгуулах;
3. Эрүүл мэндийн холбогдох байгууллагатай утсаар холбогдож эрүүл мэндийн зөвлөгөө авсны дараа шаардлагатай гэж зөвлөсөн тохиолдолд хүүхдээ эмнэлэгт аваачих хэрэгтэй гэдгийг эцэг, эх, асран хамгаалагчдад ойлгуулах.

4.4. Дараах зайлшгүй шаардлагатай зааврыг гэр бүлийн нөхцөлд хүүхэд бүр биелүүлэх:

1. Гараа зөв угаах заавар:
 - Алхам 1: Аюулгүй, цэвэрхэн усаар гараа норгох;
 - Алхам 2: Норгосон гараа хангалттай савандах;
 - Алхам 3: Гарын алга, ар тал, хуруунуудын хооронд, хумсны дотор тал зэрэг гарын бүх гадаргууг хамгийн багадаа 20 секунд үрэх;
 - Алхам 4: Аюулгүй, цэвэрхэн усаар сайтар зайлах;
 - Алхам 5: Гараа цэвэрхэн хуурай алчуур, нэг удаагийн цаасан алчуур эсвэл гар хатаагчийн аль байгааг нь ашиглаж хатаах.

Тайлбар: Хоол идэхийн өмнө, идсэний дараа; нусаа нийх, ханиах эсвэл найтаасны дараа; ариун цэврийн өрөө/бие засах газар/жорлонд орсны дараа, гар бохирдсон тохиолдол бүрт тогтмол угаах, саван, ус байхгүй тохиолдолд хамгийн багадаа 60 хувийн спиртийн найрлагатай гар халдваргүйжүүлэгч хэрэглээрэй. Таны гар бохир байгаа нь тодорхой харагдаж байгаа үед заавал саван, ус ашиглаж угаагаарай.

2. Зөв ханиаж найтаах заавар:
 - Алхам 1. Ханиаж, найтаахдаа амаа гарын шууны дотор тал эсвэл тохойн дотор талаар халхлах;
 - Алхам 2. Цаасан алчуураар ам, хамраа таглаад ханиаж, найтаасны дараа хэрэглэсэн цаасан алчуураа тагтай хогийн саванд хийх;
 - Алхам 3. Гараа сайтар угаагаагүй тохиолдолд нүд, ам, хамартаа хүргэхгүй байх;

- Алхам 4. Нус, цэр, шүлсээ ил задгай хаяж болохгүй, харин цаасан алчуурт авч, хумин, таглаатай хогийн саванд хийх;
- Алхам 5. Ханиаж, найтаасан, нусаа нийсэн, хамраа цэвэрлэсэн, ухсан, шүлс, нус, цэрэнд хүрэлцсэн бол гараа заавал угаах, саван, ус байхгүй нөхцөлд хамгийн багадаа 60 хувийн спиртийн найрлагатай гар ариутгагч хэрэглэх.

Тав. Хэвийн горимд шилжүүлэх арга хэмжээ

5.1. Хүүхдэд сэтгэлийн хямралаа даван туулахад туслах:

1. Хөл хорио цуцлагдаж, хичээл эхэлсэн үед ч хүүхдүүд сэтгэл хямралын үед өөр, өөр хариу үйлдэл үзүүлсээр байж болно гэдгийг анхаарах хэрэгтэй. Унтаж чадахгүй байх, орондоо шээх, гэдэс эсвэл толгой өвдөх, санаа зовох, зожиг болох, уур уцаартай болох, гэртээ ганцаараа үлдэх дургүй байх, айх зэрэг нь түгээмэл хариу үйлдэл юм. Эдгээр хариу үйлдэлд эерэг байдлаар хандаж, энэ нь гарч болох хэвийн үйлдэл гэдгийг нь тайлбарлаж ойлгуулаарай. Хүүхдийн санаа зовж буй зүйлсийн талаар цаг гарган сонсож, тайвшруулж энхрийлэн, "аюулгүй байна" гэдгийг нь бататгаж, байнга магтаж байгаарай.
2. Боломжтой бол хүүхдэд тоглох, амрах боломжийг бүрдүүлээрэй. Хүүхдийг унтахаас өмнө аль болохоор тогтмол хийх зүйлс бүхий цагийн хуваарийг гаргах, шинэ орчинд шинэ зүйлийг бүтээхэд нь дэмжлэг үзүүлээрэй. Юу болж байгаа талаарх мэдээллийг хүүхдийн насны онцлогт нь тохируулан өгч, өөрийгөө болон бусдыг халдвараас хамгаалахын тулд тэд юу хийж чадахыг ойлгомжтой жишээгээр тайлбарлаарай.
3. Цаашид юу болж болох талаар сэтгэл санааг нь тайтгаруулсан зүйлсийг хэлж өгөөрэй. Жишээлбэл, Хүүхэд гэртээ эсвэл эмнэлэгт өвчтэй байгаа бол Та түүнд "Гэртээ эсвэл, эмнэлэгт байх нь чиний хувьд болон найзуудад чинь илүү аюулгүй тул чи гэртээ эсвэл, эмнэлэгт байгаа юм. Чамд энэ үед хэцүү, магадгүй айдастай эсвэл уйтгартай байгааг би мэдэж байгаа боловч бид өөрсдийгөө болон бусад хүмүүсийг аюулгүй байлгахын тулд дүрэм журмыг мөрдөх хэрэгтэй. Бүх юм удахгүй хэвийн байдалдаа эргэн орох болно" гэж хэлж болох юм.
4. Хичээл эхэлж, ангийн найз, багштайгаа уулзсанаар бидний амьдрал хэвийн байдалд орсон тул чи хөл хорионы өмнөх үед хичээлдээ хэрхэн чармайж байсан шигээ одоо дахин чармайх, ангийн бусад хүүхдүүдтэй улам эвтэй байх, цэцэрлэг, сургууль дээр баримтлах эрүүл мэндийн заавар зөвлөмжийг сайн мөрдөж биелүүлэх хэрэгтэй гэдгийг эцэг, эх, асран хамгаалагч, багш, ажилтнууд нэгэн ижил байр суурьтайгаар хүүхдүүдэд ойлгуулах хэрэгтэй.

5.2. Насны онцлогт тохирсон эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл, зөв дадал хэвшил төлөвшүүлэх:

Халдварт өвчнөөс сэргийлэх болон хариу арга хэмжээ авах, амьдрал, сургалтын үйл ажиллагааны хэвийн горимд хүүхдийг шилжүүлэхийн тулд сургалтын хөтөлбөр, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, орон нутгийн хэвлэл, мэдээллийн бодлого, гэр бүлийн нөхцөлд дараах агуулга, арга зүй бүхий үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Цэцэрлэгийн хүүхдэд:

- Ханиаж, найтаахдаа амаа гарын шууны дотор талаар таглах болон гараа тогтмол угаах зэрэг эрүүл ахуйн зан үйлд голчлон анхаарал хандуулах;
- Гараа 20 секундын турш угаах зан үйлийг сургахын тулд гараа угааж байх явцдаа дуу дуулуулах, хамтдаа угаах;
- Гар ариутгагчаар гараа ариутгах "дадлага" хийх;
- Гараа хэрхэн угааж байгааг нь хянах аргыг ашиглан гараа тогтмол/угаах шаардлагатай болсон үед угаасан хүүхдийг урамшуулах;
- Ханиах, найтаах, халуурах зэрэг шинж тэмдгүүдийг үзүүлж харуулах, хүүхдүүд бие нь таагүй байгаа үед (толгой өвдөх, гэдэс өвдөх, халуурах эсвэл их ядрах г.м.) багш болон аав, ээждээ хэлэх, өвдсөн хүнийг хэрхэн тайвшруулах, бусдын зовлонг ойлгох болон халамж тавихдаа аюулгүй байдлаар хандах зэргийг хүүхэлдэй, тоглоом ашиглан тайлбарлах;
- Хүүхдүүдийг өөр хооронд нь зайтай суулгах, гараа алдлах эсвэл 'жигүүрээ дэлгэх' дасгал хийхдээ найзууддаа хүрэхгүй байхаар зайтай байхыг сануулах.

2. Бага ангийн суралцагчдад:

- Хүүхдийн санаа зовсон зүйлийн талаар сонсох, тэдний асуултад насанд нь тохирсон байдлаар хариулах, тэднийг хэт их мэдээллээр дарахгүй байх;
- Сэтгэл хөдлөлөө илэрхийлэхийг хөхиүлэн дэмжих, сэтгэл хөдлөл нь өөр, өөр байдалтай байж болох ба энэ нь хэвийн зүйл гэдгийг тайлбарлаж ярилцах;
- Өөрсдийгөө болон бусдыг эрүүл байлгахын тулд олон зүйл хийж чадна гэдгийг онцлох;
- Найзуудаасаа хол зогсох, олон хүнтэй газар очихгүй байх, шаардлагагүй тохиолдолд хүмүүсийн биед хүрэхгүй байх нь өвчин тусах эрсдэлээс сэргийлнэ гэдгийг ойлгуулах;
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хянах талаарх үндсэн ойлголтыг мэдэж авахад нь туслах; халдвар хэрхэн тархаж болохыг жишээгээр үзүүлэх. Тухайлбал, ус цацагч саванд өнгөтэй ус хийгээд, хуудас цагаан цаас руу шүрших, усны дуслууд хэр хол явж байгааг ажиглах;
- Саван, ус ашиглан гараа 20 секунд угаах нь яагаад чухал болохыг харуулах;
- Суралцагчдын гар дээр гялалздаг бодис бага хэмжээгээр түрхээд, гараа зөвхөн усаар угаахыг хүсэх. Гялалздаг бодис хэр их үлдсэнийг асуугаад, дараа нь гараа саван, ус ашиглан 20 секунд угаахыг сануулах;
- Суралцагчдаар эрүүл ахуйн зөв зан үйлтэй холбоотой богино сэдэв уншуулах, түүнд дүгнэлт хийж өндөр эрсдэлтэй зан үйлийг тодорхойлуулж, эдгээрийг засах эерэг зан үйлийн талаар ярилцах. Жишээлбэл: "Сурагч Б. ханиадтай ч сургууль дээрээ иржээ. Тэр ханиаж

найтаахдаа амаа гараараа таглав. Дараа нь найзтайгаа гар барин мэндчилээд, гараа алчуураар арчсаны дараа ангидаа орж ирэв. Сурагч Б. эрсдэлтэй ямар зүйл хийсэн бэ? Үүний оронд юу хийх хэрэгтэй байсан бэ?" гэх зэрэг асуулт тавих;

3. Дунд ангийн суралцагчдад:

1. Бага ангид заасан агуулгыг сэргээн бататгаж насны онцлогт нь тохируулан дараах агуулгыг нэмж оруулах;
 - Сурагчдыг гэр бүлийнхэндээ эрүүл зан зүйл биечлэн сурталчилж чадна гэдгийг нь ойлгуулах;
 - Бусдыг эвгүй байдалд оруулахгүйгээр шаардлага тавих, санал бодлоо илэрхийлэх, асуудал дэвшүүлэх аргад суралцах үйлийг дэмжих;
 - Тэдэнд сэтгэл хөдлөл нь өөр, өөр байдалтай байж болох ба хөл хорио, эрсдэлтэй нөхцөл байдлын үед эдгээр нь хэвийн зүйл гэдэг талаар тайлбарлаж ярилцах, сэтгэл хөдлөлөө илэрхийлж байхыг хөхиүлэн дэмжих;
 - Суралцагчдын баг, бүлэг байгуулж нийгмийн эрүүл мэндийн тухай мэдээлэлтэй байнга танилцах, сургуулийн зарлал, мэдээллийн самбар болон зурагт хуудсаар дамжуулан бусдад түгээх, зөв үлгэр дууриал үзүүлэхийг дэмжих;
2. Эрүүл мэндийн боловсролын холбогдох агуулгыг бусад хичээлүүдтэй уялдуулах:
 - Байгалийн ухааны хичээлээр вирус, өвчний тархалт болон вакцинд хамрагдахын ач холбогдлыг судлах;
 - Нийгмийн ухааны хичээлээр халдварт өвчин, цартахлын түүх, нийгмийн эрүүл мэнд болон аюулгүй байдлын чиглэлээр баримтлах бодлогуудад гарсан өөрчлөлтийг судлах;
 - Монгол хэл бичиг, уран зохиолын хичээлээр суралцагчдын шүүмжлэлт болон бүтээлч сэтгэлгээ, харилцах чадвар, идэвхтэй байдлыг хөгжүүлэх;
 - Хими, физикийн хичээлээр цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн тухай судлах.

4. Ахлах ангийн суралцагчдад:

1. Бага, дунд ангид заасан агуулгыг сэргээн бататгаж, насны онцлогт нь тохируулан дараах агуулгыг нэмж оруулах;
 - Суралцагчдын санаа зовсон зүйлсийн талаар сонсож, тэдэнд тайлбар, зөвлөгөө өгөх;
 - Суралцагчид өөрсдийгөө болон бусдыг эрүүл байлгахын тулд их зүйл хийж чадна гэдгийг ойлгуулах, хамтдаа зарим үйл хийхийг дэмжих;
 - Олон хүнтэй газар очихгүй байх, шаардлагагүй тохиолдолд хүмүүсийн биед хүрэхгүй байх, найзуудаасаа хол зогсох нь өвчин тусах эрсдэлээс сэргийлнэ гэдгийг бусдад ойлгуулах, хэрэгжүүлэхийг уриалах, шаардлага тавих;

- Ханиаж найтаахдаа ам, хамраа гарын шууны дотор талаар таглах, гараа угаах зэрэг эрүүл ахуйн зөв зан үйл дээр онцлон анхаарал хандуулж хэрэгжүүлэх, бусдад ойлгуулах, хэрэгжүүлэхийг уриалах, шаардлага тавих;
 - Бусдыг эвгүй байдалд оруулахгүйгээр шаардлага тавих, санал бодлоо илэрхийлэх, асуудал дэвшүүлэх зан үйлийг хэвшил болгох;
 - Тэдэнд сэтгэл хөдлөл нь өөр, өөр байдалтай байж болох, хөл хорио, эрсдэлтэй нөхцөл байдлын үед эдгээр нь хэвийн зүйл гэдгийг тайлбарлаж ярилцах, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, тухайн үеийн нөхцөл байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, шийдэл, хувилбарыг ярилцах;
2. Эрүүл мэндийн боловсролын холбогдох агуулгыг бусад хичээлүүдтэй уялдуулан интеграц болон төсөлт хичээл, маргаан, мэтгэлцээн, хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулж сурагчдыг оролцуулах.

---000---

Хавсралт

**ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ОРЧНЫ ХАЛДВАРЫН ҮЕИЙН
БЭЛЭН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ АСУУМЖ**

Байгууллагын нэр:

№	Асуумж	Асуумжийн үнэлгээ (1, 2, 3, 4 онооны тохирохыг бичнэ)	Тайлбар (нөхцөл байдлын талаар тодорхой тэмдэглэл бичих)
1	Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан бие даасан орон тоогоор ажилладаг эсэх		
2	Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажилладаг (гэрээ, төлөвлөгөө г.м ямар арга хэлбэрээр ажилладаг болох) эсэх		
3	Хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт зохион байгуулалттай хамруулдаг эсэх		
4	Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэл, зайнаас халуун хэмжигч, халууны шил бэлэн байгаа эсэх		
5	Тусгай анхаарал халамж шаардлагатай хүүхдүүдэд эмнэлгийн тусламж үзүүлдэг эсэх		
6	Багш, ажилтанд халдварт болон томуу, томуу төст өвчний халдварын шинж тэмдэг илрэх байдал болон сэрэмжлүүлэх зурагт хуудас, санамж, анхааруулга, мэдээлэл өгдөг эсэх		
7	Халдварт өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлэх утасны дугаарыг шинэчилж, түүнийг ил тод байршуулсан эсэх		
8	Халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед түр тусгаарлах ор бүхий нөөц өрөөтэй эсэх		
9	Амны хаалт хэрэглэх, гарын эрүүл ахуй сахих, ханиаж найтаах үед амны алчуураар ам, хамраа дарах, гарын шуу, тохойгоор халхлах зэрэг санамж, сурталчилгаа хийдэг эсэх		
10	Хүүхдэд гарын эрүүл ахуй сахих талаар сургалт, сурталчилгаа хийдэг эсэх		
11	Гар угаах угаалтуурын тоо 1:20-оос багагүй байгаа эсэх /угаалтуурын тоо: хүүхдийн тоо /		

12	Гар угаах саван, гар халдваргүйжүүлэгч бодис ариун цэврийн байгууламжид тогтмол байдаг эсэх		
13	Хүүхэд бүр гар нүүрийн алчууртай эсхүл гар угаах байгууламжийн дэргэд гар хатаагч байршуулсан эсэх		
14	Анги, танхимд агаар сэлгэлт 2 цаг тутамд хийгддэг эсэх		
15	Анги танхим, өрөө тасалгааны хаалганы бариул, сандал, ширээ зэрэг хатуу биетийг өдөрт 3-аас доошгүй удаа цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийдэг эсэх		
16	Хүүхдийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнд 7 хоног бүр цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийгддэг эсэх		
17	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар, хүүхдийн аяга, тавагны ариутгал, халдваргүйтгэл хийгддэг эсэх		
18	Өрөө тасалгаа болон нийтийн эзэмшлийн талбайд чийгтэй цэвэрлэгээ өдөр бүр хийдэг эсэх		
19	Ариун цэврийн байгууламжийг өдөрт 2-оос доошгүй, бохирдсон тохиолдол бүрт цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийдэг эсэх		
20	Цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт		
Нийт оноо			

Тайлбар: Асуумж тус бүрд дараах оноо өгнө:

- 1 оноо-Шалгуурыг хангаж чадахгүй байгаа
- 2 оноо-Арга хэмжээ авах шийдвэр гарсан, хэрэгжилт эхлэлийн шатанд байгаа
- 3 оноо- Хэрэгжих шатанд явагдаж байгаа
- 4 оноо-Шалгуурыг бүрэн хангасан

Авсан нийт онооны нийлбэрийг гаргаж дараах үнэлгээ өгнө:

Авбал зохих нийт оноо 80 байна.

Их эрсдэлтэй: Авбал зохих нийт онооны 60-аас доош хувийг авсан

Эрсдэлтэй: Авбал зохих нийт онооны 60-79 хувийг авсан

Бага эрсдэлтэй: Авбал зохих нийт онооны 80 ба түүнээс дээш хувийн авсан

---000---



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/144

Улаанбаатар хот

Сургалтын бодлого батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дугаар заалт, Монгол хэлний тухай хуулийн 5.2, 5.3, 14.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.8, 3.2.10 дахь заалт, "Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-3", "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын II зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол хэлний сургалтын талаар баримтлах бодлогыг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан бодлогыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын, Нийслэлийн Боловсролын газрын, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн захирал, багш нарт тус тус даалгасугай.

3. Бодлогыг сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд тусгах, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Дээд боловсролын газар /Г.Батнэмэх/, Ерөнхий боловсролын газар /Т.Ням-Очир/, Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/ Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

My documents/Saidiin tushaal

142010526

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2020 оны ... 23 дугаар сарын ... 23 -ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, улс үндэстний оршин байх дархлаа болсон монгол хэл, бичиг, түүх, соёл, сэтгэлгээг Монгол Улс төр засгийн бодлого, үзэл баримтлалынхаа төвд байлган, тэдгээрийг өвлүүлэх, хөгжүүлэх, хадгалж хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсээр иржээ.

Монгол Улсын Үндсэн хуульд "Монголын ард түмэн бид ... төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, ... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" хэмээн тунхаглахын зэрэгцээ "Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн" гэж заасан.

Монгол хэлний тухай хуульд "Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн", "Монгол хэл, бичиг үсгийг эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн үүрэг мөн" хэмээн тус тус заажээ. Түүнчлэн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь "Монгол хэл, бичгийн соёлын өвийг хамгаалах, үндэсний бичгээрх оюуны өв сан, ардын аман зохиол болон монгол утга зохиолын судалгаа, сургалтыг өргөжүүлэх ажлыг боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх" үүрэгтэйг хуульчилжээ. Ерөнхий боловсролын сургуулийн хүлээх үүрэгт "Суралцагчдад монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын хичээлийг эрх бүхий байгууллагаас баталсан хөтөлбөр, агуулга, стандартын дагуу тасалдалгүй явуулах" хэмээн тусгасан байна.

Бага, дунд боловсролын тухай хуульд "Бага боловсролын агуулгаар суралцагчид эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж, бичиж сурах, суурь боловсролын агуулгаар эх хэлний зохих шатны мэдлэг эзэмших, бүрэн дунд боловсролын агуулгаар эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар эзэмшинэ" хэмээн заасан юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "... үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн. Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлнэ. Монгол хэл, бичгийн соёлоо хамгаалан хөгжүүлж, уламжлалт монгол бичгийн сургалт, хэрэглээг нэмэгдүүлнэ..." хэмээн заажээ.

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Суралцагчдыг эх хэлээрээ алдаагүй зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх хэрэглээний бүрэн ур чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн монгол хэлний сургалтын цогц шинэчлэлийг хэрэгжүүлнэ" гэсний сацуу "Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчлэх"-ийг эн тэргүүний зорилт болгон дэвшүүлсэн юм.

Монгол Улсын Засгийн Газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрт “Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичигт эх оронч үзэл, монгол ахуй, өв соёл, зан заншлын агуулга, арга зүйг тусган хэрэгжүүлэх, гэр бүлийн харилцаанд хүүхэд, залуучуудад эх орон, тусгаар тогтнолоороо бахархах, үндэсний соёл, зан заншлаа дээдлэн хүндлэх, газар нутаг, байгаль орчноо хайрлах үзэл, хүмүүжил төлөвшүүлэхэд эцэг эхчүүдийн үлгэр дуурайл, зөв хандлагыг дээшлүүлэх, айл өрх бүр угийн бичгийг хөтлөхөд арга зүйн дэмжлэг үзүүлэх” гэж нарийвчлан заасан байна.

Гэвч, монгол хэлний талаарх дээр дурдсан хууль, үзэл баримтлал, үйл ажиллагааны болон үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын түвшин хоёр зөрөөтэй байгааг зайлшгүй анхаарч үзэх шаардлага тулгарч байна.

Монголын багш нарын VII их хурлын тогтоолд “Сургалтын бодлогыг хүүхэд бүр монгол хэл, түүх, соёл, ёс заншил, өв уламжлалыг өвлөх, хөгжүүлэхэд чиглүүлэх, бүх шатны боловсролын байгууллага нь хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн төлөө үүрэг, хариуцлага хүлээдэг хууль, эрх зүйн орчин бий болгох, эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдийнхээ хөгжил, төлөвшил, хүмүүжил, хичээл сургалтад анхаарал хандуулж, сургууль, багшид дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах журамт үүргийг хуульчлах” хэмээн заасан бол Монголын багш нарын улсын II зөвлөгөөн, “Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр” үндэсний хэлэлцүүлэгт оролцогч ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нар нэгтгэн гаргасан зөвлөмждөө “Суралцагчдын унших чадварыг хөгжүүлэхэд анхаарах, тэдний заавал унших зохиолыг тодорхой зааж батлах, бага ангийн унших, үг хөгжлийн хичээлийг сэргээх, хүүхдийн ярих, цээжлэх чадварыг үнэлдэг болох, монгол хэл, уран зохиол, монголын түүхийн хичээлийн агуулгад үнэлгээ хийж, сургалтын чанарыг шинэ шатанд гаргах, монгол хэлний багш нарыг тодорхой хугацаанд мэргэжлийг нь тогтмол дээшлүүлэх, Боловсролын тухай хуульд “Монгол хэл, бичиг нь бүх нийтийн үйл хэрэг мөн” гэж нэмэлт оруулах ...” хэмээн тусгасан байна.

“Монгол хэл, бичгийн сургалтын цогц шинэчлэл” сэдэвт зөвлөгөөнд уригдан оролцсон Ардын болон гавьяат багш нар, ахмад эрдэмтэн, судлаачид “... Хүүхдүүд алдаагүй, зөв найруулан бичиж, санаа бодлоо цэгцтэй илэрхийлж сураагүйгээр үл барам монгол хэлний хичээлд сонирхолгүй болж байна. Бага ангид уншихын хичээл ордоггүйгээс хүүхдийн унших чадвар тааруу болж, төлөвшил, хүмүүжил нь доройтож байна. Зарим ном сурах бичгийн агуулга монгол ахуйгаас хол тасарч, харь үг хэллэг, зураг дүрслэлээр дүүрсэн нь уламжлалт сэтгэлгээ суулгах насанд сөргөөр нөлөөлж байх жишээтэй” гээд монгол хэлний сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгыг монголын түүх, соёлын агуулгатай болгох чиглэлээр тодорхой, үр өгөөжтэй санал санаачилгуудыг дэвшүүлж, нэн тэргүүнд сургалтын цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Эрдэмтэн, судлаачид ерөнхий боловсролын 10 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгасан нийт хичээлийн цагт монгол хэлний хичээлийн цагийн эзлэх хувь 17.4 байсан бол ерөнхий боловсролын сургууль 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжсэнээр 14.3 хувь болж буурсан гэдгийг онцоллоо. Мөн ерөнхий боловсролын 10 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөөний бага, дунд, ахлах ангийн хичээлүүдийн

нийт цагт монгол хэлний хичээлийн цагийн эзлэх хувь харгалзан бага ангид 34.1, дунд ангид 12.0, ахлах ангид 3.3 хувийг эзэлдэг байсныг сэргээх, монгол хэлний хичээлийг бага ангид дунджаар 13.5, дунд ангид 4.5, ахлах ангид 1 цаг судлахын дээр хэл зүй бага ангид 4.7, дунд ангид 4.5, ахлах ангид 1 цаг, бага ангид унших дунджаар 5.5, үг хөгжил 2, цэвэр бичиг 2 цаг, мөн яриа бичгийн дадлага хичээл ордог байсныг сэргээх нь маш чухал хэмээн үзжээ.

2019-2020 оны хичээлийн жилд хүчин төгөлдөр мөрдөж буй ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөний бага, дунд, ахлах ангийн хичээлүүдийн нийт цагт монгол хэлний хичээлийн цагийн эзлэх хувь харгалзан бага ангид 27.8, дунд ангид 6.3, ахлах ангид 2.7 байгаа юм.

Боловсролын үнэлгээний төвөөс 2017-2019 онд авсан монгол хэлний чанарын үнэлгээгээр 5 дугаар ангийн суралцагчдын гүйцэтгэл улсын хэмжээнд дунджаар 37%, 9, 12 дугаар ангийн суралцагчдын гүйцэтгэл тус тус 49%-тай шалгагджээ. Боловсролын үнэлгээний төвөөс 2017-2019 онд авсан их, дээд сургуульд элсэгчдийн монгол хэлний шалгалтаар шалгуулагчид улсын хэмжээнд дунджаар 52.4%-ийн гүйцэтгэлтэй шалгуулсан байна. Суралцагчдын гүйцэтгэл нь монгол хэл, бичгийн сургалтын чанар, үр өгөөж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангалттай биелүүлж чадахгүй байгааг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд боловсролын байгууллага, төрийн бус байгууллагаас сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хийсэн судалгаануудад суралцагчдын унших, бичих, сонсох, ярих чадварыг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх шаардлагатай гэж удаа дараа дүгнэсээр байна. Энэ дүгнэлт нь тус яаманд монгол хэл, бичгийн хичээлийн талаар иргэдээс ирүүлсэн санал, дүгнэлттэй нийцэж байгаа юм. Иймээс монгол хэл, бичгийн сургалтад онцгой анхаарах, тодорхой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Засгийн Газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III” болон энэхүү “Монгол хэлний сургалтын талаар баримтлах бодлого” нь дээрх хуулиудын хэрэгжилтийг хангах, монгол хэл, бичгийн сургалтын чанарыг дээшлүүлж, суралцагчдын эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагыг биелүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Хоёр. Сургалтын зорилго, зорилт

Монгол хэлний сургалтын зорилго нь монгол үндэстний хэл, бичгээ чанартай эзэмшиж, нийгмийн харилцаанд зөв, зохистой хэрэглэдэг, хэлнийхээ дархлаа, түүх, соёл, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлсээ эрхэмлэн дээдэлж, бахархдаг, хамгаалдаг монгол хүнийг төлөвшүүлэхэд оршино. Монгол хэлний сургалтын зорилгыг дараах зорилтуудаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол хэлний сургалтыг энэхүү бодлогын баримт бичигт нийцүүлэн, баяжуулан боловсруулсан сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлэх
- Монгол хэлний агуулгын түвшинг тогтоон стандартчилж, мөрдлөг болгох
- Суралцагчдын биет ба биет бус соёлын өвийн талаарх мэдлэгийг өргөжүүлж, бодит орчинд нь сурах боломж олгох
- Монгол хэлний сургалтын орчин болон багш бэлтгэх, мэргэжилтэнд тавих шаардлагыг боловсруулан баталгаажуулж, хэрэгжүүлэх

- Монгол хэл судлал, онолын, хавсарга хэл шинжлэлийн судалгааны үр дүн болон орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийн ололтыг сургалтад тогтмол нэвтрүүлэх
- Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагчид, эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэн, судлаачид, багш нар, иргэдийн оролцоог дэмжин, хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

Гурав. Сургалтын зарчим

Монгол хэлний сургалтад дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Монгол хэл, бичиг, түүх, соёл бол монгол хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, бусад хичээлийг судлах амин чухал үндэс суурь гэж үзэх
- Суралцагчдад монгол хэлний зүйн мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхийн дээр тэднийг уламжлалт сэтгэлгээтэй, эх оронч үзэлтэй монгол хүн болгон төлөвшүүлж, хөгжүүлэх
- Сургалтын агуулга нь монгол хэл, бичиг соёл, уран зохиол, түүх, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлсийг шингээсэн байх
- Сургалтын агуулга нь анги ахих тусам өргөсөн гүнзгийрч, залгамж холбоотой байх
- Сургалтын арга зүй нь дан ганц хэлний зүйн ойлголт ухагдахууныг заах биш, монгол хэл, бичгийн хэрэглээний чадвар, дадал эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэх
- Сургалт нь суралцагчийн эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцсэн, дэвшилтэт технологид суурилсан, биет ба биет бус соёлын өв, бодит орчинд түшиглэсэн, суралцагчийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн, чанартай, хүртээмжтэй, тасралтгүй байх
- Сургалтад орчин цагийн монголын утга зохиолын хэлний хэм хэмжээ, зөв бичих дүрэм, тогтоосон нэр томъёо, “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”, холбогдох бусад толь бичгийг хэрэглэх.

Дөрөв. Сургалтын агуулга

Монгол хэлний сургалтын агуулга нь хэлний зүйн үндсэн ойлголт, ухагдахуун, хэл ярих арга барил, монголын соёл, уран зохиол, түүх, өв уламжлал, зан заншилд илгүүрлана. Сургалтын агуулга нь монгол хэлний сургалтын зорилго, зорилт, зарчимд нийцэж, тэдгээрийг хэрэгжүүлэх үндэс суурийг бүрдүүлнэ. Сургалтын агуулгыг дараах аардлагад нийцүүлэн тогтооно. Үүнд:

- Монгол хэл, бичгийн сургалтын агуулгатай монголын түүх, бичиг соёл, уран зохиолын агуулгыг холбож, суралцагчдад өв уламжлал, зан заншлыг уг сургалтын агуулгаар дамжуулан эзэмшүүлнэ.
- Монгол хэл, бичиг үсэг, соёл, уран зохиол, түүх, өв уламжлал, зан заншлын агуулгыг суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн өргөсгөн гүнзгийрүүлж, залгамж холбоотой тогтооно.
- Сургалтын агуулга нь монгол хэлний хэрэглээ болон онолын тэнцвэрт харьцааг баримтална.
- Сургалтын агуулга нь суралцагчдын үгийн баялгийг нэмэгдүүлэх, бусдын санаа бодлыг сонсох, шинжлэх, найруулах, тайлбарлах, зохион бичих арга барил болон харилцан ярилцах чадварыг эзэмшихэд хөтөлнө.

- Боловсролын түвшин бүрийн сургалтын агуулга нь суралцагчдад монгол хэл, бичиг соёл, уламжлалт сэтгэлгээний дархлааг тогтоохуйц байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүдийн нийт цагт монгол хэлний хичээлийн эзлэх цагийг бага ангид 35, дунд ангид 20, ахлах ангид 10-аас доошгүй хувь байхаар тогтооно.
- Сургуулийн өмнөх боловсролын түвшинд сургалтын агуулга нь бусдыг анхааралтай, хичээнгүйлэн сонсох, бүтэн өгүүлбэрээр зөв ярих чадвартай, зөв харилцаа, хандлагатай монгол хүүхэд төлөвших үндэс суурийг бүрдүүлэхэд чиглэнэ.
- Бага боловсролын сургалтын агуулга нь суралцагчид бусдыг анхааралтай, хичээнгүйлэн сонсох, уншиж ойлгох, санаа бодлоо амаар болон бичгээр илэрхийлэх, зөв бичиж ярьж сурах, нэгнээ хүндэлж нөхөрсөг зөв харилцах, хэл, бичиг соёлоо дээдлэх, түүхээрээ бахархах хүмүүжил төлөвшилтэй болоход чиглэнэ.
- Суурь боловсролын сургалтын агуулга нь суралцагчид монгол хэлний зүйн болон эх судлалын үндсэн мэдлэг эзэмшиж, найруулгын алдаагүй, оновчтой хэрэглэх, санаа бодлоо нээлттэй илэрхийлэхийн зэрэгцээ, бусдын санаа бодлыг сонсох, ярилцах, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, хамтран ажиллах, харилцан суралцах, эв зөийг эрхэмлэх, бусадтай эелдэг зөөлөн харилцах, уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааны аргаас суралцах, хөдөлмөрлөх, бүтээх үйлд шамдах, чин сэтгэлээсээ хандаж сурахад чиглэнэ.
- Бүрэн дунд боловсролын агуулга нь суралцагчид албан баримт бичиг, ном товхимлын хэлний анхан шатны мэдлэг, чадвар эзэмшиж, хэрэглээний түвшинд болон цахим орчинд чадамгай ашиглах, хэлнийхээ баялаг, найруулгын яруу тансаг үнэ цэнг мэдэрч хэрэглэх, хойч үеийнхээ өмнө хэлний дархлааг хамгаалах үүрэг, хариуцлагаа гүн ухамсарлах, нийгэмд зүй зохистой амьдрах үндэс суурь болсон зөв үзэл бодол, хандлага төлөвших, оновчтой шийдвэр гаргах, бусдын төлөө хариуцлага хүлээх, асуудлыг олон талаас нь шинжлэх, ургуулан бодох, төсөөлөх, үнэлэх, дүгнэх, бусадтай хэлэлцэх, учир шалтгаанд үндэслэн тайлбарлах, мэтгэлцэх, үзэл бодлоо ойлгомжтой илэрхийлэх, түүнийгээ баталж нотолж чаддаг болоход чиглэнэ.
- Дээд боловсролын сургалтын агуулга нь суралцагчид орчин цагийн утга зохиолын хэлний хэм хэмжээг дагаж мөрддөг, хэл, бичиг соёлоо эрхэмлэн дээдэлж, нийгмийн өмнө эх хэлний дархлааг хамгаалах, өвлүүлэх, судлан шинжлэх, хөгжүүлэх, бусдад түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ариун үүргээ ухамсарласан, үлгэр жишээгээр биелүүлдэг иргэн болж хүмүүжиж төлөвшихөд чиглэнэ.

Монгол хэл, бичгийн сургалтын агуулгын талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Суралцагчдын монгол хэлний баялаг үгийн сангаас эзэмших хувь хэмжээ, бусдыг анхааралтай, хичээнгүйлэн сонсох, утга төгөлдөр найруулан бичих, ярих, ойлгож, шинжилж унших чадвар, хэл ярианы хөгжлийг боловсролын түвшин бүрээр болон нас, насаар нь тодорхойлж, хэлний агуулгын түвшинг тогтоож, стандартчилна.
- Бага ангийн суралцагчдын нас, сэтгэхүйд тохирсон, тэднийг хүмүүжүүлж төлөвшүүлэх агуулгатай “Унших бичиг, үг хөгжил” хичээлийг сэргээн судлуулна.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэлний агуулгын түвшин, суралцагчийн хөгжих хэрэгцээ, ялгаатай байдалд нийцүүлэн боловсруулж, баталгаажуулан үр дүн, чанарыг нь тогтмол үнэлж, хэрэгжүүлнэ.

- Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгыг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах, хөгжих хэрэгцээтэй уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ.
- Их, дээд сургуулиудын мэргэжлийн бус ангиудын монгол хэл, бичиг, найруулга зүйн сургалтын хөтөлбөрт үндэсний бичгийг нэмж тусган, судлах цагийг нэмэгдүүлнэ.

Монгол хэлний сургалт нь агуулгынхаа мөн чанараас хамаарч суралцагчдад монголын соёл, өв уламжлал, зан заншлыг төлөвшүүлэх үндсэн гол сургалт болно. Суралцагчид монголын түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг эзэмших нь зөвхөн уг сургалтын агуулгаар хязгаарлагдахгүй, монголын уран зохиол, түүх, иргэний ёс зүйн боловсрол зэрэг бусад сургалтын агуулгатай нягт уялдаа холбоотой байна.

Тав. Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь монгол хэлний сургалтын зорилго, зорилт, зарчим, агуулгад нийцэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Монгол хэл, бичгийн сургалтын арга зүй нь суралцагчдын нас, сэтгэхүйн болон танин мэдэхүйн онцлогийг харгалзсан, хөгжлийн онцлогоос үүдсэн ялгаатай байдлыг дэмжсэн, түүнд нийцсэн арга ашиглаж суралцах боломжийг нь адил тэгш хангасан, суралцагчдыг аль ч талаар ялгаварлан гадуурхахгүй байхад тулгуурлана.

Сургалтад суралцагчдын монгол хэл, бичиг, түүх, соёлоо сурч, хөгжих орчинг бүрдүүлсэн, тэдний эрэлт хэрэгцээ, оролцоог дэмжсэн, ил тод, нээлттэй, амьдралын хэрэглээтэй холбосон, сонирхолтой, бүтээлч арга зүйг ашиглана. Сургалтаар суралцагчдад өөрийн болон бусдын алдаанаас суралцах, бусадтай хамтарч ажиллангаа суралцах, сурч мэдсэнээ хамтдаа хэрэгжүүлэх боломж олгохуйц арга зүйг хэрэгжүүлнэ. Хичээл сургалт бол суралцагчдын баяр баясал, хүсэл тэмүүлэл байхаас гадна багшийн арга зүй суралцагчдад ойлгомжтой, тэдний хүсэл, сонирхолд нийцсэн, үр өгөөжтэй байна.

Монгол хэл, бичгийн сургалт нь хэлний зүйн дүрмийг тоочих, зааварлах биш, суралцагчдад өөрийгөө дайчлан хэлний мэдлэг, чадвар эзэмших арга ухаанд суралцах түүнийг өөрөө болон хамтран бүтээх, улмаар дадуулан хэвшүүлэх, эзэмшсэн мэдлэг, чадвараа насан туршдаа хэрэглэх таатай орчин, нөхцөл боломжийг бүрдүүлж өгнө. Өдөр тутмын, цаашлаад нийгмийн амьдралд оролцох эхлэл хэмээн үзэж суралцагч бүр хичээлд идэвхтэй оролцож, санаа бодлоо бусадтай хуваалцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Үлгэр, түүх, эх бичвэр, үзэгдэл, тохиолдлын жишээнүүд, шүлэг, өгүүллэгүүд нь суралцагчдыг эргэцүүлэн бодоход хөтөлж, бусдын үзэл бодлыг ойлгох, тайлбарлах, мэтгэлцэх, шийдвэр гаргаж сурахад туслахын дээр хүмүүжүүлж төлөвшүүлэхэд чиглэнэ. Монгол хэлний сургалтыг эхэд тулгуурлан, эхийг унших, цээжлэх, найруулах, тайлбарлах, эх зохиох ажлыг гүйцэтгүүлэхдээ тоочих ба эргэцүүлэх, тайлбарлах ба зохиох аргаар аман ба бичгийн хэлд сургахыг эрхэмлэнэ.

Зургаа. Сургалтын орчин

Сургалтын орчин нь монгол хэлний сургалтын зорилго, зорилт, зарчим, агуулга, арга зүйд нийцэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Монгол хэл, бичгийн сургалтыг суралцагчид уг сургалтаар дэвшүүлсэн зорилгыг бүрэн гүйцэд эзэмшихүйц цаг, багш, санхүүгийн нөөц бүхий орчинд явуулна.

Монгол хэл, бичгийн сургалтын орчинд тавигдах шаардлагыг боловсруулж, баталгаажуулан, үр дүнг тогтмол үнэлж, цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгож, тогтвортой мөрдөнө. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн нь суралцагчид ашиглахад энгийн бүтэцтэй, хэл найруулга ойлгомжтой байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн суралцагчдын хичээлээс гадуур заавал унших болон сонгож унших номын жагсаалтыг анги бүрээр тодорхой зааж, баталгаажуулан сургалтад ашиглана. Суралцагчид дунд ангиас эхлэн монголын аман болон бичгийн уран зохиолыг бүтэн эхээр нь судална.

Суралцагчдын хэрэгцээ, нас, сэтгэхүйн онцлогт тохирсон уламжлалт сэтгэлгээ, хэл яриаг хөгжүүлэх эх, цахим сурах бичиг, багшийн заах арга, ур чадварыг хөгжүүлэх багшийн ном, арга зүйн гарын авлага, тэргүүн туршлага, бүтээлийн цахим сантай байна.

Монгол хэл, бичгийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн мэдээллийн сантай байна. Нэгдсэн мэдээллийн санд тулгуурлан үгсийн ба эхийн сан бүрдүүлэн, хэлний сургалтын хэрэглэгдэхүүнийг бий болгож, түүнийг тогтмол сайжруулж, ашигладаг байна.

Суралцагчдад монгол хэл, бичгийн сургалтын орчны шаардлага хангасан хэрэглээний орчинд суралцах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, асуудал шийдвэрлэх, бусадтай хамтран ажиллах, харилцах, мэтгэлцэх, шинэ орчин нөхцөлд дасан зохицоход инновац, дижитал шилжилтүүд, хиймэл оюун ухааны ололтуудыг монгол хэл, бичгийн хөгжил, түүх, соёлын үнэт зүйлстэй нягт уялдуулан ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Монгол хэл, бичгийн сургалтын орчин бүрдүүлэхэд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангид монгол хэл, бичгийн хичээлийг дэд бүлгээр зохион байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх
- Ерөнхий боловсролын сургууль дээр монгол хэл, бичиг, уран зохиол, түүхийн сургалтын төв, сонгон, дугуйлан хичээллүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, санхүүжилтийг шийдвэрлэх
- Багш бэлтгэдэг өмчийн бүх хэлбэрийн их, дээд сургуулиудад монгол хэл, бичиг, уран зохиол, түүхийн хичээлийг заавал судлах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлэх
- Багш нарт зориулсан монгол хэл, бичиг, уран зохиол, түүхийн хичээлийг нягт уялдуулан заах арга зүйн зөвлөмж боловсруулж, хэрэглэх
- Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх "Багшийн ном" боловсруулж, ашиглах
- Сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, уран зохиол, сэтгүүл зүй, нийгмийн ажилтны чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэл, бичгийн шалгалтын агуулгын хүрээг тогтоож, тусгай журам боловсруулж, хэрэгжүүлэх

- Монгол хэл, бичиг, уран зохиол, түүхийн сургалтын орчин бүрдүүлэхэд санаачилга гарган үр дүнтэй ажилласан ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төв, их, дээд сургуулийн багшийг урамшуулах, дэмжих эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлэх
- Бүх шатны сургуулийн номын сан, хөмрөгийг үндэсний бичгээр хэвлэгдсэн бүтээл, монголын түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншил нэвт шингэсэн, суралцагчдад эх оронч үзэл, ёс суртахууны хүмүүжил, төлөвшил олгох ном, сонгодог бичгийн дурсгал, эртний уран зохиолын яруу тансаг найруулгатай зохиолоор баяжуулах, төсөв хөрөнгө шийдэж, санхүүжүүлэх
- Монгол хэл, бичиг, түүх, соёл, өв уламжлал, зан заншилд тулгуурлан монгол хүүхдийн үлгэрлэн дуурайх үндэсний баатрын дүрийг бүтээх, уг баатрын үйл хэргийг үзүүлсэн хүүхэлдэйн кино, жүжиг, уран сайхны кино хийж, зурагтаар нэвтрүүлэх
- Бүх нийтийн монгол хэл, бичгийн унших, бичих, ярих, сонсох чадварын түвшинг тогтоож, стандартчилах, жигдлэх
- Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III болон монгол хэл, бичгийн сургалтын үнэ цэн, хэрэглээ, хэлний дархлаа, эртний түүхэн сурвалж, ховор, хуучин ном, уран зохиолын талаар олон нийтэд ухуулан таниулах, судлуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах, сурталчлах ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
- Суралцагчдыг монгол хэл, бичиг, түүх, соёлд тулгуурлан хүмүүжүүлж төлөвшүүлэх үйл явцад эцэг эхийн хүлээх үүргийг тодорхойлж, тэдний оролцоог хангах эрх зүйн орчин бүрдүүлэх, эцэг эхчүүдийн үндэсний зөвлөгөөн зохион байгуулдаг байх
- Хилийн чанад дахь монгол хүүхэд багачууд, иргэдэд монгол хэл, бичиг соёл, түүх, өв уламжлал, зан заншлын мэдлэг, чадвар эзэмших эрх зүйн орчин бүрдүүлэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, түүний хэрэгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, багшаар хангах, суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг бичгээр баримтжуулж, баталгаажуулах
- Боловсролын хүрээлэнд монгол хэл, бичиг, түүх, соёл, уран зохиолын сургалт хариуцсан нэгжийг шинээр байгуулж, ажиллуулах
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэлдэхүүнд монгол хэл, бичиг, уран зохиол, түүхийн сургалтын бодлого, хэрэгжилт хариуцсан орон тооны мэргэжилтэн ажиллуулах
- Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангиудад монгол хэлний улсын олимпиад болон “Үндэсний хэл, соёл” агуулгын хүрээнд уралдаан, тэмцээн тогтмол зохион байгуулах
- Аймаг орон нутагт монгол хэл, бичгийн музей, галерей, хэл, соёлын төв байгуулах
- “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-т монгол бичгээр хэвлүүлэхээр заасан сурах бичгүүдийг монгол бичигт хөрвүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Монгол хэлний сургалтын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах үйл ажиллагааны зардлыг улс, орон нутгийн төсөвт жил бүр тусгахаас гадна олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив тусламж болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх
- Монгол хэл, бичгийн сургалтын талаар баримтлах бодлогыг төр болон төрийн бус боловсрол, соёл урлаг, хэвлэл мэдээллийн байгууллага, эрдэмтэн судлаач, шинжээч, гэр бүл, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлэх

Долоо. Сургалтын үнэлгээ

Сургалтын үнэлгээ нь монгол хэлний сургалтын зорилго, зорилт, зарчим, агуулга, арга зүй, сурах бичиг, сургалтын орчинд нийцсэн, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Сургалтын үнэлгээ нь суралцагчдад монгол хэл, бичиг, түүх, соёл, өв уламжлал, зан заншлын мэдлэг, чадвар, дадал төлөвшиж буй үйл явцын өөрчлөлт, түүний ахиц амжилтыг үнэлж, зөвлөн тусална.

Суралцагчдын мэдлэг, чадвар, дадлыг тогтоох үнэлгээний шалгуур, аргачлалыг хянан сайжруулж, сургалтын чанар, үр дүнг эцэг эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломж бүрдүүлнэ.

Сургалтын үнэлгээ нь өөрийн болон хөндлөнгийн гэсэн үндсэн хэлбэртэй байх бөгөөд эдгээрийн тэнцвэрт харьцааг баримтална. Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг нэгэн адил шалгуураар хийх бөгөөд сургалтын агуулгад нийцсэн үнэлгээний даалгавар боловсруулна. Суралцагчдын үгийн баялаг, ярих, цээжлэх чадвар, харилцаа хандлагыг илрүүлэх даалгаврын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. Аль ч үнэлгээний үр дүнг суралцагчид, эцэг эхэд зөвлөн туслах, багшийн мэргэжил, арга зүйг хөгжүүлэх үндсэн мэдээлэл болгон ашиглана.

Их, дээд сургуулийн мэргэжлийн бус ангиудын монгол хэл, бичиг, найруулга зүйн сургалтаар суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлын түвшинг тогтоох шалгалт авч, дүнг баталгаажуулна. Багш нар сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлнэ. Монгол хэлний сургалтын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, монгол хэлний сургалтын чанар, үр дүнг тогтмол нэмэгдүүлнэ.

Найм. Сургалтын хэлбэр, зохион байгуулалт

Сургалтын хэлбэр, зохион байгуулалт нь монгол хэлний сургалтын зорилго, зорилт, зарчим, агуулга, арга зүй, орчин, үнэлгээнд нийцэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Монгол хэл, бичгийн сургалт нь тухайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хичээл, хичээлийн бус үйл ажиллагаа гэсэн үндсэн хэлбэртэй байна. Хичээлийг сургалтын төлөвлөгөөнд тогтоосон хугацаанд зориулалтын анги танхимд, суралцагчдын сурах үйлийн онцлогоос үүдсэн ялгаатай байдлыг хүндэтгэж, хот, хөдөөгийн сургуулийн орчин нөхцөл зэргийг харгалзан зохион байгуулна. Дунд, ахлах ангийн хичээлийг дэд бүлгээр зохион байгуулна. Хичээл, хичээлийн бус үйл ажиллагааг тухайн цаг үеийн суралцагчийн эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцсэн хэлбэрээр явуулна.

Суралцагчид монгол хэл, бичиг, түүх, соёл, өв уламжлал, зан заншлаа эзэмших хичээлийн болон хичээлийн бус үйл ажиллагааг монгол соёл, ахуй, амьдралын бодит орчинд ажил хөдөлмөртэй уялдуулан зохион байгуулахаас гадна музей, кино, номын сан, архив зэрэг баримтат өвийг хадгалан хамгаалж буй байгууллагуудтай хамтран бүх талын оролцоог ханган зохион байгуулна.

Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь эцэг эх, асран хамгаалагчдад монгол хэл, бичгийн сургалтыг танилцуулах зөвлөгөө, санал, туршлага солилцох ярилцлага, нэгдмэл ойлголт хандлага тогтоох арга хэмжээг боломжит бүхий л хэлбэрээр зохион байгуулна.

Ерөнхий боловсролын сургууль дээр суралцагч бүрийн авьяас, чадвар, сонирхлыг харгалзан дунд, ахлах ангид сургалтын хөтөлбөрийг өргөсгөн гүнзгийрүүлсэн агуулгаар монгол хэл, бичиг соёл, түүх, уран зохиолын сургалтын төв, сонгон, дугуйлан хичээллүүлнэ.

Ес. Сургалт зохион байгуулах багшлах боловсон хүчин

Их, дээд сургуулиудад энэхүү бодлогын баримт бичигт нийцүүлэн боловсруулсан сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд, дээд боловсролын монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхүйц багшлах боловсон хүчин бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулан, хэрэгжилтийг хянаж, дэмжлэг үзүүлнэ.

Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс монгол хэл, бичиг, уран зохиолын багш болох хүсэл сонирхолтой, өндөр оноотой суралцагчийг багш бэлтгэх их, дээд сургуульд элсүүлэх, төрийн зардлаар сургах, бусад зээл, тэтгэлэгт хамруулахаас эхлүүлээд төгсөгчдийг ажлын байраар хангах, багшийн үнэлэмжийг өндөрсгөн, цалин, нийгмийн баталгаагаар хангах асуудлыг шийдвэрлэх зэргээр чанартай багш бэлтгэх эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлнэ.

Багш бэлтгэх сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг монгол хэл, соёл, түүх, өв уламжлал, зан заншил, үнэт зүйлсээр баяжуулан, хэлний агуулгын түвшинд нийцүүлэн сайжруулна.

Багш бүрийг арга зүйгээ хөгжүүлэх цахим сургалтын болон бусад шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангана. Багшийн ур чадварыг ажлын байрандаа тасралтгүй дээшлүүлэх тогтолцоотой байна. Монгол хэл, бичгийн сургалтын хөтөлбөр, сурах бичиг зохиогчид, мэргэшсэн судлаач, эрдэмтдийн төлөөлөл бүхий зөвлөл байгуулан багш нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Багш бэлтгэх их сургуулийг түшиглэсэн багш хөгжүүлэх сургалт, судалгааны төвтэй байна. Багшийг монгол хэл, бичиг, уран зохиол, соёл, түүхийн асуудлаар судалгааны ажил хийхийг дэмжинэ.

Багш нарт суралцагчдын сурлагын амжилтын ахисан түвшин, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг харгалзан нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгоно. Монгол хэлний чанартай сургалт явуулж буй багш нарыг урамшуулах, бүтээлч арга туршлагыг нь судлах, илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. Монгол хэл, бичгийн багш нарын бүсийн зөвлөгөөнийг 2 жил тутамд, улсын зөвлөгөөнийг 4 жил тутам зохион байгуулна.

Арав. Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Монгол хэлний сургалтын талаар баримтлах энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүн, үнэлгээний даалгаврын чанар, хүртээмж, хэрэгжилт, монголын утга зохиолын хэлний хэм хэмжээг мөрдөж буй байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад хэлээр сургалт явуулдаг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн суралцагчдын монгол хэлний зүйн мэдлэг ойлголт, чадварын түвшинг тогтоож, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль (төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг болон гадаад хэл заах тусгай зөвшөөрөл бүхий цэцэрлэг, сургууль багтана), насан туршийн боловсролын төв, их, дээд сургууль, коллежийн багш нараас монгол хэл, бичгээр унших, бичих, ярих, сонсох чадварын түвшин тогтоох шалгалт авч, нэгтгэн дүгнэх, мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, тогтмол давтан сургах, мэргэшүүлэх
- Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй монгол хэл, бичиг, уран зохиол, монголын түүхийн багш нарын монгол хэл, бичгийн мэдлэг, чадварын түвшинг тэдний төгссөн их, дээд сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиол, түүхийн сургалтын хөтөлбөрийн түвшинд шинжилж, дүгнэх
- Өмчийн бүх хэлбэрийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын монгол хэл, бичиг, уран зохиол, түүхийн хичээлийг улсын хэмжээнд мөрдөж буй сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж буй эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, заавал мөрдүүлэх арга хэмжээ авах
- Бүх нийтийн монгол хэлний хэрэглээ, хандлага, үнэлэмжийн судалгаа хийж цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл, арга замыг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
- Монгол хэл, бичгийн сургалтын зорилго, агуулгыг энэхүү монгол хэлний сургалтын талаар баримтлах бодлогод нийцүүлэн тодорхойлох, арга зүйг шинэчлэх эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, чуулга уулзалт зохион байгуулж, дүгнэх
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төв, их, дээд сургуулийн суралцагчдын үгийн сан, унших, бичих, ярих, сонсох чадвар, хэл ярианы хөгжлийн түвшинг нас, насаар нь тогтоож, үр дүнг монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад тусгах
- Монгол хэлний сургалтын талаар баримтлах энэхүү бодлогод нийцүүлэн боловсролын бүх түвшний сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг цогцоор нь баяжуулан шинэчилж, хэрэгжүүлэх
- Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан “Багшийн ном” зохиох
- Бага ангид үздэг байсан “Унших бичиг, үг хөгжил” хичээлийг сэргээн, хэрэгжүүлэх, сурах бичиг, цахим хэрэглэгдэхүүн, багшийн ном зохиох.



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/152

Улаанбаатар хот

Нийтлэг шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү нийтлэг шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэгчдэд үүрэг болгосугай.
3. "Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Нийтлэг шаардлагын хэрэгжилтэд жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД

Е.БААТАРБИЛЭГ



D:alban bichig/tushaal

142010446

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2020 оны 03 дугаар сарын 27-ны
өдрийн А.1862 тоот тушаалын хавсралт

ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сургууль болон сургуулиас гадуурх сургалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд энэхүү нийтлэг шаардлагыг мөрдлөг болгоно.

1.2. “Өдөр өнжүүлэх үйлчилгээ” гэж Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.19-д заасныг ойлгоно.

1.3. Өдөр өнжүүлэх үйлчилгээнд Боловсролын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хүүхэд хамгааллын жишиг бодлого” болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгон ажиллана.

1.4. Өдөр өнжүүлэх үйлчилгээг аливаа шашин, улс төрийн үйл ажиллагаанаас ангид зохион байгуулна.

Хоёр. Ерөнхий шаардлага

2.1. Өдөр өнжүүлэх үйлчилгээ явагдаж буй байршлыг тодорхой зааж, төрийн албан ёсны хэлээр бичсэн хаягыг барилга, байгууламжийн гадна талд байршуулсан байна.

2.2. Шинээр өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээд энэхүү нийтлэг шаардлагыг хангаж байгаа эсэхэд аймаг, дүүргийн Засаг даргын байгуулсан боловсрол, мэргэжлийн хяналт, онцгой байдал, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсэг урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана.

2.3. Ажлын хэсгийн дүгнэлтийг аймаг, нийслэлийн дүүргийн Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлөөр хэлэлцэн өдөр өнжүүлэх үйлчилгээ зохион байгуулахыг дэмжих эсэх талаар шийдвэр гаргана.

2.4. Өдөр өнжүүлэх үйлчилгээ зохион байгуулах иргэн, байгууллага үйлчилгээ явуулах харъяалах нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын сургуульд хандаж хамтран ажиллах санамж бичиг байгуулна.

2.5. Өдөр өнжүүлэх үйлчилгээнд хичээлийн бус цагаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу хамруулна.

2.6. Өдөр өнжүүлэх үйлчилгээг хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай харилцан тохиролцож үйлдсэн гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

2.7. Өдөр өнжүүлэх үйлчилгээ нь бүлгийн зохион байгуулалттай байх бөгөөд нэг бүлэгт арван тав хүртэл хүүхэд байна.

2.8. Өдөр өнжүүлэх бүлэг хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн дараах үйл ажиллагааг дангаар эсвэл хэсэгчлэн зохион байгуулна.

- ном унших, уншиж ойлгох чадварыг сайжруулах
- уламжлалаа дээдэлж, монгол ёс заншлаас суралцах
- авьяас, бие бялдрын хөгжлийг дэмжих
- гэрийн даалгавар хийхэд дэмжлэг үзүүлэх

2.9. Бүлэг бүр багш, багшийн туслах ажилтантай байна.

2.10. Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэгч нь багш, ажилтан тус бүрийн чиг үүрэг, хариуцлага, хүүхдийн аюулгүй байдлыг хангах заавар болон хүүхдийн тоглох, амрах, хичээллэх өдрийн дэглэм, цагийн хуваарийг баталж мөрдүүлнэ.

2.11. Хүүхдийг сургуульд хүргэх, хүлээн авах хуваарь болон хоол, хүнс, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих асуудлыг эцэг эх, асран хамгаалагчтай харилцан тохиролцож, гэрээнд тусгана.

2.12. Өдөр өнжүүлэх үйлчилгээний багшийн туслах ажилтан хүүхдийг хичээлд хүргэх, авахдаа анги удирдсан багшид хүлээлгэн өгч, хичээлийн дараа хүлээн авна.

2.13. Өдөр өнжүүлэх үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн бүртгэл, мэдээллийг бүлгийн багш тогтмол хөтөлж, сургуульд мэдээлнэ.

Гурав. Тусгай шаардлага

А. Орчинд тавих шаардлага

3.1. Өдөр өнжүүлэх үйлчилгээ явуулах байр, өрөө тасалгаа нь дараах шаардлагыг хангасан байна.

3.1.1. Өдөр өнжүүлэх үйлчилгээний өрөө, тасалгаа нь барилга байгууламжийн 3 хүртэлх давхарт байрласан байна. Зоорийн давхарт /B1 давхар/ өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

3.1.2. Өдөр өнжүүлэх бүлэг бүр хүүхэд амрах тоглох, хичээллэх, хооллох өрөө, ариун цэврийн өрөө, хувцас солих хэсэгтэй байна.

3.1.3. Өрөө тасалгааны нийт талбайн нэг хүүхдэд ногдох хэмжээ нь 5м²-аас багагүй байна.

3.1.4. Хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн ном, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, хичээл давтах, хооллох ширээ, сандал, хувцасны өлгүүр, шүүгээтэй байна.

3.1.5. Өрөө тасалгааны тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хөдөлгөөнгүй, тогтвортой байрлуулж, хүүхэд бэртэх, гэмтэхээс урьдчилан сэргийлсэн, аюулгүй байдлыг хангасан байна.

3.1.6. Өдөр өнжүүлэх үйлчилгээний өрөө, тасалгаа бүр нь камерын бүрэн хяналтад байх бөгөөд камер нь бүрэн ажиллагаатай, бичлэгийг 1 сараас доошгүй хугацаанд хадгална.

3.1.7. Өдөр өнжүүлэх үйлчилгээг зохион байгуулах өрөө тасалгаа нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулалтын системтэй байна.

3.1.8. Өрөө, тасалгааны агаарын хэм 18-22⁰C, агаарын хэвийн солилцоог хангах ердийн болон механик салхивчтай, харьцангуй чийгшил 40-60 хувь байна.

3.1.9. Өрөө, тасалгааны ханын дээд хэсэг, тааз нь цагаан, бусад хэсэг нь цайвар өнгөтэй байна.

3.1.10. Ариун цэврийн өрөө нь хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон суултуур, гар угаагууртай байх бөгөөд байнгын бүрэн ажиллагаатай байна. Ажилтнуудад зориулсан тусдаа суултуур, ариун цэврийн өрөөтэй байна.

3.1.11. Гадна бие засах газар, хэсгийн бохир ус зайлуулах системтэй тохиолдолд “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага. MNS 5924” стандартын шардлагыг хангасан байна.

3.1.12. Ундны усны чанар, аюулгүй байдалд хагас жилд 1 удаа мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулна.

3.1.13. Зөөврийн усан хангамжтай тохиолдолд ундны ус зөөх, хадгалах сав нь хүнсний зориулалтын, угааж цэвэрлэхэд хялбар байх ба ундны усны савыг 7 хоногт 1-2 удаа бүрэн суллаж, угааж, халдваргүйжүүлнэ.

3.1.14. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг шинжилгээ баталгаажилттай, батлагдсан бодисоор өдөр тутам зааврын дагуу хийнэ.

3.1.15. Цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтэд хэрэглэж буй бодисыг хүүхдийн гар хүрэхгүй газарт байрлуулна.

3.1.16. Шавж, мэрэгч устгал болон халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж хийлгэнэ. Шавж, мэрэгч илэрсэн тохиолдолд тухай бүр устгал, халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.

Б. Үйлчилгээнд тавих шаардлага

3.2. Өдөр өнжүүлэх үйлчилгээ явуулахад хүүхдийн хоол, хүнсний аюулгүй байдлын дараах шаардлагыг хангасан байна.

3.2.1. Өдөр өнжүүлэх үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдэд эрүүл, шим тэжээллэг халуун хоол, цайгаар үйлчилнэ.

3.2.2. Хүүхдийн хоолны цэсийг эцэг эх, асран хамгаалагчийн саналыг үндэслэн 7 хоног тутамд боловсруулж, жор, технологийн дагуу хийнэ.

3.2.3. Хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүн нь гарал үүслийн бичигтэй, шинжилгээ баталгаажилттай, хаяг, шошго бүрэн бүтэн, стандартын шаардлага хангасан байна.

3.2.4. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шаардлага хангасан нөхцөлд тээвэрлэж, хадгална.

3.2.5. Нэг ээлжинд бэлтгэсэн бүх төрлийн хоол, хүнснээс 150 гр-аас багагүй дээжийг авч, ариутгасан саванд хийж битүүмжлэн хаяглаж, +4 хэмд 72 цагаас доошгүй хугацаанд хадгалж, устгах ба бүртгэл хөтөлнө.

3.2.6. Хүүхдийн хоол хүнсийг бэлтгэх тусгайлсан хэсэгтэй байх ба сав суулгыг тогтмол угааж цэвэрлэн аяга, таваг, халбага сэрээг тогтмол ариутгана.

В. Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах шаардлага

3.3. Өдөр өнжүүлэх үйлчилгээ явуулахад хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын дараах шаардлагыг хангасан байна.

3.3.1. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд өдөр өнжүүлэх бүлгийн багш жилд нэг удаа, багшийн туслах, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, боловсруулалт, түгээлтийн үйл ажиллагаанд оролцдог ажилтан, ажиллагсад 6 сар тутамд хамрагдана.

3.3.2. Өвчний шинж тэмдэг илэрсэн, хоолны хордлого, халдвар гарсан тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч, эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу авч хэрэгжүүлнэ.

3.3.3. Хүүхдэд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх анхны тусламжийн хайрцаг байх ба хэрэглэсэн тухай бүр бүртгэл хөтөлдөг байна.

3.3.4. Өрөө тасалгаанд өдөрт 1-ээс доошгүй удаа чийгтэй цэвэрлэгээ хийнэ.

3.3.5. Хүүхэд хүссэн үедээ ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлсэн байна.

3.3.6. Бие махбодын шийтгэл, сэтгэлзүйн болон үе тэнгийн дарамт, дээрэлхэлт гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.7. Хүүхдийг байнгын хараа хяналттай байлгана.

3.3.8. Өдөр өнжүүлэх үйлчилгээний өрөө, тасалгаанд хүн амьдрах, гадны хүн оруулахгүй байна.

Г. Хүний нөөцөд тавих шаардлага

3.4. Өдөр өнжүүлэх үйлчилгээ явуулах хүний нөөц нь дараах шаардлагыг хангасан байна.

3.4.1. Бүлгийн багш нь багш, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч мэргэжилтэй байх бөгөөд тухайн өдөр өнжүүлэх үйлчилгээний үндсэн ажилтан байна.

3.4.2. Өдөр өнжүүлэх үйлчилгээний багш, ажилтан нь сэтгэцийн болон халдварт өвчин эмгэггүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй байна.

3.4.3. Ерөнхий боловсролын сургуулийн багш өдөр өнжүүлэх бүлэгт цагаар хичээл заах тохиолдолд сургуулийн захирлын дэргэдэх зөвлөлийн зөвшөөрөлтэй байна.

3.4.4. Багшийн туслах болон ажилтнууд нь анхны тусламж үзүүлэх болон хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийг дэмжих арга зүйн мэдлэг, хүүхэдтэй ажиллах ур чадвартай байна.

3.4.5. Хүүхдийн хоол хүнсийг боловсруулах ажилтан нь хоол үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэшсэн байна.

3.4.6. Хоёроос дээш бүлэг хичээллэж буй тохиолдолд орон тооны мэргэжлийн тогооч, бэлтгэгч /угаагч/ ажиллана.

3.4.7. Багш, ажилтан нь хүүхдийн хувийн мэдээллийг чанд хадгална.

--000--



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 4 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар
хот

Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн танхимын сургалтын үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл зогсоох, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай:

1.1. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургууль, коллежийн суралцагчдад зориулан зохион байгуулж байгаа теле болон цахим хичээлийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх;

1.2. энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг төгсөгч, 2020-2021 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл бичгийн хичээлээр шалгалт авахгүй байх зохицуулалт хийх;

1.3. ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

2. Сургалтын үйл ажиллагааг зогсоосон хугацаанд боловсролын байгууллагын гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түлш халаалт зэрэг байр ашиглалттай холбоотой зардлыг хэмнэх зорилгоор шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шинэ коронавирүсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолын 5 дахь заалт, "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 64 дүгээр тогтоолын 2.1 дэх дэд заалт, "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Боловсрол, соёл, шинжлэх
ухаан, спортын сайд

УХА0064

У.ХҮРЭЛСҮХ

Ё.БААТАРБИЛЭГ



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/194

Улаанбаатар хот

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн
хичээл, сургалтын үйл ажиллагаанд
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 139 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөр дуусгавар болгосугай.

2. Хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг дуусгавар болгохтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох нэгж, байгууллагад даалгасугай:

2.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад зориулсан теле хичээлийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн зохион байгуулахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Ерөнхий боловсролын газар /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;

2.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2020 оны 4-5 дугаар сард цахим хэлбэрээр зохион байгуулахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;

2.3. Телевиз болон цахимаар зохион байгуулсан хичээлийг багшийн журналд тэмдэглэх заавар, 2020-2021 оны хичээлийн жилийн эхний сард өмнөх ангид судалсан байвал зохих агуулгыг бататгах арга зүйн зөвлөмж боловсруулж 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүргүүлэх арга хэмжээ авахыг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д.

3. Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1.Хичээлийн жилийг дуустал зохион байгуулах теле хичээл, цахим сургалтыг суралцагч бүрт хүрч буй эсэхэд хяналт тавьж, хариу арга хэмжээ авах;

3.2. Энэ тушаалын 2.3-т заасан арга зүйн зөвлөмжийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүргэж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;

3.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын даалгаврыг гүйцэтгэхэд гардаг нийтлэг алдааны талаар шалгалтад бэлтгэгчдэд заавар, зөвлөмж хүргэх;

142010698

3.4. Цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, багш нарын дунд 2020 онд зохион байгуулахаар төлөвлөсөн улсын чанартай бүх төрлийн олимпиад, уралдаан, тэмцээнийг цуцлах;

3.5. Ерөнхий боловсролын сургуулийн 9, 12 дугаар анги төгсөгчдөд боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх/ олгох ажлыг 2020 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн дотор холбогдох журмын дагуу зохион байгуулах;

3.6. Холбогдох журмын дагуу мэргэжлийн зэрэг олгох зохицуулалтыг 2020 оны 9 дүгээр сард хэрэгжүүлэх;

3.7. Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 2020-2021 оны хичээлийн жилд элсэн суралцах хүүхдийн суралцах бэлтгэлийг хангахад орон нутгийн удирдлага, цэцэрлэгийн эрхлэгч нарт чиглэл, зөвлөмж өгч, хамтран ажиллах;

3.8. Зуны сард зохион байгуулах сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт, сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхэд, залуучуудад боловсрол олгох сургалтыг түр зогсоох;

3.9. Энэ тушаалын 4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, багш нарт мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, мэдээлэл судалгааг тухай бүр гаргаж ажиллах.

4. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

4.1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг 100 хувь анги дэвшүүлэх, төгсгөх;

4.2. Анги дэвших болон улсын шалгалтын үнэлгээ /дүн/-г тооцоход Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/118 дугаар тушаалыг баримтлах;

4.3. Суралцагчийн жилийн эцсийн дүнг хагас жил /II улирал/-ийн үнэлгээ/хувь/, теле болон цахим хичээлийг судалсан байдлыг харгалзан багшийн өгсөн оноо/хувь/-ны нийлбэрээр тооцож, боловсролын салбарын мэдээллийн системд 2020 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн дотор оруулах;

4.3.1. Энэ тушаалын 4.3-т заасан жилийн эцсийн үнэлгээг гаргахад суралцагч техник, технологийн болон гэр бүлийн ялгаатай орчинд зайнаас суралцсан байдлыг харгалзах, сурлагын амжилтын өмнөх үнэлгээг бууруулахгүй байх зарчим баримтлан сурах үйлийг нь дэмжиж уян хатан хандах;

4.4. Ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангид үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй суралцагчийн тоонд хязгаарлалт тогтоохгүй байх;

4.5. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдардаг суралцагчийн эд зүйлс болон цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаар бэлтгүүлсэн сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгсэл, бусад зүйлсийг 2020 оны 4 дүгээр сард багтаан тус тус хүлээлгэн өгөх;

4.6. Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 2020-2021 оны хичээлийн жилд элсэн суралцах хүүхдийн суралцах бэлтгэлийг хангахад гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, сургуульд бэлтгэх гарын авлагыг цэцэрлэгээр дамжуулан хүргүүлэх, хамтран ажиллах;

4.7. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвийн багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгох, сунгах ажлыг 2020 оны 9 дүгээр сард зохион байгуулах;

4.8. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын амралтыг 2020 оны 6 дугаар сарын эхний 7 хоногт багтаан эхлүүлэх;

4.9. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль өөрийн санхүүжилт, нөөц боломжоо ашиглан хийх засвар, үйлчилгээг түр цуцлах;

4.10. Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдөөс бусад ангийн суралцагчийн хувийн хэрэг, сургуулийн номын сангаас авч ашиглаж байгаа сурах бичгийг буцаан төвлөрүүлэх, цэцэрлэгийн бүртгэл, суралцагч элсүүлэхтэй холбогдох үйл ажиллагааг 2020 оны 8 дугаар сарын хоёрдугаар хагаст зохион байгуулах.

5. Энэ тушаалын 2, 3-т заасан арга хэмжээний хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагаас тайлан авч, үр дүнг 2020 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газар /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/201

Улаанбаатар хот

Элсэлтийн тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28¹.1.6, 45.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн IX ангийг тухайн жил өдрөөр төгсөгчдөөс Х ангид элсүүлэх тоонд хязгаарлалт тогтоохгүйгээр хүсэлт гаргасан суралцагчийг үргэлжлүүлэн суралцуулж байхыг сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

2. Ерөнхий боловсролын 9 жилийн сургалттай сургуулийн IX анги төгсөгчийг Х ангид элсүүлэхтэй холбогдуулан хамран сургах тойрог тогтоож, мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын газар (Т.Ням-Очир)-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Элсэлтийг нэмэгдүүлэх тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 486 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

142010720



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/220

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 166 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулсугай.

2. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлага зохион байгуулахад мөрдөх зааврыг хавсралтаар баталсугай.

3. Сургуулийн орчинд давтлага зохион байгуулах хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Төлөвлөгөө удирдамж батлах тухай" 2020 оны А/140 дүгээр тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж"-ийг баримтлан ажилласугай.

4. Энэхүү тушаалын нэг дэх заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

4.1. Энэхүү тушаалын хоёрт заасан зааврыг эцэг эх, суралцагчдад урьдчилан хүргэж танилцуулах;

4.2. Дотуур байранд амьдарч байсан хүүхдийг давтлагад хамрагдах хугацаанд аюулгүй байдлыг хангаж, эрсдэлгүй байх нөхцөл бүрдүүлэх талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/508 дугаар тушаалаар баталсан гэрээний үлгэрчилсэн загварын дагуу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулж ажиллах;

4.3. Анги танхимын бэлэн байдлыг хангах ариутгал, халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

4.4. Багш, ажилчдад эрүүл ахуйн дэглэм баримтлах заавар зөвлөмж өгөх, цэвэрлэгээ үйлчилгээний багаж, тоног төхөөрөмжид ариутгал хийх;

4.5. Эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан зөвлөмжийг баримтлах;

D:alban bichig/tushaal

142010813

4.6. Багш, ажилтан, суралцагчтай холбоо барих утасны жагсаалт, тухайн өдөр хичээлийн байранд орсон, гарсан хүмүүсийг бүртгэх, суралцагчдын ирцийн мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн системд өдөр бүр оруулах;

5. Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга нарт дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

5.1. Давтлагад хамрагдах хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах талаар зааварт заасан хамгаалах хэрэгсэл түүнийг ашиглах заавар, санамжийг эцэг эх, асран хамгаалагчдад орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад арга хэлбэрээр шуурхай хүргэж, бэлэн байдлыг хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.2. Эрүүл мэнд, онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг тухай бүрд нь сургуулиудад шуурхай хүргүүлж, ажиллах;

5.3. Давтлага зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байдал, зааврыг сургуулийн удирдлага, багш, ажилтан, суралцагчид мөрдөн ажиллаж буй эсэхэд хяналт тавих;

5.4. Халдвар тархах эрсдэл үүссэн тохиолдолд давтлагыг зогсоож, орон нутгийн онцгой комисст мэдэгдэж, тус комиссоос гаргасан шийдвэрийг мөрдөж ажиллах.

6. Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх орчин нөхцөл бүрдүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд давтлагыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, суралцах орчны эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

7. Давтлагад хамрагдсан суралцагчийн ирцийн мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэж, 7 хоног бүр мэдээлж байхыг Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дүнжиннамдаг/-т үүрэг болгосугай.

8. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд Г.Ганбаярт даалгасугай.

САЙД  **Е.БААТАРБИЛЭГ**



D:alban bichig/tushaal

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2020 оны 12-р дугаар сарын 27-ны
өдрийн 27 дугаар тушаалын хавсралт

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТАД БЭЛТГЭХ ДАВТЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ЗААВАР

1. Коронавируст халдвар (COVID 19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хорио, хөдөлгөөний хязгаарлалтын үед ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг ерөнхий боловсролын сургуулийн орчинд зохион байгуулахад энэхүү зааврыг мөрдөнө.

2. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад сургуулийн удирдлага, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, албан хаагчид тодорхой үүрэг хүлээн бэлтгэлийг сайтар хангаж, халдвараас урьдчилан сэргийлсэн орчин нөхцөл бүрдүүлэн, тогтоосон дэгийг баримталж ажиллана.

3. Давтлагын нэг ээлжийн үргэлжлэх хугацаа нь сургалтын цагаар өдөрт 3 цагаас илүүгүй байх бөгөөд суралцагч шалгалт өгөхөөр сонгосон бүх хичээлээр давтлагад 5 хоногийн хугацаанд бүрэн хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

4. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахын өмнө дараах бэлтгэлийг заавал хангасан байна. Үүнд:

4.1. Эрүүл мэнд, онцгой байдлын болон мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг ил тод байршуулна.

4.2. Сургуулийн удирдлагын баг 12 дугаар ангийн суралцагчийн хүсэлтийг судлан сургалтад хамрагдах суралцагчдын тоог тодорхой болгосон байна.

4.3. Нэг танхимд 10-аас илүүгүй суралцагч байхаар тооцоолон анги танхимыг бэлтгэн, багшийн хичээлийн хуваарийг төлөвлөнө.

4.4. Нэг ширээнд нэг суралцагч суух, ширээ хоорондын зайг 1-1,5 метр байхаар ширээ сандлыг байрлуулна.

4.5. Мэргэжлийн байгууллагаас халдвар хамгаалал, эрүүл ахуйн заавар, зөвлөмж, сургалт авч, урьдчилсан тандалт хийх багаж хэрэгслийг бэлтгэнэ.

4.6. Сургууль орчмын бүсэд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийлгэж, шаардагдах ариутгалын бодисыг энэхүү сургалтын хугацаанд тасалдахгүй байхаар бэлтгэнэ.

4.7. Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага, ном сурах бичгийг бэлтгэнэ.

4.8. Багш сурагчид хичээллэх танхимд орох, гарахдаа нэг дор олноороо цугларахгүй байхаар зохицуулалт хийж, зураглал гаргана.

4.9. Сургалтын үйл ажиллагаанд оролцогчдоор тогтоосон дэгийг мөрдүүлэх, сургуулийн орчны хаана, хэзээ, хэн хяналт тавьж ажиллахыг тодорхой болгож, хуваарь гаргасан байна.

5. Халдвараас сэргийлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг заавал хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1. Давтлагад хамрагдах хугацаанд дотуур байранд хүүхэд байрлуулахгүй. Дотуур байранд амьдарч байсан хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлгүй байх нөхцөл бүрдүүлэхээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулж ажиллана.

5.2. Сургуулийн удирдлагын баг хариуцлагатай жижүүрийн горимоор ажиллана.

5.3. Багш, суралцагч, албан хаагчдыг амны хаалттай нэвтрүүлж, тэдний биеийн халууныг тогтмол хэмжин, тэмдэглэл хөтөлж, шаардлагатай тохиолдолд эмчийн үзлэгт хамруулна.

5.4. Сургууль орчмын бүсэд цэвэрлэгээ, ариутгалыг хуваарийн дагуу тогтмол хийж, гадны хүн нэвтрэх, хүн олноор цугларахгүй байх арга хэмжээ авна.

5.5. Сургууль, анги танхимд цэвэрлэгээ, ариутгалыг хуваарийн дагуу тогтмол хийж, орох, гарах хөдөлгөөнд хяналт тавьж, сургуулийн давхар бүрт хянагч ажиллуулна.

5.6. Сургуулийн нүхэн жорлон, ариун цэврийн өрөө, угаагуурт дараалал үүсгэхгүй байхаар зохицуулалт хийж, ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийнэ.

5.7. Ариун цэврийн өрөөнд саван, анги, танхимд спиртэн суурьтай гар ариутгагчийг байнга байлгана.

5.8. Анги, танхимд 40 минут тутамд 10-15 минутын агаар сэлгэлт хийнэ.

5.9. Ээлж хооронд анги танхимд цэвэрлэгээ, агаар сэлгэлт хийнэ.

5.10. Ширээ сандал, самбар, хичээлийн хэрэглэгдэхүүн, номын шүүгээ зэрэг хатуу гадаргууг ахуйн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор 2 цаг тутамд цэвэрлэгээ, ариутгал хийнэ.

5.11. Багш, суралцагчдыг халуун бүлээн ус, цай уух боломжийг бүрдүүлнэ. Багш, суралцагчид өөрсдийн аяга, савтай байх бөгөөд анги танхимд хооллохгүй.

5.12. Анги танхимд хувцсаа нэг дор өлгөхгүй, сэгсрэхгүй байх зохицуулалт хийнэ.

6. Давтлагын үед суралцагч дараах дэгийг баримтална. Үүнд:

6.1. Суралцагч нь зөвхөн хуваарьт давтлагад хамрагдана.

6.2. Суралцагч амны хаалттай байх бөгөөд сургуульд нэвтрэхдээ биеийн халуунаа хэмжүүлнэ.

6.3. Анги танхимд хуваарилсан суудалд сууж хичээллэнэ.

6.4. Бал үзэг, цаас, ном дэвтэр, утас, таблет, notebook, флаш гэх мэт аливаа хэрэглэгдэхүүнийг бусдад дамжуулж хэрэглэхийг хориглоно.

6.5. Халуун бүлээн ус, шингэн уух зүйл бэлтгэн авч ирсэн тохиолдолд хоорондоо дамжуулан хэрэглэхгүй байна.

6.6. Бусадтай гар барих гэх мэтээр бусдын биед хүрэхгүй байна.

6.7. Бохирдол ихтэй зүйлст хүрсэн тохиолдолд заавал гараа угаах эсвэл ариутгалын бодисоор цэвэрлэнэ.

6.8. Завсарлагааны үеэр коридор, бие засах газарт бусадтайгаа 1-1,5 метрээс дотогш зайд ойртож харилцахгүй байна.

6.9. Биед ямар нэг өвчний зовуурь, шинж тэмдэг (халуурах, ханиалгах, амьсгалахад төвөгтэй болох, суулгах, бөөлжих гэх мэт) илэрсэн тохиолдолд сургууль дээр ирэлгүй, багшдаа мэдэгдэж, эрүүл мэндийн байгууллагад хандана.

6.10. "Гэр-сургууль-гэр" маршрутын дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтална.

7. Сургуулийн удирдлага, багш, албан хаагчид, эцэг эх, асран хамгаалагчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

7.1. Давтлага зохион байгуулах үйл ажиллагаанд оролцогчид бүгд амны хаалт зүүж, гараа ариутгана. Бусадтайгаа 1-1,5 метрээс дотогш зайд ойртож харилцахгүй байна.

7.2. Хариуцлагатай жижүүр өдөр тутмын тэмдэглэл хөтлөн, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлнэ.

7.3. Сургуулийн удирдлага, эмч нь гадаад, дотоод орчны цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавина. Мэргэжлийн байгууллагаас өгч буй заавар, зөвлөмжийг багш, суралцагч, албан хаагчдад мэдээлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.

7.4. Багш, албан хаагчид нь суралцагчид тогтоосон дэгийг баримталж буй байдал, тэдний биеийн эрүүл мэндэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сургуулийн эмчид мэдээлэл өгч ажиллана.

7.5. Суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдэдээ амны хаалт, гар ариутгагч, уух зүйл бэлтгэн өгч, өглөө, өдрийн хоол, цайг гэрт нь тогтмол уулгаж, дархлааг нь дэмжинэ. Хүүхдийнхээ биеийн байдлыг ажиглаж, өвдсөн шинж тэмдэг илэрсэн үед сургалтад явуулахгүй байх арга хэмжээ авна. Хүүхдийнхээ давтлагын цагийн хуваарьтай танилцаж, "Гэр-сургууль-гэр" маршрутыг мөрдүүлнэ.

7.6. Багш, албан хаагч, эцэг эх, асран хамгаалагчид нь мэргэжлийн байгууллагаас өгч буй халдвар, хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, суралцагчдад үлгэрлэнэ.

.....000.....



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/220

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 166 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулсугай.

2. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлага зохион байгуулахад мөрдөх зааврыг хавсралтаар баталсугай.

3. Сургуулийн орчинд давтлага зохион байгуулах хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Төлөвлөгөө удирдамж батлах тухай" 2020 оны А/140 дүгээр тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж"-ийг баримтлан ажилласугай.

4. Энэхүү тушаалын нэг дэх заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

4.1. Энэхүү тушаалын хоёрт заасан зааврыг эцэг эх, суралцагчдад урьдчилан хүргэж танилцуулах;

4.2. Дотуур байранд амьдарч байсан хүүхдийг давтлагад хамрагдах хугацаанд аюулгүй байдлыг хангаж, эрсдэлгүй байх нөхцөл бүрдүүлэх талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/508 дугаар тушаалаар баталсан гэрээний үлгэрчилсэн загварын дагуу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулж ажиллах;

4.3. Анги танхимын бэлэн байдлыг хангах ариутгал, халдваргүйтгэлийн мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

4.4. Багш, ажилчдад эрүүл ахуйн дэглэм баримтлах заавар зөвлөмж өгөх, цэвэрлэгээ үйлчилгээний багаж, тоног төхөөрөмжид ариутгал хийх;

4.5. Эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан зөвлөмжийг баримтлах;

D:alban bichig/tushaal

142010813

4.6. Багш, ажилтан, суралцагчтай холбоо барих утасны жагсаалт, тухайн өдөр хичээлийн байранд орсон, гарсан хүмүүсийг бүртгэх, суралцагчдын ирцийн мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн системд өдөр бүр оруулах;

5. Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга нарт дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

5.1. Давтлагад хамрагдах хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах талаар зааварт заасан хамгаалах хэрэгсэл түүнийг ашиглах заавар, санамжийг эцэг эх, асран хамгаалагчдад орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад арга хэлбэрээр шуурхай хүргэж, бэлэн байдлыг хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.2. Эрүүл мэнд, онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг тухай бүрд нь сургуулиудад шуурхай хүргүүлж, ажиллах;

5.3. Давтлага зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байдал, зааврыг сургуулийн удирдлага, багш, ажилтан, суралцагчид мөрдөн ажиллаж буй эсэхэд хяналт тавих;

5.4. Халдвар тархах эрсдэл үүссэн тохиолдолд давтлагыг зогсоож, орон нутгийн онцгой комисст мэдэгдэж, тус комиссоос гаргасан шийдвэрийг мөрдөж ажиллах.

6. Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх орчин нөхцөл бүрдүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд давтлагыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, суралцах орчны эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

7. Давтлагад хамрагдсан суралцагчийн ирцийн мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэж, 7 хоног бүр мэдээлж байхыг Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дүнжиннамдаг/-т үүрэг болгосугай.

8. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд Г.Ганбаярт даалгасугай.

САЙД



Е. БААТАРБИЛЭГ

D:alban bichig/tushaal

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2020 оны 12-р дугаар сарын 27-ны
өдрийн 27 дугаар тушаалын хавсралт

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТАД БЭЛТГЭХ ДАВТЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ЗААВАР

1. Коронавируст халдвар (COVID 19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хорио, хөдөлгөөний хязгаарлалтын үед ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг ерөнхий боловсролын сургуулийн орчинд зохион байгуулахад энэхүү зааврыг мөрдөнө.

2. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад сургуулийн удирдлага, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, албан хаагчид тодорхой үүрэг хүлээн бэлтгэлийг сайтар хангаж, халдвараас урьдчилан сэргийлсэн орчин нөхцөл бүрдүүлэн, тогтоосон дэгийг баримталж ажиллана.

3. Давтлагын нэг ээлжийн үргэлжлэх хугацаа нь сургалтын цагаар өдөрт 3 цагаас илүүгүй байх бөгөөд суралцагч шалгалт өгөхөөр сонгосон бүх хичээлээр давтлагад 5 хоногийн хугацаанд бүрэн хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

4. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахын өмнө дараах бэлтгэлийг заавал хангасан байна. Үүнд:

4.1. Эрүүл мэнд, онцгой байдлын болон мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг ил тод байршуулна.

4.2. Сургуулийн удирдлагын баг 12 дугаар ангийн суралцагчийн хүсэлтийг судлан сургалтад хамрагдах суралцагчдын тоог тодорхой болгосон байна.

4.3. Нэг танхимд 10-аас илүүгүй суралцагч байхаар тооцоолон анги танхимыг бэлтгэн, багшийн хичээлийн хуваарийг төлөвлөнө.

4.4. Нэг ширээнд нэг суралцагч суух, ширээ хоорондын зайг 1-1,5 метр байхаар ширээ сандлыг байрлуулна.

4.5. Мэргэжлийн байгууллагаас халдвар хамгаалал, эрүүл ахуйн заавар, зөвлөмж, сургалт авч, урьдчилсан тандалт хийх багаж хэрэгслийг бэлтгэнэ.

4.6. Сургууль орчмын бүсэд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийлгэж, шаардагдах ариутгалын бодисыг энэхүү сургалтын хугацаанд тасалдахгүй байхаар бэлтгэнэ.

4.7. Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага, ном сурах бичгийг бэлтгэнэ.

4.8. Багш сурагчид хичээллэх танхимд орох, гарахдаа нэг дор олноороо цугларахгүй байхаар зохицуулалт хийж, зураглал гаргана.

4.9. Сургалтын үйл ажиллагаанд оролцогчдоор тогтоосон дэгийг мөрдүүлэх, сургуулийн орчны хаана, хэзээ, хэн хяналт тавьж ажиллахыг тодорхой болгож, хуваарь гаргасан байна.

5. Халдвараас сэргийлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг заавал хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1. Давтлагад хамрагдах хугацаанд дотуур байранд хүүхэд байрлуулахгүй. Дотуур байранд амьдарч байсан хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлгүй байх нөхцөл бүрдүүлэхээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулж ажиллана.

5.2. Сургуулийн удирдлагын баг хариуцлагатай жижүүрийн горимоор ажиллана.

5.3. Багш, суралцагч, албан хаагчдыг амны хаалттай нэвтрүүлж, тэдний биеийн халууныг тогтмол хэмжин, тэмдэглэл хөтөлж, шаардлагатай тохиолдолд эмчийн үзлэгт хамруулна.

5.4. Сургууль орчмын бүсэд цэвэрлэгээ, ариутгалыг хуваарийн дагуу тогтмол хийж, гадны хүн нэвтрэх, хүн олноор цугларахгүй байх арга хэмжээ авна.

5.5. Сургууль, анги танхимд цэвэрлэгээ, ариутгалыг хуваарийн дагуу тогтмол хийж, орох, гарах хөдөлгөөнд хяналт тавьж, сургуулийн давхар бүрт хянагч ажиллуулна.

5.6. Сургуулийн нүхэн жорлон, ариун цэврийн өрөө, угаагуурт дараалал үүсгэхгүй байхаар зохицуулалт хийж, ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийнэ.

5.7. Ариун цэврийн өрөөнд саван, анги, танхимд спиртэн суурьтай гар ариутгагчийг байнга байлгана.

5.8. Анги, танхимд 40 минут тутамд 10-15 минутын агаар сэлгэлт хийнэ.

5.9. Ээлж хооронд анги танхимд цэвэрлэгээ, агаар сэлгэлт хийнэ.

5.10. Ширээ сандал, самбар, хичээлийн хэрэглэгдэхүүн, номын шүүгээ зэрэг хатуу гадаргууг ахуйн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор 2 цаг тутамд цэвэрлэгээ, ариутгал хийнэ.

5.11. Багш, суралцагчдыг халуун бүлээн ус, цай уух боломжийг бүрдүүлнэ. Багш, суралцагчид өөрсдийн аяга, савтай байх бөгөөд анги танхимд хооллохгүй.

5.12. Анги танхимд хувцсаа нэг дор өлгөхгүй, сэгсрэхгүй байх зохицуулалт хийнэ.

6. Давтлагын үед суралцагч дараах дэгийг баримтална. Үүнд:

6.1. Суралцагч нь зөвхөн хуваарьт давтлагад хамрагдана.

6.2. Суралцагч амны хаалттай байх бөгөөд сургуульд нэвтрэхдээ биеийн халуунаа хэмжүүлнэ.

6.3. Анги танхимд хуваарилсан суудалд сууж хичээллэнэ.

6.4. Бал үзэг, цаас, ном дэвтэр, утас, таблет, notebook, флаш гэх мэт аливаа хэрэглэгдэхүүнийг бусдад дамжуулж хэрэглэхийг хориглоно.

6.5. Халуун бүлээн ус, шингэн уух зүйл бэлтгэн авч ирсэн тохиолдолд хоорондоо дамжуулан хэрэглэхгүй байна.

6.6. Бусадтай гар барих гэх мэтээр бусдын биед хүрэхгүй байна.

6.7. Бохирдол ихтэй зүйлст хүрсэн тохиолдолд заавал гараа угаах эсвэл ариутгалын бодисоор цэвэрлэнэ.

6.8. Завсарлагааны үеэр коридор, бие засах газарт бусадтайгаа 1-1,5 метрээс дотогш зайд ойртож харилцахгүй байна.

6.9. Биед ямар нэг өвчний зовуурь, шинж тэмдэг (халуурах, ханиалгах, амьсгалахад төвөгтэй болох, суулгах, бөөлжих гэх мэт) илэрсэн тохиолдолд сургууль дээр ирэлгүй, багшдаа мэдэгдэж, эрүүл мэндийн байгууллагад хандана.

6.10. "Гэр-сургууль-гэр" маршрутын дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтална.

7. Сургуулийн удирдлага, багш, албан хаагчид, эцэг эх, асран хамгаалагчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

7.1. Давтлага зохион байгуулах үйл ажиллагаанд оролцогчид бүгд амны хаалт зүүж, гараа ариутгана. Бусадтайгаа 1-1,5 метрээс дотогш зайд ойртож харилцахгүй байна.

7.2. Хариуцлагатай жижүүр өдөр тутмын тэмдэглэл хөтлөн, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлнэ.

7.3. Сургуулийн удирдлага, эмч нь гадаад, дотоод орчны цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлийг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавина. Мэргэжлийн байгууллагаас өгч буй заавар, зөвлөмжийг багш, суралцагч, албан хаагчдад мэдээлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.

7.4. Багш, албан хаагчид нь суралцагчид тогтоосон дэгийг баримталж буй байдал, тэдний биеийн эрүүл мэндэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сургуулийн эмчид мэдээлэл өгч ажиллана.

7.5. Суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдэдээ амны хаалт, гар ариутгагч, уух зүйл бэлтгэн өгч, өглөө, өдрийн хоол, цайг гэрт нь тогтмол уулгаж, дархлааг нь дэмжинэ. Хүүхдийнхээ биеийн байдлыг ажиглаж, өвдсөн шинж тэмдэг илэрсэн үед сургалтад явуулахгүй байх арга хэмжээ авна. Хүүхдийнхээ давтлагын цагийн хуваарьтай танилцаж, "Гэр-сургууль-гэр" маршрутыг мөрдүүлнэ.

7.6. Багш, албан хаагч, эцэг эх, асран хамгаалагчид нь мэргэжлийн байгууллагаас өгч буй халдвар, хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, суралцагчдад үлгэрлэнэ.

.....000.....



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/244

Улаанбаатар хот

Хичээлийн жилийн бүтэц
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан хичээлийн жилийн бүтцийг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.
3. Халдварт өвчний тархалт, агаарын бохирдол, мал төллөх хугацаанаас хамааруулан хичээлийн жилийн улирлын амралтын эхлэх, дуусах хугацаанд хавсралтад заасны дагуу зохицуулалт хийхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.
4. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хичээлийн жилийн шинэчилсэн бүтцэд нийцүүлэн хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулж, багш нарт хүргэхийг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.
5. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын газар /Т.Ням-Очир/-т тус тус даалгасугай.
6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай" А/490 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Е.БААТАРБИЛЭГ

142010797

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
 2020 оны ... дугаар сарын ... -ны өдрийн
 АХН дугаар тушаалын хавсралт

Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц

Улирал	Нэгдүгээр улирал												Хоёрдугаар улирал					Гуравдугаар улирал					Нийт 7 хоног																																							
	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	II	III	IV	V	VI	IV	V	VI																																												
7 хоног	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42																				
Анг	16 долоо хоног												A					8 долоо хоног					8 долоо хоног					A					9 долоо хоног					9 долоо хоног					Ш А					32					33					34				

Тайлбар:

- 1 Хичээлийн жилийн 1 дүгээр улирлын 8, 9 дэх долоо хоногт Бага, дунд боловсролын тухай хуулийн 18.1-18.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2 Хичээлийн жилийн сүүлийн 7 хоногт дунд, ахлах ангид Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3 Хичээлийн жил ба улирлын амралт Даваа гарагт эхэлж, Баасан гарагт дуусна.
- 4 Халдварт өвчний тархалт, өвөлжилтийн байдлаас хамааран 31 дүгээр 7 хоногийн амралтыг 1 дүгээр улирлын амралт дээр нэмж шилжүүлж болно.

Тэмдэглэгээ: А - амралт
 Ш - шалгалт



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/249

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.10, 13.12 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан чиглэлийг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлж ажиллахыг захирал нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын газар /Г.Ням-очир/, Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс /Ч.Ганцэцэг/, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Г.Энхжаргал/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё БААТАРБИЛЭГ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2020 оны 05 дугаар... сарын 21-ний
өдрийн 1889 дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТАНХИМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмшихэд тулгарч байгаа бэрхшээлийг бууруулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг ерөнхий боловсролын сургуулийн орчинд зохион байгуулахад энэхүү чиглэлийг баримтална.

1.2. Энэхүү чиглэлийг хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бүрийн онцлог байдлыг хүндэтгэх, тэдний хүсэл, сонирхлыг харгалзан давуу тал, авьяас, суралцах хэв маягт тохируулан үйлчлэх, суралцах, хөгжих үйлийг дэмжихэд бүх талын оролцоо, түншлэлийг хангасан, ил тод, нээлттэй, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчим баримтална.

1.3. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг тэдний бэрхшээлийн онцлог, суралцах хэв маягт тохирсон зориулалтын тоног төхөөрөмж, тохируулгат орчин бүхий танхимд зохион байгуулна.

1.4. "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим /цаашид "танхим" гэх" гэж хүүхдийн алдагдсан чадварыг боломжит дээд хэмжээнд сэргээх, засан сайжруулах, боловсрол эзэмшихэд туслах тохирох хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангагдсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллах, сургалт, зөвлөгөө, мэдээлэл, зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулах танхимыг ойлгоно.

1.5. Энэхүү чиглэлд хэрэглэсэн "Тохирох хэрэглэгдэхүүн", "Туслах хэрэгсэл" гэсэн нэр томъёог Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.8-д зааснаар тус тус ойлгоно.

1.6. Тухайн сургуульд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бэрхшээлийн төрөл, сургалтын тохирох тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, хэрэгслийн хүртээмж, бэлтгэгдсэн хүний нөөцөөс тус тус хамаарч энэхүү чиглэлийн 1.4-д заасан танхимыг сургууль дангаар эсхүл сургууль дундын хэлбэрээр тус тус байгуулж ажиллуулна.

1.7. Энэхүү танхимаар тухайн орон нутагт оршин суугаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш үйлчлүүлнэ.

Хоёр. Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд зохион байгуулах үйл ажиллагаа

2.1. Энэхүү чиглэлийн 1.4-д заасан танхимд сургалт, хүмүүжлийн, засан сайжруулах, хөгжүүлэх болон зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулна.

2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын тусгай хэрэгцээг харгалзан тэдэнд амьдрах ухаан, хэл яриа, танин мэдэхүй, харилцаа, хөдөлгөөн, орон зай, чиг баримжаа, мэдрэхүйн ур чадвар, чадамж эзэмшүүлэх чиглэлээр сургалт, хүмүүжлийн дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, суралцах хэв маяг, тусгай хэрэгцээнд нийцсэн сургалтын ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж, нэмэлт давтлага өгөх, хүртэхүй, сэтгэхүйн үйлдлийг хөгжүүлэх дасгал, даалгавар ажиллуулах зэргээр хүүхэд бүртэй ганцаарчлан ажиллах;

2.2.2. Суралцагчийн өөртөө итгэх итгэл, оюун ухаан, хөдөлгөөн болон харилцааны ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг жижиг бүлгээр (хичээл давтах, ном унших, эвлүүлэх, зохиох, бүтээх, тоглоом тоглох, мэдээллийн болон туслах технологи хэрэглэж сурах) зохион байгуулах;

2.2.3. Харилцан ойлголцох, хүндлэх, сэтгэл хөдлөлөө удирдах зэрэг үнэт зүйлсийг эрхэмлэх соёлд сургах зэрэг хүмүүжлийн эерэг зан үйл төлөвшүүлэх ажлыг үе тэнгийнхний дэмжлэг, зөвлөн чиглүүлэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулах;

2.2.4. Сургуулийн орчин, хичээл, сургалтын болон хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох, анги дэвшин суралцах, мэргэжил сонгоход туслах үйл ажиллагааг багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

2.2.5. Өөртөө үйлчлэх, эрүүл аюулгүй амьдрах, нийгмийн амьдралд бие даан оролцох чадварт сургах;

2.3. Хүүхдийн бие махбодын болон хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч алдагдсан чадварыг сэргээх, засан сайжруулах, хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

2.3.1. бие бялдар, хөдөлгөөний эвслийг засан сайжруулах;

2.3.2. харилцааны ур чадварыг хөгжүүлэх, тайвшруулах;

2.3.3. сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг хөгжүүлэх, хүүхдийн сөрөг зан үйлийг засах;

2.3.4. сэтгэл зүйч, хэл засалч, тусгай хэрэгцээт боловсролын багштай ганцаарчилсан сургалт зохион байгуулах.

2.4. Энэхүү чиглэлийн 2.3-д заасан үйл ажиллагааг шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцаатай хэрэгжүүлж болно.

2.5. Хүүхдийг бусадтай харилцах, өөрийгөө илэрхийлэх, дүрэм журмыг дагах арга барилд сургах, хөгжилд нь тохируулан дэмжлэг үзүүлэх, асрах, хөгжүүлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш, ажилтанд зөвлөгөө, мэдээлэл, зөвлөн туслах дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

2.5.1. Хүүхдийн хөгжил төлөвшил, гэр бүлийн талаар мэдээлэл цуглуулах (анкет, ярилцлага, ажиглалт гэх мэт), тусгай хэрэгцээг тодорхойлж, дэмжлэгийн чиглэлийг тогтоох;

2.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээ, хөгжил, ахиц өөрчлөлт, тэдэнтэй ажиллах арга зүйн талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулах, сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх;

2.5.3. Хүүхдийн тусгай хэрэгцээ, дэмжлэгийн чиглэлд тулгуурлан хүүхдийн хөгжил, сэтгэл хөдлөлийн байдлыг ажиглах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, тохирох хэрэглэгдэхүүн боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд багшид зөвлөн туслах.

2.6. Хөгжлийн бэрхшээл, тусгай хэрэгцээт болон тэгш хамруулах боловсролын талаар багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үе тэнгийнхэн болон иргэд, олон нийтэд эерэг ойлголт, хандлага төлөвшүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх, нөлөөллийн дараах үйл ажиллагаа зохион байгуулна:

2.6.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ойлгох, хүндэтгэх, хамгаалах, харилцах, дэмжин туслах зэрэг чиглэлээр зөвлөгөө, мэдээллийг үе тэнгийнхэн болон олон нийтэд өгөх, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх;

2.6.2. Хүүхдийн хөгжлийн ахиц, өөрчлөлт, амжилтыг сурталчлах арга хэмжээг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоотой зохион байгуулах.

2.7. Танхимд хичээллэх суралцагчийн тусгай хэрэгцээнд тохируулан алдагдсан чадварыг боломжит дээд хэмжээнд сэргээх, засан сайжруулах, суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, цагийн хуваарийг багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.

Гурав. Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд тавих шаардлага

3.1. Энэхүү чиглэлийн 1.4-д заасан танхим нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах орчны нэг хэсэг байна.

3.2. Танхим нь "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал MNS6782:2019", Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS6799:2019" стандартад заасан ерөнхий шаардлагыг хангасан байна.

3.3 Танхимд багаар эсхүл ганцаарчилсан хэлбэрээр суралцах, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамрагдах боломжтой орон зайн шийдэл хийсэн байх бөгөөд танхимын нийт талбайн нэг хүүхдэд ногдох хэмжээ 5 м²-аас доошгүй байна.

3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих онцлог, тусгай хэрэгцээнд тохирох сургалтын хэрэглэгдэхүүн, туслах хэрэгсэл¹, тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, үзүүлэн таниулах материалыг танхимд байршуулсан байх бөгөөд тэдгээрийн аюулгүй байдлыг хангасан байна.

3.5. Танхим нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дэгтэй байна.

3.6. "Хүүхдийн хөгжлийн танхим"-ын үйл ажиллагаанд сургуулийн "Дэмжлэгийн баг²" зөвлөн тусалж, хяналт тавина.

Дөрөв. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаа

4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийгмийн амьдралд оролцох, бусадтай идэвхтэй харилцах, чадвар, чадамжаа боломжит дээд хэмжээнд хүргэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш, эмч болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үе тэнгийнхэн, иргэд, олон нийтийн оролцоотой хэрэгжүүлнэ.

4.2. Танхимын үйл ажиллагааг сургуулийн захирал дараах чиглэлээр дэмжиж ажиллана:

¹ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам"-ын 2 дугаар хавсралт

² Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам"-ын 3.5 дахь заалт

4.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд тохирох хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангах ажлыг санхүүгийн нөөц боломж, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн оролцоотой бүрдүүлэх;

4.2.2. Танхим хариуцан ажиллах багш, ажилтныг томилж, чөлөөлөх, холбогдох сургалтад хамруулах;

4.2.3. Багш, ажилтанд нэмэгдэл хөлс, урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох.

4.3. Танхимын үйл ажиллагааг сургалтын менежер дараах чиглэлээр дэмжиж ажиллана:

4.3.1. Энэхүү чиглэлийн 2.7, 3.5-д заасан төлөвлөгөө, хуваарь, дэгийг сургалтын менежер баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

4.3.2. Тэгш хамруулан сургах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр багшид сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

4.3.3. Энэхүү чиглэлийн 2.6, 2.7-д заасан үйл ажиллагааг удирдамжаар хангах.

4.4. Танхимын үйл ажиллагааг нийгмийн ажилтан дараах чиглэлээр дэмжиж ажиллана:

4.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог, суралцах хэв маяг, тусгай хэрэгцээ, давуу тал, авьяас, сонирхлын талаар судлах, хүүхдийн эрх ашгийг хамгаалах;

4.4.2. Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш, ажилтанд тулгамдаж байгаа асуудлыг шийдэх чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгөх;

4.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ойлгох, хүндэтгэх, нөхөрлөх, идэвхтэй харилцах үйлийг дэмжсэн арга хэмжээ зохион байгуулах, эерэг хамт олныг бий болгоход үе тэнгийнхнийг татан оролцуулах.

4.5. Танхимд багш дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

4.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээг судлах /эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч бусад багштай ганцаарчлан уулзаж тухайн хүүхдийн ерөнхий хөгжил, тусгай хэрэгцээний талаар мэдээлэл цуглуулах, зан үйлийн онцлог, суралцах үйлийг ажиглах, тэмдэглэл хөтлөх гэх мэт/;

4.5.2. Хүүхдийн тусгай хэрэгцээнд тохирсон ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, дасгал даалгавар боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх;

4.5.3. Ганцаарчилсан сургалт, хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, ахиц, өөрчлөлтийг тодорхой үе шатанд үнэлэх;

4.5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө өгөх;

4.5.5. Хүүхдийн хөдөлгөөний эв дүй, чадварыг хөгжүүлэх ажлыг биеийн тамирын багштай хамтран зохион байгуулах;

4.5.6. Хүүхдэд тохиолдож буй бэрхшээлийг хамтдаа шийдэж урамшуулах, идэвхжүүлэх ажлыг гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран зохион байгуулах;

4.5.7. Багш, ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй өөрийн туршлага, ур чадвараа солилцох, мэргэжлийн байгууллагаас сургалт, зөвлөгөө авах.

4.6. Танхимын үйл ажиллагааг сургуулийн эмч дараах чиглэлээр дэмжиж ажиллана:

4.6.1. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдээс хүүхдийн өсөлт хөгжлийн талаар асуумж авч, тандан судлах, тэмдэглэл хөтлөх;

4.6.2. Хүүхдийн эрүүл мэндийн байдалд үзлэг хийх, тэмдэглэл хөтлөх, хүүхдэд гарч буй өөрчлөлтийн талаар багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг мэдээллээр хангах;

4.6.3. Хүүхдийг хөгжүүлэх-засан сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах, багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө өгөх, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах.

4.7. Танхимын үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийт дараах чиглэлээр дэмжиж ажиллана:

4.7.1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, болон бусад үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;

4.7.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үе тэнгийнхэнд ойлгуулах, эерэг ойлголт, хандлага төлөвшүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах,

4.7.3. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, олон нийтийн байгууллагын хүүхэдтэй ажиллаж үр дүнд хүрсэн сайн туршлагыг харилцан солилцох, түгээн дэлгэрүүлэх;

4.7.4. Нутгийн захиргаа болон иргэний нийгмийн байгууллага нь хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаа, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

...000...



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 6 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 207

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.1.3, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.

3. Үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолыг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Боловсрол, соёл, шинжлэх
ухаан, спортын сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ё.БААТАРБИЛЭГ



Засгийн газрын 2020 оны 207 дугаар тогтоолын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн улс орнууд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг нийгмийн халамжийн бодлогын салшгүй нэг хэсэг болгож, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, мэдлэг чадвартай зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдний суралцах идэвх, оролцоог нэмэгдүүлэх, сурагчдын насны онцлогт тохирсон хоол, хүнсээр үйлчлэх, шим тэжээлийн мэдлэг, боловсрол олгох харилцааг хуулиар зохицуулан, тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж, сайн туршлагуудыг хуримтлуулсан байна.

Тухайлбал; Америкийн Нэгдсэн Улс 1946, Япон Улс 1954, Солонгос Улс 1953 оноос тус тус “Сургуулийн хоол”-ны тухай хуулийг хэрэгжүүлж эхэлжээ.

Америкийн Нэгдсэн Улсад өдөрт 31 сая, Японд 10 сая, Солонгост 7.3 сая, Энэтхэгт 140 сая, Оросын Холбооны Улсын бүх сургуулийн хүүхэд үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна.

Эдгээр улс орнуудын сургуулийн хоолны цэс нь өргөн сонголттой, хоолны түүхий эдийн 70 хувийг органик хүнс эзэлдэг байна.¹

Манай улсад “Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2006 оны 47 дугаар тогтоол, “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжиж байна.

Үндэсний аудитын газраас “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд уг хөтөлбөрт хамрагдаж байгаа сурагчдын 60 орчим хувийг хамруулж 2007-2008, 2010-2011 оны хичээлийн жилд судалгаа хийсэн бөгөөд уг судалгаагаар 2007-2008 оны хичээлийн жилийн бага ангийн сурагчдын 7 хоногийн дундаж ирц 91.3 хувьтай байсан бол 2010-2011 оны хичээлийн жилд 96.7 хувь болж өссөн байна.

Түүнчлэн сургууль завсардалтын байдлыг 16 аймгийн түвшинд авч үзэхэд 2006 оныг 2010 онтой харьцуулахад 54.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа талаар болон “Үдийн цай” хөтөлбөр нь нийслэлийн захын болон хөдөө орон нутгийн бага орлоготой өрхийн амьжиргаанд тодорхой хэмжээний дэмжлэг болж байгааг аудитын тайланд тус тус дурдсан байна.²

“Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон хүүхдэд халуун хоолоор үйлчлэхэд ажлын байр, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг стандартын шаардлагад нийцүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор шийдвэрлэх шаардлагатай байгаа тухай Мэргэжлийн

¹ Asia Pacific Journal of Clinical Nutrition, Volume 21, 2012

² Үндэсний аудитын газрын Үдийн цай хөтөлбөрийн явц, үр дүнгийн тайлан 2011

хяналтын ерөнхий газраас 2019 онд цэцэрлэг, сургуулийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд хийсэн хяналт шалгалтын танилцуулгад тэмдэглэсэн байна.

Мөн танилцуулгад сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын хоол үйлдвэрлэлийн технологийн урсгал нэг чигийн бус, ялангуяа үдийн цайнд халуун хоол олгох болсонтой холбоотойгоор ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх хоолны газрууд хүчин чадлаасаа 5-10 дахин давсан ачаалалтай ажиллаж, хоол үйлдвэрлэлийн ажиллагаа бүгд нэг дор 30-40 м2 өрөөнд хийгдэж байгаа зөрчил нийтлэг илэрч, хоол, хүнс бохирдох, улмаар халдвар, хордлого гарах эрсдэлийг бий болгож байгаа тухай дурдсан байна.³

Эрүүл мэндийн яам, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангаас 2017 онд явуулсан “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэстний V судалгаа”-ны дүнгээс үзэхэд илүүдэл жин, таргалалтын тархалт насанд хүрэгчид, сургуулийн хүүхэд, бага насны хүүхдийн дунд сүүлийн 10 жилийн хугацаанд эрс нэмэгдсэн байна.

Илүүдэл жин, таргалалттай хүүхэд насанд хүрэхэд зүрх судасны өвчин, багтраа, II хэв шинжийн чихрийн шижин зэрэг архаг өвчнөөр өвчлөх эрсдэл өндөр байдаг байна. Илүүдэл жинтэй 6-11 насны хүүхдийн эзлэх хувь хөдөө орон нутаг (17.6%)-тай харьцуулахад хот суурин газар (23.9%)-т өндөр байна.⁴

Иймд “Үдийн цай” хөтөлбөрийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2019 онд “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”-ийг баталж, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэстний хөтөлбөрийг Засгийн газар батлан, хэрэгжүүлэхээр заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний хуулийг дагаж гарах нийтлэг шаардлага, дүрэм, журмуудыг боловсруулан, хүнсний хангамжийн нэгдсэн тогтолцоог бий болгох, стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэж, оновчтой зохион байгуулах, суралцагчийн бие махбод, насны ангилалд тохирсон шим тэжээлийн зохистой харьцааг хангахад чиглэсэн хоолны жор технологийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулан, хоол, шим тэжээлийн талаар ойлголт, мэдлэг олгох тогтолцоог бүрдүүлэх, үр дүнг тооцож үнэлэлт дүгнэлт өгч байх зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий үндэстний хөтөлбөрийг боловсрууллаа.

Үндэстний хөтөлбөр нь Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, үндэстний хөтөлбөртэй уялдан улсын төсөв, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж дэмжлэгтэйгээр үндэстний хэмжээнд хэрэгжинэ.

³ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2018-2019, 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүн

⁴ “Хоол тэжээлийн үндэстний V судалгааны тайлан” 2017 он, ЭМЯ, НҮБ-ын Хүүхдийн сан

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй, тогтвортой, хүртээмжтэй тогтолцоог бий болгох, суралцагчийг шим тэжээллэг хоол, хүнсээр хангаж, эрүүл мэндийг нь дэмжихэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгуурласан, стандартын шаардлага хангасан хоол, хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлэх;

2.2.2. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх, хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулах замаар хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах;

2.2.3. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

2.2.4. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр дамжуулан боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх.

2.3. Хөтөлбөрийг 2020-2025 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгуурласан, стандартын шаардлага хангасан хоол, хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. орон нутгийн онцлогт тулгуурласан хүнсний хангамжийн тогтолцоог бий болгох, эрх зүйн орчныг сайжруулах;

3.1.2. сургууль дотор стандартын шаардлага хангасан ундны усаар үнэ төлбөргүй хангах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.3. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хангамжид үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэх боломжийг бүрдүүлэх, органик болон баяжуулсан хүнсний сонголтыг нэмэгдүүлэх;

3.1.4. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр чиглэлээр холбогдох арга хэмжээг авах;

3.1.5. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махыг нийлүүлэх асуудлыг судалж, хэрэгжүүлэх;

3.1.6. суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нийлүүлж байгаа хүнсний түүхий эдийг худалдан авах түүнд хяналт тавих цахим системийг газар зүйн байршил, орон нутгийн онцлогт тохируулан боловсруулах, турших.

3.2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх, хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулах замаар хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавих дүрэм, журам, стандартыг боловсруулж, мөрдүүлэх;

3.2.2. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцсэн орчин үеийн, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах;

3.2.3. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байр, тоног төхөөрөмжийн хангамж, хүчин чадал, ашиглалтын талаар судалгаа хийж, үнэлэлт өгөх, бүртгэлжүүлэх;

3.2.4. зохистой дадал нэвтрүүлсэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах;

3.2.5. хүн амын зохистой хооллолтын зөвлөмж хэмжээ, үнийн өсөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан хоолны зардлын нормативыг тогтмол шинэчлэх, санхүүжилтийн уян хатан тогтолцоог бий болгох;

3.2.6. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хаягдлыг бууруулах, дахин ашиглах чиглэлээр инновацийн үйл ажиллагаа нэвтрүүлэх.

3.2.7. сургуулийн хоол, хүнсний болон орчны аюулгүй байдалд тандалт судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг холбогдох байгууллагатай хамтран үе шаттай зохион байгуулах.

3.3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. нутгийн захиргааны байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх асуудал хариуцсан орон тооны ажилтантай болгох боломжийг судалж, эрх зүйн орчныг бий болгох;

3.3.2. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөц бэлтгэж байгаа сургалтын тогтолцоог сайжруулах, дэмжих;

3.3.3. ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа хоол зүйч, тогоочийн мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын тогтолцоог сайжруулж, сургалтын байгууллагыг чадавхжуулах;

3.3.4. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллаж байгаа ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

3.4. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр дамжуулан боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад олгож байгаа эрүүл мэндийн боловсролын хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэг олгох бүлгийн агуулгыг сайжруулж, модуль, хэрэглэгдэхүүн боловсруулах, турших;

3.4.2. багш, ажилчид, эцэг эх, асран хамгаалагчийн хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг өргөжүүлэх;

3.4.3. боловсролын үйлчилгээнд оролцогч талуудад хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэг олгох сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах, турших, сургалт зохион байгуулах;

3.4.4. сургуулийн хүүхдийн хоол, тэжээлийн байдлын судалгааг хийж шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, бүтээгдэхүүн,
шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

4.1.1. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоо бүрдсэн байна;

4.1.2. мэргэжлийн хүний нөөцөд суурилсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлснээр суралцагчид эрүүл, аюулгүй шим тэжээллэг хоол, хүнсээр тэгш, хүртээмжтэй хангагдана;

4.1.3. боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлснээр нийгмийн эрүүл мэндийн зарим үзүүлэлт дээшилсэн байна. Суралцагчдын хоол, шим тэжээлийн эерэг ойлголт, мэдлэг нь гэр бүлийн түвшинд дам нөлөө үзүүлэх боломж бүрдэнэ;

4.1.4. сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөнөөр шинэ ажлын байр бий болж, орон нутагт иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдсэн байна.

4.2. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр тодорхойлно:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2019 он)	Зорилтот түвшин (2025 он)
1.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах эрх зүйн баримт бичгийн тоо	тоо	0	12
2.	Сурагчдыг стандартын шаардлага хангасан ундны усаар үнэ төлбөргүй хангасан сургуулийн эзлэх хувь	хувь	56	100

3.	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх орон нутгийн болон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь	хувь	15	60
4.	Үдийн хоолонд бүрэн шилжсэн сургуулийн эзлэх хувь	хувь	20	100
5.	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээллийн сан бүхий цахим систем	тоо	0	1
6.	Хоол зүйчээр хангагдсан сургуулийн тоо	тоо	7	600
7.	Мэргэжлийн тогоочоор хангагдсан сургуулийн тоо	тоо	99	662
8.	6-11 насны хүүхдийн өсөлт хоцролтын тархалтын хувь	хувь	7.3 (2017 он)	5.0
9.	Хоол, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хийх нэвтрүүлгийн тоо	тоо	1	25
10.	Боловсролын үйлчилгээнд оролцогч талуудад зориулсан хөтөлбөр, хэрэглэгдэхүүн	тоо	0	3

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 5.1.3. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 5.1.4. хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
- 5.1.5. бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, дүнг Засгийн газарт танилцуулна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн IY улиралд багтаан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

6.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг холбогдох яам, агентлагууд жил бүрийн 12 дугаар сард багтаан гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний болон хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

-----oOo-----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 6 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 208

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Боловсролын тухай хуулийн 40.2, 43.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам"-ын "Хоёр" дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 2.8, 2.9 дэх заалт нэмсүгэй:

"2.8. Ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид хүүхдийн хөгжлийн ахиц, багшийн ачааллыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгоно."

"2.9. Энэ журмын 2.8-д заасан нэмэгдэл хөлс олгох зааврыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

2. Энэ тогтоолыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, соёл, шинжлэх
ухаан, спортын сайд

Ё.БААТАРБИЛЭГ



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/286

Улаанбаатар хот

Хичээлийн жилийн бэлтгэл хангах
талаар авах зарим арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын 2019-2020 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилт, үр дүнг дүгнэх, 2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хичээлийн жилийн бэлтгэл хангахтай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг /Т.Ням-Очир/-т үүрэг болгосугай.

2.1. 2019-2020 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж танилцуулах;

2.2. 2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн дотор боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.3. Цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад 2020 оны IX сард зохион байгуулах бататгах хичээлүүдийн агуулга, арга зүйн зөвлөмж боловсруулах, хичээл, сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах платформ хөгжүүлэх дэд багийн бүрэлдэхүүнийг хичээл тус бүрээр Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран томилон ажиллуулах;

2.4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах платформ хөгжүүлэх ажлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Монгол дахь төрөлжсөн байгууллагаас хэрэгжүүлэх "Монгол Улсад COVID-19 тархалтыг хязгаарлах, түүний сөрөг нөлөөллийг бууруулахад нэн шаардлагатай нийгмийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд зохион байгуулах.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Цэдэвсүрэн/-д даалгасугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

142011032

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2020 оны 06 сарын 02
өдрийн 41 дугаар тушаалын хавсралт



Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын
2019-2020 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилт, үр дүнг
дүгнэх, 2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл хангах ажлын
хэсгийн бүрэлдэхүүн

Нэг. Ажлын хэсгийн ахлагч:	Т.Ням-Очир	Ерөнхий боловсролын газрын дарга
Гишүүд:	Ж.Мягмар	Сургуулийн өмнөх боловсролын газрын дарга
	Ч.Энх-Амгалан	Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн газрын дарга
	Г.Энхжаргал	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
	Г.Батнэмэх	Дээд боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ч.Ганцэцэг	Тусгай хэрэгцээт боловсролын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ж.Ган-Эрдэнэ	Боловсролын үнэлгээний төвийн захирал
	Л.Болортунгалаг	Насан туршийн боловсролын үндэсний төвийн захирал
	Р.Нямцэрэн	Боловсролын хүрээлэнгийн дэд захирал
	Д.Энх-Амгалан	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын дэд захирал
Нарийн бичгийн дарга	Д.Наранзул	Ерөнхий боловсролын газрын шинжээч

1.1. Цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад 2020 оны IX сард зохион байгуулах бататгах хичээлийн агуулга, арга зүйн зөвлөмж боловсруулах ажлыг удирдах баг

Багийн ахлагч:	П.Лхагвасүрэн	Боловсролын хүрээлэнгийн захирал
Гишүүд:	С.Санжаабадам	Боловсролын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
	А.Энхтогтох	Боловсролын хүрээлэнгийн Боловсролын хөтөлбөрийн секторын эрхлэгч

	У.Туяа	Боловсролын хүрээлэнгийн Үндэсний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын секторын эрхлэгч
	Ц.Цэвэгмид	Боловсролын хүрээлэнгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, арга зүйн секторын эрхлэгч
	Н.Цэрэннадмид	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн боловсролын хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн /тохиролцсоноор/
	Ц.Халиун	Боловсролын чанарын шинэчлэл төслийн зохицуулагч
	Д.Алтанцэцэг	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн дэд зохицуулагч
Нарийн бичгийн дарга:	Х.Энхжаргал	Боловсролын хүрээлэнгийн Боловсролын хөтөлбөрийн секторын эрдэм шинжилгээний ажилтан

1.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх платформ хөгжүүлэх ажлыг удирдах баг

Багийн ахлагч:	Ж.Болормаа	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирал
Гишүүд:	А.Энхтогтох	Боловсролын хүрээлэнгийн Боловсролын хөтөлбөрийн секторын эрхлэгч
	Л.Ганбат	Боловсролын үнэлгээний төвийн хэлтсийн дарга
	Эри Фүжита	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын боловсрол хариуцсан суурин төлөөлөгч /тохиролцсоноор/
	Н.Цэрэннадмид	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн боловсролын хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн /тохиролцсоноор/
	С.Өлзийсайхан	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн бага насны хүүхдийн хөгжил хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/

	Х.Баттуяа	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн залуучуудын хөтөлбөрийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/
	С.Хандмаа	ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/
Нарийн бичгийн дарга:	Д.Энх-Амгалан	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын дэд захирал

---000---



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/296

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 208 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар"-ыг хавсралт ёсоор баталсугай

2. Зааврыг 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Ерөнхий боловсролын газар /Т.Ням-Очир/, Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс /Ч.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

142011077

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2020 оны 06 дугаар
сарын 25-ний өдрийн 9/296 дугаар
тушаалын хавсралт

**Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд
хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа
багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Ердийн хэв шинж бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль /цаашид "цэцэрлэг, сургууль" гэх/-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид нэмэгдэл хөлс /цаашид "нэмэгдэл хөлс" гэх/ олгоход энэхүү зааврыг баримтална.

1.2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын орон нутаг дахь салбар комисс"-ын дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй болох нь тогтоогдсон хүүхэдтэй ажиллаж байгаа цэцэрлэгийн багш, туслах багш, бага, дунд, ахлах анги удирдсан болон хүүхэд хөгжлийн танхимын багшид ажлын үр дүнд үндэслэн нэмэгдэл хөлсийг энэхүү зааврын 2-т заасан хувь хэмжээгээр тус тус олгоно.

1.3. Хүүхдийн бэрхшээлийн онцлог, хэрэгцээг харгалзан нэг бүлэгт байх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн цэцэрлэг, сургуулийн багш нарын зөвлөлийн хурдаар хэлэлцэж тогтооно.

1.4. Энэхүү зааврын 2.1.2-т заасан багш хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг цэцэрлэгийн арга зүйч/эрхлэгч, сургалтын менежерээр батлуулж, үр дүнг тооцуулна.

1.5. Энэхүү зааврын 1.2-т заасан багшид нэмэгдэл хөлс олгох шийдвэрийг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал гаргана.

Хоёр. Нэмэгдэл хөлс олгох

2.1. Энэ зааврын 1.2-т заасан багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн нэмэгдэл хөлсийг тухайн багшийн албан тушаалын сарын үндсэн цалингаас сар бүр тооцож, улиралд нэг удаа дараах хувь хэмжээгээр тус тус олгоно.

2.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа цэцэрлэгийн бүлгийн багш, туслах багш, бага ангийн багш, туслах багш, дунд, ахлах анги удирдсан багш, хүүхэд хөгжлийн танхимын багшид албан тушаалын сарын үндсэн үндсэн цалингийн 10 хувиар;

2.1.2. Цэцэрлэгийн хөгжим, биеийн тамирын багш, сургуулийн дунд, ахлах ангийн хичээл заадаг багш хүүхдийн бэрхшээлийн онцлогт нийцүүлэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэсэн тохиолдолд нэмэгдэл хөлсийг дараах аргачлалаар тооцож олгоно.

Ерөнхий боловсролын сургууль	Сургуулийн өмнөх боловсрол
$S_n = \frac{M \times n}{760}$	$S_n = \frac{M \times n}{1600}$
S_n – Нэмэгдэл хөлс	S_n – Нэмэгдэл хөлс
M – Үндсэн цалин	M – Үндсэн цалин

<p>л – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тухайн сард ажилласан хичээл, үйл ажиллагааны нийт цаг</p>	<p>л – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тухайн сард ажилласан хичээл, үйл ажиллагааны нийт цаг</p>
--	--

2.2. Энэхүү зааврын 2.1-д заасан ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хүүхдийн тусгай хэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн агуулга, багшийн албан тушаалын чиг үүргээс хамааруулан дараах үйл ажиллагааны хүрээнд улиралд нэг удаа хийнэ:

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хэрэгцээг судлах;

2.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэмэлт хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

2.2.3. Шаардлагатай тохиолдолд хүүхдэд засан сайжруулах үйлчилгээ үзүүлэх;

2.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгөх;

2.2.5. Хүүхдэд тохиолдож буй бэрхшээлийг хамтдаа шийдэж урамшуулах, идэвхжүүлэх ажил зохион байгуулах;

2.2.6. Хүүхдээс хүүхдэд, үе тэнгийн туслагч хөдөлгөөн өрнүүлэх;

2.2.7. Хүүхдийн авьяас, сонирхлыг нээн хөгжүүлэх;

2.2.8. Анги удирдсан багш тухайн хүүхдийг сургууль, анги танхимд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, хичээл заадаг багштай хамтран ажиллах, хүүхэд хөгжлийн үйл ажиллагаанд оролцуулах, өөртөө үйлчлэх, бусадтай харилцах чадварыг хөгжүүлэх;

2.2.9. Хүүхдийн ахиц, өөрчлөлтийг тэмдэглэх, дүн шинжилгээ хийх.

2.3. Энэхүү зааврын 2.2-д заасан үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх ажлыг цэцэрлэгийн арга зүйч/эрхлэгч, сургуулийн сургалтын менежер хийнэ.

2.4. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр энэхүү журмын 2.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй тохиолдолд тухайн сард нэмэгдэл хөлс олгохгүй.

---000---



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/305

Улаанбаатар хот

Жишиг хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хэл ярианы хөгжил" сургалтын жишиг хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан сургалтын жишиг хөтөлбөрийг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд ганцаарчилсан сургалтаар хэрэгжүүлсүгэй.
3. "Хэл ярианы хөгжил" сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын газар /Т.Ням-Очир/, Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс /Ч.Ганцэцэг/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газарт тус тус даалгасугай.


САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

122011089

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны ... сарын ...-ний өдрийн
..... дугаар тушаалын хавсралт



“ХЭЛ ЯРИАНЫ ХӨГЖИЛ” СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР

Нийтлэг үндэслэл:

Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, хүний эрх, хүүхдийн эрхтэй холбоотой аливаа тунхаглал, баримт бичгийг даган мөрдөж “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүмүүсийн эрхийн тунхаглал”, “Хүүхдийн эрхийн тухай конвенц”, Саламанка, Дакарын тунхаглал”, Ази, Номхон далайн бүс нутаг дахь тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүмүүст зориулсан “Эрхийг бодитой болгоё” Инчеоны стратеги, Тогтвортой боловсрол 2030 зэрэг баримт бичгүүдэд тусгасан боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг тэгш боломжоор ханган, адил тэгш ялгаварлан гадуурхалтгүй, хүртээмжтэй, чанартай боловсрол олгох үзэл санааг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого зэрэг хууль, тогтоомжийн хүрээнд холбогдох дүрэм, журмыг боловсруулж батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/155 дугаар тушаалаар “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал”
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаал, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын оны А/249 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”
- Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаартай хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар” зэрэг баримт бичигт хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн, ялгаварлан гадуурхалтгүй, адил тэгш боломжоор хангасан боловсролын үйлчилгээ үзүүлэхийг тодорхой заасан.

Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар ерөнхий боловсролын сургуульд хэл ярианы бэрхшээлтэй 857 хүүхэд суралцаж байна. Хүний харилцааны болон соёлын гол хэрэгсэл болох хэл ярианы хөгжил нь хүүхдийн танин мэдэхүйн болон бие хүний хөгжил, төлөвшил, сургалтын үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Иймд ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хүүхдийн хэл ярианы бэрхшээл, хоцрогдлыг арилгах, унших, бичихийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн “Хэл ярианы хөгжил” сургалтын жишиг хөтөлбөр боловсруулан сургууль, багш нарт хүргэж байна.

Энэхүү хөтөлбөр нь хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хэрэгжинэ.

Сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулахад баримталсан зарчим:

- Хэл ярианы бэрхшээлийг эрт үед илрүүлэх, засан сайжруулах чиглэлтэй байх;
- Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтгүй, боловсрол эзэмших орчин нь тэгш, хүртээмжтэй байх;
- Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд нэг бүртэй ажиллах сургалтыг уян хатан төлөвлөх, зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх.

Хөтөлбөрийн зорилго:

Хүүхдийн хэл яриаг засан сайжруулах, бусдын яриаг зөв ойлгох, өөрийгөө илэрхийлэх болон сургуульд дасан зохицох, унших, бичихийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт:

- Хүүхэд бусдын яриаг ойлгох, өөрийгөө илэрхийлэх боломжит чадвар эзэмших;
- Эх хэлээрээ зөв сонсож хүртэх, ойлгох, ярих боломжит чадвар эзэмших;
- Энгийн үг хэллэгээр бичигдсэн төрөл бүрийн эхийг сонсох, ойлгох, унших, утгыг ярих, бичгээр илэрхийлэх чадвар эзэмших.

Хөтөлбөрийн агуулга:

Сургалтын жишиг хөтөлбөрөөр хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн сонсох, ярих, унших, бичих чадварыг дараах агуулгын хүрээнд хөгжүүлнэ.

Сонсох	Ярих	Унших	Бичих
Түвшин I			
<ul style="list-style-type: none"> - Хэлний бус болон хэлний авиаг сонсох, хүртэх, ялган таних - Авиаг үе, үгнээс ялгаж сонсох, хүртэх - Үг, холбоо үг, богино өгүүлбэрийг сонсож, утгыг ойлгох, дохио зангаа, зурагт карт ашиглаж хариу илэрхийлэх - Багшийн хэлсэн авиа, үе, үгийг анхааралтай сонсож, давтан хэлэх, юмыг бодитоор буюу зурагт заах - Өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэгддэг үгийн нөөцийг нэмэгдүүлэх - Хүнтэй хариу мэндлэх, богино асуултыг сонсоод хариулах эсвэл хариулах оролдлого хийх 	<ul style="list-style-type: none"> - Хэлний бус (байгалийн) авиаг даган дуурайж дуугарах - Хэлний авиаг даган дуурайж хэлэх, зөв дуудах - Авиа, үе, үгийг зөв дуудах - Энгийн, шууд утгатай үг, холбоо үг бүтээх, ярих, утгыг ойлгох - Өөрийнхөө тухай богино өгүүлбэрээр асуултад хариулах - Өөрийгөө үг яриагаар илэрхийлэх оролдлого хийх 	<ul style="list-style-type: none"> - Үсэг, үе, богино үг, холбоо үг, өгүүлбэрийг зурагт картаар бүтээх - Үгт картыг зурагт карттай зөв харгалзуулах, - Шинэ авиа үсэгтэй танилцахдаа эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган таних - Үелж унших, 	<ul style="list-style-type: none"> - Үсэг бүтээдэг зурлагуудыг дэвтрийн шугамаар баримжаалан зааврын дагуу бичих, - Үсэг, үе, богино үг, холбоо үг, өгүүлбэрийг давхарлаж бичих - хуулж бичих, бичих - Хуулж бичихдээ хүний нэр болон өгүүлбэрийг томоор эхэлж бичдэг дүрмийг баримтлах

Түвшин II			
<ul style="list-style-type: none"> - Авиа, үе, үг, өгүүлбэрийг сонсох - Ахуйн хэрэглээний энгийн үгийн утгыг сонсож ойлгох - Богино өгүүлбэрийг сонсож ойлгох - Бусдын энгийн хүсэлтийг сонсох - 2 ба түүнээс дээш үеэс бүтсэн үг, холбоо үг, өгүүлбэрийг бусдын дэмжлэгтэй сонсож ойлгох - Удаан хэлэх, давтан хэлэх, биеийн хөдөлгөөнөөр заах, ба зураг, үгт карт ашигласан яриаг сонсож ойлгох - Энгийн, хялбар агуулгатай богино эх, зүйр үг, оньсого, шүлэг сонсох, утгыг ерөнхийд нь ойлгох - Хүүхдийн дуу сонсох, утгыг ерөнхийд нь ойлгох 	<ul style="list-style-type: none"> - Үг, холбоо үг, өгүүлбэр, эхийн утгыг зурагт, үгт картын тусламжтай ойлгож тайлбарлах - Өөрт нь хэрэгцээтэй байдал үүссэн тохиолдолд ярих оролдлого хийх - Өөрийн хүсэлтээ энгийн үгээр илэрхийлэх - Ярилцах үедээ багшийн болон бусдын дэмжлэг авах - Өдөр тутам хэрэглэгддэг энгийн үг хэллэгээр ярих - Үгт карт, зураг ашиглаж, мэдэхгүй, ойлгохгүй үгээ илэрхийлэх - Уншсан богино эхийн утгыг бусдын дэмжлэгтэй ярих 	<ul style="list-style-type: none"> - Цагаан толгойн үсгийг мэдэх, богино үетэй үгээс бүтсэн үг, холбоо үг, өгүүлбэрийг унших, - Өгүүлбэрт байгаа мэддэг үгээ таних - Богино өгүүлбэрээс ойлгосноо зургаар илэрхийлэх - Мэдэхгүй үгийн утгыг бусдын дэмжлэгтэй уншиж ойлгох - Уншсан үг, холбоо үг, өгүүлбэрийн утгыг ойлгох - Богино эх, шүлэг унших арга барилд суралцах - Эх, өгүүлбэрийг уншаад, хэн, юу, яав гэсэн асуултад хариулах 	<ul style="list-style-type: none"> - Цагаан толгойн үсгийг цээжээр бичих - Авиаг үсгээр дүрслэн бичих - Үсэг, үе ба үг, холбоо үгийг бичих - Үг, богино өгүүлбэрийг бие дааж болон багшийн дэмжлэгтэйгээр бичих - Өгүүлбэр, эх зохион бичих, утгыг зургаар илэрхийлж зурах, баримал барих - Бичихдээ өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх
Түвшин III			
<ul style="list-style-type: none"> - Өдөр тутмын амьдралын болон сургалтын агуулгын хүрээний үг, хэллэгийг сонсож, ойлгох, үүрэг, даалгаврыг биелүүлэх - Ахуйн шинжтэй, энгийн асуулт асуудлыг ойлгох - Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой яриа хүсэлт, анхааруулгыг сонсож ойлгох - Эхийг сонсож, асуултад хариулах - Танил шууд утгатай үг, хэллэгээр ярьсан, бичсэн мэдээллийг сонсож, ойлгох - Ахуйн агуулгатай, хялбар зүйр үг, шүлэг, оньсого, хэлц үгийг сонсож ойлгох 	<ul style="list-style-type: none"> - Үг, холбоо үг, өгүүлбэрээр ярих - Эхийн утгыг ойлгож ярих - Цээжилсэн, ойлгосон зүйлийн талаар ярих, хураангуй болон энгийн өгүүлбэрээр ярих - Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой яриа өрнүүлэх - Шүлэг, зүйр үг, оньсого, хэлц үгийн утгыг ойлгосноо тайлбарлах - Санаа, бодлоо илэрхийлэх, асуултад хариулах - Ойр дотнын хүмүүсийн тухай ярих, харилцан ярианд оролцох 	<ul style="list-style-type: none"> - Танил ба танил бус үгийг унших, утгыг ойлгох - Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой богино мэдээллийг унших, утгыг ойлгох - Богино эхийг уншиж, гол санааг ойлгох - Уншсан эхийн агуулгын дэс дарааллыг үгт карт, зурагт карт ашиглан тогтоох - 3-аас дээш үеэс бүтсэн урт үгийг үелж унших - Зүйр үг, шүлэг, оньсого, хэлц үгийг уншиж, дэмжлэгтэй ойлгох 	<ul style="list-style-type: none"> - Үг, холбоо үг, өгүүлбэрийн зөв бичих дүрмийг мэдэх, бичих - Үйл явдлыг харуулсан зургийн агуулгаар богино эх зохиож бичих - Өгүүлбэрийг 1-2 асуултын дагуу дэлгэрүүлэн бичих - Өдөр тутмын үйл явдлын тухай богино эхийг бие дааж болон бусдын дэмжлэгтэй зохион бичих - Энгийн мэдээлэл, захидлыг бие даах болон бусдын дэмжлэгтэй бичих

	- Өдөр тутмын болсон үйл явдлыг дэс дарааллаар нь энгийн танил, үг, холбоо үг хэрэглэн өгүүлбэрээр ярих	- Тухайн ангийн агуулгын түвшинд хичээлийн материалыг унших	- Хүсэлтээ бичиж, алдааг хянах - Бичихдээ өгүүлбэрт цэг, таслал, асуултын тэмдгийг зөв хэрэглэх
--	---	---	--

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалт

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл:

Сургалтын жишиг хөтөлбөрийг суралцагчийн хэл ярианы чадвар, сурах арга барил, хувь хүүхдийн хөгжих, сурах онцлогийг харгалзан ганцаарчилсан хичээлээр хэрэгжүүлнэ.

Сургалтын жишиг хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулийн багш, сургууль дээрх "Дэмжлэгийн баг"-ийн гишүүд (сургуулийн удирдлага, сэтгэл зүйч, эмч, сувилагч, нийгмийн ажилтан, дотуур байрны багш, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчид) хэл ярианы хөгжлийг дэмжсэн нэмэлт ганцаарчилсан сургалт шаардлагатай суралцагчдын суралцах ачааллыг тооцож төлөвлөнө.

Ерөнхий боловсролын сургууль нь орон нутаг, сургуулийн онцлог, хүний нөөцийг тооцон жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйг уян хатан, нээлттэй байхаар төлөвлөн, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан) боловсруулан хэрэгжүүлнэ.

Сургалтыг суралцагчийн гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран, тэдний санал, хүсэлтийг харгалзан зохион байгуулж, хүүхэд бүрийн хэрэгцээ, хөгжлийн түвшнийг харгалзан туслалцаа, зөвлөгөө өгч ажиллана. ЕБС-ийн "Дэмжлэгийн баг"-ийн үйл ажиллагаа нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн, амжилттай суралцахад бэлтгэхэд чиглэх юм.

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй нь хүүхэд төвтэй арга зүйд суурилсан хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгыг эзэмшүүлэхэд чиглэсэн байна. Засан сайжруулах арга зүй (суралцагч бүрийн хэл ярианы бэрхшээлийн онцлог, хөгжлийн ялгаатай байдлыг судалж, тэдний хэрэгцээ, чадварт суурилан засан сайжруулах) үйл ажиллагааны агуулгыг сурагч төвтэй оновчтой төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хүүхэд өөрөө мэдлэг бүтээх;
- Тэгш хамран сургах;
- Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзах (хөгжих, сурах онцлог, сурах арга барил гэх мэт);
- Алдаанаасаа суралцахад нь дэмжих;
- Асуулт, дасгал, даалгавраар үйл ажиллагаа болон суралцагчийн хөгжлийг дэмжих;

- Үйлийн явцад хөгжих;
- Тоглох, суралцах явцад хөгжих, төлөвших;

Сургалтын хэрэглэгдэхүүн

Сургалтын орчин гэдэгт танхимын болон танхимаас гадуурх байгаль, нийгэм, соёлын орчныг ойлгоно. Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургалтын орчин болох анги, танхим нь хүүхдийн хэл яриа, танин мэдэхүйн хөгжил, сонирхол хэрэгцээнд нийцсэн, бие дааж суралцах боломжтой, авьяасыг хөгжүүлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд суралцагчийн үйлийн орчин, тэдний оролцоог дэмжсэн, өөрөө суралцаж, хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Сургалтад ганцаарчилсан төлөвлөгөө, дохионы хэлний зурагт толь, сурах бичиг, зөвлөмж гарын авлага, зурагт альбом, хэвлэмэл, бодит, биет, цахим хэрэглэгдэхүүн, үзүүлэн, тарааж өгөх материал, дуу, дүрс бичлэг, видео хичээл, ардын уламжлалт болон орчин үеийн тоглоомууд, үгт карт, зурагт карт, модель, макет, сургалтын техник хэрэгсэл, телевизор, компьютер, дэлгэц, магнитофон, чихэвч зэргийг ашиглана. Зарим онцгой тохиолдолд сургалтад мэдрэгчтэй сэрүүлэгтэй цаг, хаалганы гэрлэн хонх, дуу чимээ мэдрэгч, дүрст утас гэх мэтийг ашиглах боломжтой.

Танхимын бус сургалтаар экскурс аялал, туршилт ажиглалт, кинотеатр, музей, түүхийн дурсгалт газар, үйлчилгээний газарт сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах нь үр дүнтэй байна.

Сургалтын орчин бүрдүүлэхэд орон нутаг, сургуулийн нөөц боломж, байгаль, нийгэм, соёлын ялгаатай байдал зэргийг харгалзсан аюулгүй, хямд, ашиглахад хялбар, олдоц сайтай гарын доорх материалаар сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж болно.

Үнэлгээ

Сургалтын жишиг хөтөлбөрийн дагуу ганцаарчилсан төлөвлөгөөгөөр хичээллэсэн суралцагчийн хэл ярианы хөгжлийн ахиц өөрчлөлтийг оношлох болон явцын, үр дүнгийн үнэлгээгээр үнэлнэ.

Оношлох үнэлгээ нь хэл ярианы бэрхшээлтэй суралцагчийн сурах үйл ажиллагаанд тулгарч байгаа хэл яриа, сонсгол, танин мэдэхүйн бэрхшээлийн түвшнийг тодорхойлж, тэдний онцлогийг тусгасан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах үндэслэл болно.

Явцын үнэлгээ нь суралцагчийн оролцоо, суралцах үйлийг дэмжиж, хэл ярианы хөгжилд ахиц өөрчлөлт гаргахад зорилгоор сургалтын явцад тогтмол хийгдэнэ.

Оношлох ба явцын үнэлгээнүүд нь үнэлгээний зорилго, үнэлж байгаа субъект болон арга хэлбэрээр ялгаатай байна.

Үр дүнгийн үнэлгээгээр сургалтын үр дүнг хүүхдийн хэл ярианы хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтийг тодорхойлно.

---000---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 7 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

Боловсролын салбарт хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15.1, Улсын онцгой комиссын саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Бүх шатны сургалтын байгууллагын хичээлийн жилийг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, шинжлэх ухааны сайд

Л.ЦЭДЭВСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 8/03

Улаанбаатар хий

Албан тушаалын үлгэрчилсэн
тодорхойлолт батлах тухай

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.27 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоол, 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 03/1352 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг нэгдүгээр, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерийн албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг хоёрдугаар, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хавсралтаар баталсан албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтод нийцүүлэн сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг тус тус боловсруулан батлах, албан хаагчийг сонгон шалгаруулах, албан тушаалд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, ажлын үр дүнг үнэлэхэд баримтлан ажиллахыг сум, дүүргийн Засаг дарга, сургуулийн захирал нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалыг олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын лаборатори сургууль, тусгай сургууль, их дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулах хамтарсан сургууль, гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Албан тушаалд тавих нийтлэг шаардлага, үндсэн чиг үүрэг батлах тухай" 2019 оны А/692 дугаар тушаал, 2020 оны А/137 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

- 142010042

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2020 оны 22 дугаар сарын 30-ны
өдрийн 1/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ТУШААЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Ерөнхий боловсролын сургууль

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Захирал

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮБД-5

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн тухай хуулийн 70.2

Тухайн ерөнхий боловсролын
сургуулийн улсын бүртгэлийн
гэрчилгээний хаяг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийг хөгжүүлэх, бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшийг хөгжлийг дэмжих ажлыг мэргэжлийн болон

захиргааны удирдлагаар хангах.

Албан тушаалын зорилт:

1. Салбарын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
2. Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, технологийг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах;
3. Байгууллагын хүний нөөцийн хөгжил, төлөвшлийг хангах, багшийн хөгжлийг дэмжих ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах;
4. Байгууллагын санхүүгийн болон материаллаг нөөцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, суралцагч, багш, ажилтныг эрүүл, аюулгүй таатай орчинд сурч, төлөвших, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Зорилго	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр
Нэгдүгээр зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Салбарын бодлого, хууль тогтоомж, сургуулийн хэв шинжид нийцүүлэн байгууллагын стратегийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах; - Аймгийн Засаг даргатай хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулах, байгууллагын тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах; - Байгууллагын төсвийн төсөөлөл, төсвийг төлөвлөх, батлуулах, зориулалтын дагуу зарцуулах, хяналт тавих, аудит хийлгэх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв, хугацаанд нь тайлагнах; - Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, төсвийн байгууллагын өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлэх; - Байгууллагын дотоод үйл ажиллагааны эрхзүйн баримт бичгийг баталж мөрдүүлэх; /Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, ажил албан тушаалын жагсаалт, албан тушаалын тодорхойлолт, цалин, нэмэгдэл олгох нөхцөл, журам болон бусад гэрээ, заавар, хөтөлбөр, төлөвлөгөө, норм норматив зэрэг/ - Боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, явц, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах; 		

<p>Нэгдүгээр зорилгын хүрээнд.</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах; - Тухайн сургуулийн хамран сургах тойргийн хүүхдийн тоо, төлөв байдлын судалгааг хийх, ойрын/хэтийн төлөвийн таамаглал боловсруулах, хамран сургах тойргийн сурагчдын элсэлтийг зохион байгуулах, элсүүлэн суралцуулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах; - Багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл/тэнхимийн ажиллах журмыг тогтоох; Боловсролын баримт бичгийг захиалах, олгох ажлыг удирдлагаар хангах, тайлагнах - Боловсролын статистик мэдээллийг хянан баталгаажуулах, тогтоосон хугацаанд тайлагнах; - Байгууллагыг хөгжүүлэх чиглэлээр дотоод гадаадын сургууль, аж ахуйн нэгж, байгууллагатай хууль тогтоомжийн дагуу гэрээ хэлцэл хийх хамтран ажиллах; - Байгууллагад өөрийн үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, удирдамжаар хангах; - Сургууль, багшийн үйл ажиллагаа, сургалтын чанар, төгсөгчдийн чанар, боловсролын хүртээмж, үр дүнгийн үзүүлэлтийг тогтмол хянах, шинжилгээ хийх, тайлагнах; - Сургуулийн үйл ажиллагааны чанар, үр дүнг тандах судалгаа, оношлогоо, хэрэглэгчийн үнэлгээний ажлыг багш, ажилтан, сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг хангах; - Бусад төрийн байгууллагаас шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг шуурхай, чанартай бэлтгэж, хүргүүлэх; - Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, мэдээллийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх, байгууллагын болон хувь хүний нууцыг хамгаалах; - Төрийн байгууллагын албан хэргийг холбогдох журам, стандартын дагуу хөтлөх, архив бүрдүүлэх ажлыг удирдлагаар хангах, хяналт тавих; - Хичээл болон хичээлээс гадуурх арга хэмжээний хүрээнд суралцагчдад авлигын хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, батлагдсан жагсаалтын дагуу хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хууль тогтоомжид заасны дагуу мэдүүлэх ажлыг зохион байгуулах; - Сургуулийн нийгмийн ажил, хүүхэд хамгаалал, төлөвшлийн чиглэлээрх бодлого, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтийг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах; - Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах. - ... 	
------------------------------------	---	--

<p>Хоёрдугаар зорилтын хүрээнд.</p>	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн менежмент, маркетинг хөгжүүлэх, сургалтын талаар баримтлах бодлого, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох, хэрэгжилтийг захиргааны удирдлагаар хангах; - Хөгжлийн чиг хандлагад баримжаалан, хичээл, сургалтын зохион байгуулалт, сургалтын арга зүй, технологи, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, сургалтын орчны хөгжлийн асуудлаар багш, ажилтныг мэдээллээр хангах, дэвшилтэт аргазүй, технологийг турших, нэвтрүүлэх ажлыг захиргааны удирдлагаар хангах, дэмжих, зөвлөн туслах; - Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй, үнэлгээний хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Боловсролын газрын удирдлага дор зохион байгуулж, үр дүнг тайлагнах; - Сургуулийн бүтцийн нэгж, хэв шинж, ангийн менежментийг оновчтой тогтоох; - Хичээл болон хичээлээс гадуурх сургалтын ажлыг чанартай зохион байгуулахад сургалтын менежер, багш нарт дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах, хамтран ажиллах; - Багш нарын зөвлөл, Заах аргын нэгдлийг мэргэжил аргазүйн удирдлагаа хэрэгжүүлэхэд нь захиргааны дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах; - Багш нарын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн суралцагчийг анги дэвшүүлэн суралцуулах, сургууль төгсгөх асуудлыг шийдвэрлэх; - Сургалтын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон зохих байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх; - Насан туршийн болон албан бус сургалтыг зохион байгуулах ажлыг удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх; - ... 		
<p>Гуравдугаар зорилтын хүрээнд.</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, нөөцийг зөв байршуулах, төлөвшүүлэх; - Ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн ажилтныг сонгон шалгаруулах, хуульд заасан үндэслэлээр ажилд томилох, ажлаас чөлөөлөх; - Багш ажилтны хөдөлмөрийн үр дүн, үр чадварыг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцох эрхзүйн орчныг бүрдүүлэх; - Төрийн албан хаагчдын хувийн хэрэг, мэдээллийн санг баяжуулах, шинэчлэх, архивлан хадгалуулах ажлыг зохион байгуулах; - Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах; - Багш, ажилтны мэргэжил, үр чадварын тасралтгүй хөгжлийг дэмжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байранд мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг баталж, тогтвортой хэрэгжүүлэх; 		

Гуравдугаар зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Багшийн ёсзүйн орон тооны бус зөвлөлийг байгуулах, ажиллах нөхцөл боломжоор хангах, багш, ажилтныг мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах; - Багш нарын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн багшид мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах; - Багш, ажилтны бүтээлч үйл ажиллагааг сурталчилан таниулах, урамшуулах, шилдэг арга зүй, технологи, менежмент, маркетинг, соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах; - ... 		
Дөрөвдүгээр зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Бага, суурь, бүрэн дунд боловсролын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эрүүл, аюулгүй байдал хангасан сургалтын материаллаг орчин бүрдүүлэх, сайжруулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах, хяналт тавих, эрсдлийн үнэлгээ тогтмол хийх; - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн эрүүл, аюулгүй дэд бүтэц бүрдүүлэх; - Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх; - Байгууллагын өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах, эд хөрөнгийн бүртгэлийг цахимжуулах, өмч эзэмшигчийн картыг шинэчлэх ажлыг зохион байгуулах; - Хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах; - Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, статистикийн мэдээлэл, бусад шаардлагатай мэдээ, судалгаа, тайланг үнэн зөв гаргах, холбогдох байгууллага, албан тушаалтанд тогтоосон хугацаанд нь мэдээлэх, тайлагнах; - Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг ил тод, нээлттэй, цаг хугацаанд нь мэдээлэх; - Сургуулийн орчин дахь хоол, хүнс, ундны цэвэр ус, бие засах газрын эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих; - Сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байр, талбай, тоног төхөөрөмжийг нийтийн өмчийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахтай холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актаар тогтоосон журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар зориулалтын дагуу түрээслүүлэх; 		

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Шийдвэр гаргахад багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл, багш, суралцагч, эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн үйл ажиллагаа, сургалтын явц, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэх; - Суралцагчид дотуур байранд амьдрах орчин нөхцлийг тогтмол сайжруулах, хяналт тавих; - Суралцагчийг сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарах, гэмт хэрэг, зөрчил зэрэг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; - Төрийн байгууллагын албан хэргийг холбогдох журам, стандартын дагуу хөтлөх, архив бүрдүүлэх ажлыг удирдлагаар хангах, хяналт тавих; - Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандарт, зааврын дагуу төлөвлөх, үдийн цайны цэс батлах, зохион байгуулах, мэргэжлийн ажилтнаар хангах, давтан сургах ажлыг удирдах; - Сурагчдыг сурах бичиг, дүрэмт хувцсаар хангах ажлыг холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотой зохион байгуулах; - Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, дотоод үйл ажиллагаа, харилцааны таатай уур амьсгал бүрдүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах; - Суралцагчдын өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; - Сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн орчинд нийгэм-сэтгэл зүйн таатай уур амьсгал бүрдүүлэх; - ... 		
------------------------------	---	--	--

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	1200-аас доош суралцагчтай сургуульд: дээд, бакалаврын болон түүнээс дээш зэрэгтэй байх; 1201- ээс дээш суралцагчтай сургуульд: дээд, магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх.
Мэргэжил	Боловсролын шинжлэх ухаан /0111/, Багш, мэргэжлийн /0113, 0114/, Байгалийн шинжлэл ухаан /0511, 0512, 0531, 0533, 0541/, Мэдээллийн технологи /0611, 0612, 0613/ Хүмүүнлэг /0222/ Хэл /0231, 0232/
Мэргэшил	Боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх
Туршлага	Багшлах болон удирдах ажлын туршлагыг заавал тусгах ба туршлагын шаардлагын доод жишгийг тогтоохдоо сургуулийн

	<p>суралцагчийн тоо, сургуулийн хэв шинж, хамран сургалтын хүрээ зэргээс хамаарч доорх байдлаар тогтоож болно.</p> <ul style="list-style-type: none"> - 160 хүртэл суралцагчтай сургуульд: ерөнхий боловсролын сургуульд 3-аас доошгүй жил багшилсан, заах аргач ба түүнээс дээш зэрэгтэй, 1-ээс доошгүй жил Заах аргын нэгдлийн ахлагчаар ажилласан байх; - 161-640 суралцагчтай сургуульд: ерөнхий боловсролын сургуульд 5-аас доошгүй жил багшилсан, заах аргач ба түүнээс дээш зэрэгтэй, 2-оос доошгүй жил Заах аргын нэгдлийн ахлагч эсхүл сургалтын менежерээр ажилласан байх; - 641-1200 суралцагчтай сургуульд: ерөнхий боловсролын сургуульд 5-аас доошгүй жил багшилсан, тэргүүлэх ба түүнээс дээш зэрэгтэй, 3-аас доошгүй жил удирдах ажил эрхэлсэн ажилласан байх; - 1201-1500 суралцагчтай сургуульд: ерөнхий боловсролын сургуульд 6-аас доошгүй жил багшилсан, тэргүүлэх ба түүнээс дээш зэрэгтэй, 4-өөс доошгүй жил удирдах ажил эрхэлсэн ажилласан байх; - 1501-дээш суралцагчтай сургуульд: ерөнхий боловсролын сургуульд 8-аас доошгүй жил ажилласан, тэргүүлэх ба түүнээс дээш зэрэгтэй, 4-өөс доошгүй жил удирдах ажил эрхэлсэн туршлагатай байх. <p>Удирдах ажлын туршлагад- ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, боловсролын газрын албаны дарга, даргын албан тушаалд ажилласан туршлагыг авч үзнэ.</p>
<p>Ур чадвар</p>	<p>Асуудал шийдвэрлэх:</p> <ul style="list-style-type: none"> -Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй, шийдвэр гаргах; -Шийдвэрийн үр дагаврыг урьдчилан тооцоолох; -Гаргасан шийдвэрийн үр дагаврыг хариуцах; -Маргаан, саналын зөрүүг эв зүйгээр шийдвэрлэх <p>Манлайлах:</p> <ul style="list-style-type: none"> -Шударга ёсыг сахих; -Ёс зүйгээр үлгэрлэх; -Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч байх; -Ажлын шинэ арга барилыг нэвтрүүлэх, хөгжүүлэх; -Хувийн зохион байгуулалт сайтай; -Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд өөрөө үлгэрлэн, манлайлах <p>Багаар ажиллах, удирдах:</p> <ul style="list-style-type: none"> -Харилцааны ур чадвартай; -Зорилго, зорилтод нийт багш ажилтныг нэгтгэх; -Мэдээллийг багш, ажилтанд нарт тэгш хүргэх; -Албан хаагч бүрийн оролцоог жигд хангах; -Албан хаагч нарыг сэдэлжүүлэх, урам зориг өгөх; <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> • Баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвартай байх;

	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн технологийг ажил хэрэгтээ ашиглах чадвартай байх; • Гадаад аль нэг хэлээр мэдээлэл ашиглах, боловсруулах, албан бичгээр харилцах чадвартай байх;
--	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: <ul style="list-style-type: none"> - Сургалтын менежер - Багш нар - Нийгмийн ажилтан - Үйлчилгээний ажилчид - 	Бусад харилцах субъект <ul style="list-style-type: none"> - Аймаг, нийслэлийн Боловсролын газар - Аймаг, нийслэл, сум дүүргийн засаг дарга, Тамгын газар - Төрийн болон төрийн бус байгууллага - Иргэд -

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал:	Байгууллагын нэр:
	Шийдвэрийн огноо:
	Дугаар:
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр:	
Шийдвэрийн огноо.	
Дугаар	
(тамга/тэмдэг)	
(Гарын үсэг)	(Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	



Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2020 оны 07 дугаар сарын 20-ны
өдрийн 5/03 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН МЕНЕЖЕРИЙН АЛБАН ТУШААЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Ерөнхий боловсролын сургууль

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Сургалтын менежер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮБД-4

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн тухай хуулийн 70.2

Тухайн ерөнхий боловсролын
сургуулийн улсын бүртгэлийн
гэрчилгээний хаяг

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, багшийн мэргэжлийн хөгжил, боловсролын мэдээллийн сангийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион

байгуулах, тайлагнах, үнэлэх ажлыг удирдан зохион байгуулах
Албан тушаалын зорилт:
<ol style="list-style-type: none"> 1. Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ, аргазүйн хэрэгжилтийг сургуулийн хэмжээнд урт болон дунд, богино хугацаагаар төлөвлөх, сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил аргазүйн удирдлагаар хангах; 2. Багшийн хөгжлийг дэмжих сургуулийн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох; 3. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчийн сурлагын чанарт хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ дүгнэлт өгөх, зөвлөмж, аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх; 4. Боловсролын статистик мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, боловсролын салбарын мэдээллийн системд сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх, тогтмол шинэчлэн хөтлөх, тайлагнах;

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Зорилго	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр
Нэгдүгээр зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн сургалтын бодлого, стратегийн зорилт, сургалтын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангах; - Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй, үнэлгээний хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Боловсролын газрын удирдлага дор зохион байгуулж, үр дүнг тайлагнах; - Салбарын бодлого, хууль тогтоомж, сургалтын чиглэлээр батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм журам, аргачлалын хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах; - Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд үндэслэн сургуулийн хэв шинж, багшийн мэргэжил, ур чадвар, суралцагчдын хэрэгцээ сонирхолд тулгуурласан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх; - Сургалтын үйл явцын зохион байгуулалтыг хичээлийн жил, улирлаар төлөвлөн хичээлийн хуваарь батлах, хэрэгжилтэд хяналт тавих; - Сургуулийн хэв шинжид нийцүүлэн, анги бүлгийн менежментийг оновчтой тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих; 		

	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн мэргэжил арга зүйн нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах; - Сургуулийн сургалтын үйл явцад өдөр тутмын зохицуулалт хийх, хяналт тавих; - Суралцагчийг анги дэвшүүлэн суралцуулах, сургууль төгсгөх асуудлыг Багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, санал дүгнэлтийг удирдлагад танилцуулах; - Сургалтын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон зохих байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх; - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин, аргазүй бүрдүүлэх - 		
<p>Хоёрдугаар зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн багшийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, багшийн мэргэжил дээшлүүлэх төлөвлөгөөг урт болон дунд, богино хугацаагаар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах; - Хөгжлийн чиг хандлагад баримжаалан, хичээл, сургалтын зохион байгуулалт, сургалтын арга зүй, технологи, хэрэглэгдэхүүн үнэлгээ, сургалтын орчны хөгжлийн асуудлаар багш, ажилтныг мэдээллээр хангах, дэвшилтэт аргазүй, технологийг турших, нэвтрүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжих, зөвлөн туслах; - Багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл/тэнхимийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдлага аргазүйгээр хангах, хяналт тавих, зөвлөн туслах; - Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдлага зохицуулалтаар хангах; - Багш нарын хичээлийн бэлтгэлд хяналт тавих, хичээл сургалтын үйл явц, үр дүн, ур чадварын хөгжилд ажиглалт, судалгаа, шинжилгээ хийх, зөвлөн туслах; - Багшийн хөдөлмөрийн үр дүн, ур чадварыг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцоход дүгнэлт санал боловсруулж, танилцуулах; - Багш, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжилтийг хангахад сургуулийн удирдлагад дэмжлэг үзүүлэх; - Багшийг ажлын байран дээр суралцах, хамтран ажиллах, ур чадвараа хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, дүгнэх, тайлагнах; - Багшийн бүтээлч үйл ажиллагааг сурталчилан таниулах, урамшуулах, шилдэг арга зүй, технологийг түгээн дэлгэрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах; 		

	<ul style="list-style-type: none"> - Багшид мэргэжлийн зэрэг олгох, сунгах, цуцлах асуудлыг Багш нарын зөвлөлд хэлэлцүүлэх, санал дүгнэлтийг сургуулийн удирдлагад танилцуулах; - Багш мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зөрчих, авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах - 		
Гуравдугаар зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Сургалтын үйл ажиллагааны дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, арга зүйн удирдамжаар хангах; - Сургууль, багшийн үйл ажиллагаа, сургалтын чанар, төгсөгчдийн чанар, боловсролын хүртээмж, үр дүнгийн үзүүлэлтийг тогтмол хянах, шинжилгээ хийх, график төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх, тайлагнах; - Сургалтын хөтөлбөрт анализ хийж, үнэлгээ өгөх, зөвлөмж, аргачлалаар хангах; - Үнэлгээний даалгавар боловсруулах, сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх; - Сургуулийн сургалтын үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд тайлагнаж, мэдээлэх; - Улсын шалгалт, анги дэвших шалгалтыг төлөвлөх, зохион байгуулах, дүнд шинжилгээ хийх, тайлагнах - ... 		
Дөрөвдүгээр зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Боловсролын болон сургалтын баримт бичгийг хөтлөх, олгохтой холбоотой дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах; - Боловсролын статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах ажлыг сургуулийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжил аргазүйн удирдлагаар хангах, тайлагнах; - Сургалтын баримт бичиг болох сурагчийн хувийн хэрэг, ангийн журналыг хөтлөх журмын хэрэгжилтийг зохион байгуулах, удирдлага, аргазүйгээр хангах; - Боловсролын салбарын мэдээллийн системд сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх, тогтмол шинэчлэн хөтлөх, тайлагнах; - Боловсролын болон сургалтын баримт бичиг, бүртгэл мэдээллийг холбогдох дүрэм журмын дагуу архив бүрдүүлэх, хадгалуулах ажлыг хариуцах; - 		

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол Дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй байх

Мэргэжил	Боловсрол судлал, багш мэргэжил эзэмшсэн байх /0111, 0113, 0114/ Байгалийн шинжлэл /0511,0512, 0533,0541/
Мэргэшил	Боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх
Туршлага	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий боловсролын сургуульд үндсэн орон тоонд 5-аас доошгүй жил багшилсан байх; • 2-оос доошгүй жил заах аргын нэгдэл /тэнхим/ удирдаж ажилласан туршлагатай байх; • Заах аргач ба түүнээс дээш зэрэгтэй байх.
Ур чадвар	<p>Асуудал шийдвэрлэх:</p> <ul style="list-style-type: none"> -Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй, шийдвэр гаргах; -Шийдвэрийн үр дагаврыг урьдчилан тооцоолох; -Гаргасан шийдвэрийн үр дагаврыг хариуцах; -Маргаан, саналын зөрүүг эв зүйгээр шийдвэрлэх <p>Манлайлах:</p> <ul style="list-style-type: none"> -Шударга ёсыг сахих; -Ёс зүйгээр үлгэрлэх; -Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч байх; -Ажлын шинэ арга барилыг нэвтрүүлэх, хөгжүүлэх; -Хувийн зохион байгуулалт сайтай; -Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд өөрөө үлгэрлэн, манлайлах <p>Багаар ажиллах, удирдах:</p> <ul style="list-style-type: none"> -Харилцааны ур чадвартай; -Зорилго, зорилгод нийт багш ажилтныг нэгтгэх; -Мэдээллийг багш, ажилтанд нарт тэгш хүргэх; -Албан хаагч бүрийн оролцоог жигд хангах; -Албан хаагч нарыг сэдэлжүүлэх, урам зориг өгөх; <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> • Баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвартай байх; • Мэдээллийн технологийг ажил хэрэгтээ ашиглах чадвартай байх; • Гадаад аль нэг хэлээр мэдээлэл ашиглах, боловсруулах, албан бичгээр харилцах чадвартай байх;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: <ul style="list-style-type: none"> • Сургалтын менежер • Нийгмийн ажилтан • Багш, дотуур байрын багш • Нягтлан бодогч, нярав • Үйлчилгээний ажилтан 	Бусад харилцах субъект <ul style="list-style-type: none"> • Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны газар, хэлтэс • Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар • Аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс • Багшийн мэргэжил дээшлүүлэх институт • Боловсролын хүрээлэн • Бусад төрийн болон төрийн бус байгууллагууд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаал:</u>	<u>Байгууллагын нэр:</u>
	<u>Шийдвэрийн огноо:</u>
	<u>Дугаар:</u>
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр:	
Шийдвэрийн огноо:	
Дугаар	
(тамга/тэмдэг)	
(Гарын үсэг)	(Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр)
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2020 оны 07 дугаар сарын 20-ны
өдрийн 07/03 дугаар тушаалын
3 дугаар хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ АЛБАН ТУШААЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Ерөнхий боловсролын сургууль

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Сургуулийн нийгмийн ажилтан

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮБД-3

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн тухай хуулийн 70.2

Тухайн ерөнхий боловсролын
сургуулийн улсын бүртгэлийн
гэрчилгээний хаяг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсролын салбарын болон хүүхэд хөгжил, хамгааллын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг сургуулийн хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах тайлагнах, үнэлэх ажлыг удирдан зохион байгуулах

Албан тушаалын зорилт:

1. Боловсролын салбарын болон хүүхэд хамгааллын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг сургуулийн хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах;
2. Хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх;
3. Хүүхдийн хөгжил, төлөвшил, сонирхол хэрэгцээнд тулгуурлан хичээлээс гадуурх сургалтын ажлыг төлөвлөх, арга зүйн удирдлагаар хангах;

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Зорилго	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэл ийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр
Нэгдүгээр зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын стратегийн төлөвлөгөө, болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүүхэд хөгжил хамгаалал, нийгмийн ажлын чиглэлээр зорилго, зорилтыг тусгуулж батлуулах, хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах; - Сургуулийн хүүхэд хөгжил хамгааллын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, тайлагнах, хүүхэд хамгааллын багийн бүрэлдэхүүнд арга зүйн дэмжлэг үзүүлэх; - Суралцагчийн эрх, хөгжил, хамгаалал, нийгмийн ажлын үйлчилгээний чиглэлээр сургуулийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах, зөвлөлийг мэргэжил, аргазүйн дэмжлэгээр хангах; - Хүүхэд хамгаалал, нийгмийн ажлын чиглэлээр сургуулийн дотоод эрх зүй, зохицуулалтын баримт бичгийг боловсруулах, батлуулах, мөрдүүлэх; - Боловсрол, нийгмийн ажил, хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах; - Хариуцсан ажлын чиглэлээр мэдээ, мэдээллийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, байгууллагын болон хувь хүний нууцыг хамгаалах арга хэмжээг авах; - Хүүхдийн эрх, хамгааллын хууль тогтоомж, нийгмийн ажлын үр дүнг багш, суралцагч, эцэг эх, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтэд сурталчлах; - Сургууль, дотуур байранд хүүхдэд үзүүлж байгаа үйлчилгээний эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг биелүүлэхэд багш ажилтантай хамтран ажиллах; - Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; 		

	<ul style="list-style-type: none"> - Бусад төрийн байгууллагад ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг шуурхай, чанартай бэлтгэж, хүргүүлэх; - ... 		
<p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Хоёрдугаар зорилтын хүрээнд.</p>	<ul style="list-style-type: none"> - Хамран сургах тойргийн зорилт болон эмзэг бүлгийн нөхцөлд байгаа хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх; - Сургалтын орчинд хүүхдийг бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, сургууль завсардах, тэвчишгүй хүнд хөдөлмөрт татагдан орох, нийгмийн болон цахим орчинд үйлдэгдэх гэмт хэрэг эрх зүйн зөрчилд холбогдох, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургуулийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх; - Багш, ажилтанд хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэх эерэг арга барил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах чиглэлээр зөвлөгөө өгөх; - Багш, ажилтан, суралцагчдын хоорондын сөрөг харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, сургуулийн удирдлага, гэр бүлд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах; - Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байхыг багш, ажилтан, эцэг эхэд чиглэл, зөвлөгөө өгөх, шаардлага тавих; - Суралцагчийг сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчил, согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах, хяналт тавих; - Сургуулийн орчинд хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаалах арга хэмжээ авах; - Худалдаа үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, сургууль орчны замын хөдөлгөөн, шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, зохион байгуулагч багш ажилтанд заавар, зөвлөгөө өгөх; - Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх, тэдний эрх 		

	<p>ашгийг хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран арга хэмжээ авах;</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомж зөрчсөн талаар мэдээлэх, зөрчлийг арилгуулахаар суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон зохих байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх, зөвлөн туслах, чиглэл заавар өгөх; - Сургуулийн хүүхэд хамгааллын нөхцөл байдалд жилд нэг удаа дүн шинжилгээ хийж, авах арга хэмжээний саналыг сургуулийн удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх; - Насан туршийн боловсролын сургалтанд хамрагдагчдад нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх; - Суралцагчдын хөгжил, төлөвшил, нийгэмшихүйд нийцүүлэн хүүхэд хамгааллын хууль эрхзүйн мэдлэг олгох, мэдлэгээ хуваалцах олон талт ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, тайлагнах; <p>- ...</p>		
<p>Гуравдугаар зорилтын хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн хичээлээс гадуурх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, бэлтгэл хангах, анги хамт олныг татан оролцуулах, тайлагнах; - Хүүхдийн хөгжил, төлөвшил, нийгэмших үйл явцыг хичээл болон хичээлээс гадуурх сургалтын ажилд харгалзан үзэх, зохион байгуулахад сургалтын менежер, багш нар /секц, заах аргын нэгдэл/-т мэргэжлийн чиглэл, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах; - Анги удирдсан багштай хамтран суралцагчдыг судлах, оношлох зорилтот (эрсдэлт) бүлгийн хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлэх, хүүхдийг эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, багш нарын анги удирдах ур чадварыг дүгнэх ажлыг хэрэгжүүлэх; - Сургалтын орчин, дотуур байранд хүүхэд бүрийг сурах, хөгжих, амьдрах, хамгаалуулах тэгш боломжоор хангагдаж буй эсэхэд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; - Суралцагч хоорондын болон багш-суралцагч, суралцагч - эцэг эх, багш-эцэг эхийн харилцааны зөрчлийг зөрэг арга замаар шийдвэрлэхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх; - Хүүхдэд сэтгэлзүй болон эрүүл мэнд, хөгжил төлөвшлийн асуудалд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг даван туулахад нь зөвлөн туслах, дэмжих, эцэг эхэд нь мэргэжлийн зөвлөгөө өгөх; 		

	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, анги хамт олны хамтын ажиллагааг зохион байгуулахад нь хүүхдийн байгууллага, багш нарт дэмжлэг үзүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх; - Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах; - Хүүхдийг хөгжүүлэх, нийгэмшүүлэх, амьдрах чадвар эзэмшүүлэх, эрсдэлт бүлгийн хүүхдэд дэмжлэг, тусламж үзүүлэх ажилд олон нийт, төрийн бус байгууллагыг татан оролцуулах, идэвх санаачилгыг өрнүүлэх; - Суралцагчдаас авсан судалгаанд үндэслэн, тэдний хэрэгцээ сонирхолд нийцсэн дугуйлан, сургалт, секц, соёл хүмүүжлийн ажлыг төлөвлөх, секц дугуйлан удирдаж буй багш нартай хамтран ажиллах, мэргэжил аргазүйн зөвлөгөө дэмжлэг өгөх; - Хүүхдийг төлөвшүүлэх, хамгаалах, хөгжүүлэх ажлын үр дүн, чанарыг сайжруулах талаар сургуулийн зөвлөлтэй хамтран ажиллах; Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх орчин, нөхцөлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт саналыг удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх 		
--	---	--	--

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд боловсролтой, бакалаврын зэрэгтэй байх
Мэргэжил	Нийгмийн ажилтан мэргэжил эзэмшсэн байх /0923/
Мэргэшил	Нийгмийн ажил, нийгмийн удирдлага
Туршлага	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн ажлын чиглэлээр ... дээш доошгүй жил ажилласан • Нийгмийн ажлын дадлага хийсэн туршлагатай • Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнаар ажилласан туршлагатай бол давуу тал болно.
Ур чадвар	<p>Багаар ажиллах, багийг удирдан зохион байгуулах чадвар:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын зорилго, зорилтод нийгмийн ажлын зорилгыг уялдуулах; - Байгууллагын хөгжилд хамт олныг чиглүүлэх, манлайлах - Байгууллагын соёлыг дээшлүүлэх, олон нийтийн арга хэмжээнд багш, ажилтны оролцооны тэгш байдлыг хангах; - Багш, ажилтнууд, суралцагчдыг сэдэлжүүлэх, урам зориг өгөх. <p>Асуудал шийдвэрлэх чадвар:</p> <ul style="list-style-type: none"> - Боловсрол, хүүхэд хөгжил, хамгааллын асуудлаар хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргахад нь сургуулийн удирдлагад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх; - Тулгарсан асуудал, маргаан, саналын зөрүүг байгууллагын зорилго, оролцогч талуудын нийцэл, ойлголцол, оролцоог

	<p>хангаж шийдвэрлэх; Манлайлах чадвар: - Харилцаа, хандлага, хувийн зохион байгуулалтаар үлгэр дууриал үзүүлэх; - Ёс зүйгээр бусдыг үлгэрлэх; - Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч байх; - Ажлын шинэ арга барилыг нэвтрүүлэх, хөгжүүлэх; - Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд өөрөө үлгэрлэн, манлайлах; Бусад: - Баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвартай байх; - Мэдээллийн технологийг ажил хэрэгтээ ашиглах чадвартай байх; - Гадаад хэлээр мэргэжлийн мэдээлэл ашиглах чадвартай байх;</p>
--	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект
--	--------------------------------

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал:	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо. Дугаар (тамга/тэмдэг) (Гарын үсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, САНГИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ
МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны 08 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 78, 149 А/16А А/14 А/19А

Улаанбаатар
хот

Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, шаардлагатай журам, заавар, удирдамжийг баталж мөрдүүлэх, санхүү төсөв, дэд бүтэц, хүний нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Эрүүл мэндийн дэд сайд Ш.Анхмаа нарт тус тус үүрэг болгосугай.

2. Хичээл, сургалтын үйл ажиллагаа удаан хугацаанд завсарласны улмаас багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад гарч болзошгүй айдас, түгшүүр, эргэлзээг тайлах, тайвшруулах нийгэм-сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагааг гэр бүлд түшиглэн 2020 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс хоёр сарын хугацаатай зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Ганзориг/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /М.Энх-Амар/, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /Л.Насанцэнгэл/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн нөхцөлд бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг үе шаттайгаар эхлүүлэхтэй холбогдуулан шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судлан, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Төрийн болон төрийн бус өмчийн хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгөөр хийгдэж буй барилга угсралт, их засвар, тохижилтын ажлыг хичээлийн жил эхлэхээс өмнө бүрэн дуусгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, их, дээд сургууль, коллежийн сургалтын төлбөр, хураамжийг эцэг эх, асран хамгаалагчдад санхүүгийн дарамт үүсгэхгүйгээр сар, улирлаар төлөх уян хатан зохицуулалт хийх арга хэмжээ авахыг их, дээд

сургуулийн консорциум, өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагын удирдах ажилтан нарт үүрэг болгосугай.

6. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах чиглэлээр ариун цэврийн байгууламжийн хүртээмж, аюулгүй байдал, орчны эрүүл ахуйг сайжруулах, гар угаах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

7. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, их, дээд сургууль, коллежийн бакалаврын хөтөлбөрт өдрөөр элсэн суралцах оюутан, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн суралцагчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, цэцэрлэгт хамрагдах хүүхдийг эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах ажлыг бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулахыг Эрүүл мэндийн дэд сайд Ш.Анхмаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

8. Бүх шатны сургалтын байгууллагын халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, зөвлөгөө мэдээллээр хангах, холбогдох нийтлэг шаардлагуудыг баримтлах, хичээл эхлэх бэлэн байдалд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд Ш.Анхмаа, аймаг, нийслэлийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Т.Гантулга/-т даалгасугай.

9. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг холбогдох яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Т.Гантулга/-т тус тус үүрэг болгосугай.

10. Тушаалын хэрэгжилтийн явц, үр дүнг 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдөрт багтаан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян нарт тус тус даалгасугай.





МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 17/17

Улаанбаатар хот

Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх
бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15.1 дэх хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ыг нэгдүгээр, “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээл, сургалтын үйл ажиллагааны бэлтгэлийг хангахтай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох нэгж, байгууллагад тус тус үүрэг болгосугай:

2.1. Энэ тушаалын нэг дэх хэсэгт заасан журмыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүргүүлж, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулах арга хэмжээ авахыг яамны Сургуулийн өмнөх боловсрол, Бага, дунд боловсролын асуудал хариуцсан нэгж, аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт;

2.2. Сургалтын хөтөлбөрийн дагуу өмнөх ангид судалсан байвал зохих агуулгыг бататгах арга зүйн сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн багш нарт 2020 оны 8 дугаар сарын хоёрдугаар хагаст цахим хэлбэрээр зохион байгуулахыг яамны Сургуулийн өмнөх боловсрол, Бага, дунд боловсролын асуудал хариуцсан нэгж, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;

2.3. Цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад зориулсан теле хичээлийг Монголын телевизүүдийн холбоотой хамтран бүрэн, чанартай бэлтгэн зохион байгуулахыг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;

2.4. Цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас нэг хичээлийн жилд бэлтгэх хичээлийн хэрэглэл, ариун цэврийн хэрэгслийг санхүүгийн дарамт үүсгэхгүйгээр улирлаар авах зохицуулалт хийхийг яамны Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан нэгжид;

142010077

2.5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль орчмын бүсэд орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсгээр эрсдэлийн үнэлгээ хийлгэж, хичээлийн жил эхлэхээс өмнө аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсрол сургуулийн захирал нарт;

2.6. Коронавируст халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах менежментийн сургалтыг эрүүл мэнд, онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт зохион байгуулахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт;

2.7. Онцгой нөхцөл байдлын үеийн боловсролын эрсдэлийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран сар бүр зохион байгуулж, хариу арга хэмжээ авч ажиллахыг яамны Сургуулийн өмнөх боловсрол, Бага, дунд боловсролын асуудал хариуцсан нэгжид;

2.8. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлбөр, хураамжийг эцэг эх, асран хамгаалагчдад санхүүгийн дарамт үүсгэхгүйгээр харилцан тохиролцож гэрээ байгуулан төлөх уян хатан зохицуулалт хийхийг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт.

3. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг хичээл, сургалтын үйл ажиллагаа хэвийн горимд шилжих хүртэл хугацаанд өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаярт даалгасугай.

САЙД  Л.ЦЭДЭВСҮРЭН

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн
А/147 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЦЭЦЭРЛЭГИЙН СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ТҮР ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Коронавируст халдварын цар тахлаас хамаарсан онцгой нөхцөл байдалд өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг /цаашид цэцэрлэг гэх/-ийн 2020-2021 оны хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад энэхүү түр журмыг мөрдөнө.

1.2. Энэхүү түр журам нь цэцэрлэг онцгой нөхцөл байдалд сургалт, үйл ажиллагаа явуулах үеийн зохицуулалт, хүний нөөц, анги танхимын бэлэн байдлыг хангах, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм баримтлах зэрэг асуудлыг хамарна.

1.3. Түр журмыг хэрэгжүүлэхэд сургалт, үйл ажиллагаанд оролцогч талууд халдвар хамгааллын дэглэм баримтлах, хүүхдэд суралцах адил тэгш боломж олгох, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, эрүүл мэнд, онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагаас баталсан журам, зааврыг хэрэгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэг авах зарчим баримтална.

1.4. Цэцэрлэг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сургалт, үйл ажиллагааг эхлүүлэх бэлэн байдлыг хангах төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөнд тухай бүр тодотгол хийж бэлэн байдлыг хангана.

1.5. Цэцэрлэг нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/140 дүгээр тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж"-ийг баримтлан ажиллана.

Хоёр. Сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Цэцэрлэгийн үндсэн бүлгийн сургалт, үйл ажиллагааг танхимын хэлбэрээр зохион байгуулах ба энэ хугацаанд хувилбарт сургалт зохион байгуулахгүй.

2.2. Цэцэрлэгт нэг хүүхдэд ногдох талбай 1-1,5 м² байхаар тооцож, нэг бүлэгт 20-25 хүүхэд хүлээн авна.

2.3 Цэцэрлэгт 5 настай хүүхдийг бүрэн, өмнөх хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдаж байсан 3-4 настай хүүхдийг үргэлжлүүлэн хүлээн авах ба 3 хүртэлх настай хүүхдийг гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгт тулгуурлан хөгжлийг дэмжинэ.

2.4 Цэцэрлэг нь анги танхимын хүрэлцээ, боломжид тулгуурлан нэмж 3-4 насны хүүхэд элсүүлэх тохиолдолд баг, хорооны Засаг даргын тодорхойлолтод үндэслэн зорилтот өрхийн хүүхдийг хамруулна.

2.5. Төрийн өмчийн цэцэрлэгийн нэг бүлэгт байх хүүхдийн тоо 25-аас хэтэрсэн тохиолдолд ойр байрлах бусад төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгт тухайн хүүхдийг шилжүүлэн хамруулж болно.

2.6. Эцэг эх, асран хамгаалагчаас цэцэрлэгт хүүхдээ хамруулахаас татгалзах албан ёсны хүсэлтээ бичгээр гаргасан тохиолдолд тусгайлан гэрээ байгуулж, теле хичээлийг үзэж, хүүхдийнхээ хөгжлийг дэмжих, багштай эргэх холбоотой ажиллах талаар зөвлөгөө өгнө.

2.7. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд зориулж теле хичээлийг үндэсний хэмжээнд зохион байгуулна.

2.8. Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа 8-10 цаг байна.

2.9. Цэцэрлэг өдрийн дэглэмийг онцгой нөхцөлд байдалд нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлнэ.

2.9.1. Цэцэрлэгийн байр танхимаас гарч, аялал зугаалга зохион байгуулахгүй.

2.9.2. Өдрийн дэглэм дэх хүүхдийн хооллох, нойрсох, эрүүл ахуйн үйл ажиллагаанд онцгой анхаарч, цагийг баримтална.

2.9.3. Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтныг хамруулсан аливаа уралдаан тэмцээн зохион байгуулахгүй.

2.10. Онцгой нөхцөл байдлын үед цэцэрлэгийн багш, туслах багш, тогооч, эмч, хамгаалагчийн ажлын чиг үүргийг хамт олны хурлаар нарийвчлан тогтоож, цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар баталж мөрдөнө.

2.11. Онцгой нөхцөл байдалд сургалт, үйл ажиллагаатай холбоотой тогтоосон дэгийг цэцэрлэгийн эцэг эх, асран хамгаалагчдад таниулах, сахиулах, хяналт тавих ажлыг цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч хариуцна.

2.12. Боловсролын хүрээлэнгээс хүргүүлсэн арга зүйн зөвлөмжийн дагуу хичээлийн жилийн эхний сард теле хичээлээр эзэмшсэн агуулгыг бататгах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулна.

2.13. Сургуулийн өмнөх боловсролын теле хичээлийн хуваарийг эцэг эх, асран хамгаалагчдад хүртээмжтэй хэлбэрээр ил тод байршуулж, мэдээлнэ.

2.14. Цэцэрлэгийн хөгжим, биеийн тамирын сургалтыг бүлгийн өрөөнд, хүүхэд ядрах, ачаалал авах, хөлрөх зэргээс сэргийлэн, эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.

2.15. Сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхэд дамжуулан хэрэглэхгүй байхад анхаарч, хүүхэд бүрд хүртээмжтэй байхаар зохицуулна.

2.16. Цэцэрлэгийн хөгжим, биеийн тамирын танхимыг шаардлагатай тохиолдолд бүлгийн зориулалтаар ашиглаж болно.

2.17. Хүүхдийн хоол, хүнсэнд түргэн гэмтэх бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй бөгөөд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн шим тэжээллэг, амин дэмээр баялаг бүтээгдэхүүн, халуун ундаа сонгож хэрэглэнэ.

2.18. Хичээлийн жилд эцэг эхээс гаргуулах ариун цэврийн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг эхний 3 сард хэрэглэгдэх хэмжээгээр бэлтгүүлэн, авч ариутгал халдваргүйтгэл хийж хэрэглэнэ.

2.19. Гадаад улсаас Монгол улсад ирж цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдэд монгол хэлээр суралцах, цэцэрлэгийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлнэ.

Гурав. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх

3.1. Эрүүл мэнд, онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг ил тод байршуулж, мөрдөнө.

3.2. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ын дагуу багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаа эхлэхээс өмнө бүрэн хамруулсан байна.

3.3. Хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулна.

3.4. Цэцэрлэгийн хаалга, хонгил, нийтийн эзэмшлийн зам талбайд зай барих тэмдэг, тэмдэглэгээ заавал хийсэн байна.

3.5. Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаа эхлэхээс өмнө мэргэжлийн байгууллагаар ундны усны дүгнэлт гаргуулах, шавж мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн байна.

3.6. Шаардлагатай цэгүүдэд (ариун цэврийн өрөө, нийтийн эзэмшлийн талбай, хоол үйлдвэрлэх хэсэг, хувцас өлгөх, анги танхим бүрд, орох гарах хаалганы хажууд) гар халдваргүйжүүлэх уусмалыг байршуулна.

3.7. Цэцэрлэгийн орох хаалга, хонгил хэсэг, ажилчдын ариун цэврийн байгууламжийн орчимд гар халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцээтэй байлгаж, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлнэ.

3.8. Сургалт, үйл ажиллагаа эхлэхээс өмнө эмч, багш нь хүүхдийн эрүүл мэндийн талаар эцэг эх, асран хамгаалагчаас батлагдсан асуумжийн хуудсаар мэдээлэл авч, хичээлийн жилийн эхний 7 хоногт багтаан нэгтгэж, дүнг цэцэрлэгийн эрхлэгчид танилцуулна.

3.9. Цэцэрлэгт ирэх, буцах замд багш, ажилтан, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч амны хаалт заавал хэрэглэнэ.

3.10. Багш ажилтан, хүүхэд цэцэрлэгт нэвтрэхэд биеийн халууныг тогтмол хэмжиж тэмдэглэл хөтлөн, гарыг халдваргүйжүүлнэ.

3.11. Анги танхимд чийгтэй цэвэрлэгээ 2 цаг тутамд хийх бөгөөд салхивчаар агаар сэлгэлт хийнэ.

3.12. Сургалт, үйл ажиллагаа тарсны дараа, хүнгүй үед анги, танхимыг кварцын гэрлээр халдваргүйжүүлэх ажлыг тусгай цагийн хуваарийн дагуу аюулгүй ажиллагааны дүрмийг чанд баримтлан хийнэ.

3.13. Хүүхдийн ам, хоолойг сод, давсны уусмалаар тогтмол зайлуулж, ам, хоолой зайлах аяганы цэвэрлэгээ, ариутгал, хадгалалтын шаардлагыг сайтар хангана.

3.14. Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэглэл, аяга тавгийг хүнсний содын уусмалаар угааж, ариутгана.

3.15. Анги танхимын хатуу, зөөлөн эдлэлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг эрүүл мэндийн байгууллагын заавар, зөвлөмжийн дагуу 7 хоногт хоёроос доошгүй удаа хийнэ.

3.16. Хүүхэд өөр хоорондоо аяга халбагыг дамжуулан хэрэглэхгүй байхад анхаарч ажиллана.

3.17. Хүүхдэд гэрээсээ уух, идэх зүйл, тоглоом авч ирэхгүй байх талаар багш, туслах багш эцэг эх, асран хамгаалагчид зөвлөх бөгөөд авч ирсэн тохиолдолд оруулахгүй.

3.18. Хүүхдийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг өдөр бүр цэвэрлэж ариутгах ба угааж цэвэрлэх боломжгүй тоглоомыг ангид байлгахгүй.

3.19. Хүүхдийг унтуулахдаа толгойгоор нь нийлүүлэхгүй байх, орыг зайтай байрлуулна.

3.20. Хүүхдийг цэцэрлэгт ирэхэд гадуур хувцсыг уутанд хийж, шүүгээнд өлгөнө.

3.21. Багш, ажилтан, хүүхэд цэцэрлэгт ханиалгах, халуурах, амьсгал давчдах, хоолой өвдөх зэрэг өвчний шинж тэмдэг илэрсэн үед анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх түр тусгаарлах өрөө гаргаж, бэлэн байдлыг хангана.

3.22. Хүүхэд эцэг эх, асран хамгаалагчдыг цэцэрлэгийн байранд орох, гарахад олноороо нэг дор цугларахгүй байхаар боломжит бүх хаалгыг ашиглах зохицуулалт хийж, чиглэл заасан зураглалаар мэдээлэл өгнө.

3.23. Онцгой нөхцөл байдалд гадны хүнийг цэцэрлэгийн байр, анги танхимд нэвтрүүлэхийг хориглоно.

3.24. Цэцэрлэгийн орчинд амны болон нүүрний хаалт, гар халдваргүйжүүлэгч, бээлий, улавч гэх мэтийг худалдан борлуулахыг хориглоно.

Дөрөв. Сургалт, үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг, оролцоо

4.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах сургалтад багш, ажилтныг бүрэн хамруулах ажлыг цэцэрлэгийн удирдлага зохион байгуулна.

4.2. Цэцэрлэгийн эмч нь арга зүйч, багштай хамтран халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, эцэг эх асран хамгаалагчдад зөвлөгөө, мэдээлэл өгнө.

4.3. Цэцэрлэгийн эмч нь бүлгүүдийн хүүхдийн ирц, анги танхимын ариутгал цэвэрлэгээ, хоол хүнсний чанарт тогтмол хяналт тавина.

4.4. Цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэх, түгээх ажлыг хариуцан гүйцэтгэж буй ажилтнууд нэг удаагийн бээлий, амны болон нүүрний хаалт хэрэглэнэ.

4.5. Багш, туслах багш нь өглөө бүр хүүхдийг хүлээн авахдаа тэдний эрүүл мэндийн байдлыг эцэг эх, асран хамгаалагчаас мэдээлэл авч, халууныг үзэх ба бүлгийн багш хүүхдийн ирц, эрүүл мэндийн байдлаар тэмдэглэл хөтөлнө.

4.6. Хүүхэд цэцэрлэгтээ ирээгүй бол эцэг эх, асран хамгаалагчтай холбоо тогтоож шалтгааныг тодруулж, тэмдэглэлд бичнэ.

4.7. Цэцэрлэгийн туслах багш өрөө, тасалгаанд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу тогтмол хийх бөгөөд багш, туслах багш нь хүүхдийн эрүүл мэндийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд цэцэрлэгийн эмчид мэдээлэл өгч ажиллана.

4.8. Хүүхэд өглөө цэцэрлэгт ирэх үед болон ирсний дараа халуурсан, ханиалгасан, нүд улайсан зэрэг шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчид яаралтай мэдэгдэж, хүлээлгэн өгнө.

4.9. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдэдээ амны хаалт зүүлгэж, гарыг тогтмол угаалгаж халдвараас урьдчилан сэргийлнэ.

4.10. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ биеийн байдлыг ажиглаж, өвдсөн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд цэцэрлэгт явуулахгүй байх арга хэмжээ авна.

4.11. Хүүхдээ олон нийтийн газар дагуулж явахгүй байх "Гэр-цэцэрлэг-гэр" маршрутыг мөрдүүлнэ.

4.12. Хүүхэд, багш, ажилтан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.

4.13. Эцэг эх асран хамгаалагч нь ариун цэврийн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 266 дугаар тушаалд заасан жагсаалтын дагуу эхний 3 сард шаардагдах хэсгийг бэлтгэж, багшид хүлээлгэн өгнө.

4.14. Цэцэрлэг дээрээ өмсөхөд зориулан хүүхдэд тохиромжтой хувцас, чийг татахгүй шаахай бэлтгэж өгнө.

4.15. Хүүхдээ тогтоосон цагт хүргэж өгч, авах, хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн биеэр хүргэх, авах боломжгүй тохиолдолд багшид мэдэгдэн, хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг бүрэн хариуцах хүнээр хүргүүлж, авхуулна.

4.16. Оршин суугаа газар, гэрийн хаяг, холбоо барих утас өөрчлөгдсөн бол багшид нэн даруй мэдэгдэнэ.

4.17. Хүүхдээ 22 цагаас өмнө унтуулж, дархлааг нь дэмжинэ.

4.18. Хүнсний бүтээгдэхүүн сонгохдоо аль болох хүүхдийн биеийн дархлааг дэмжих шинэ, шим тэжээллэг, эрдэс бодис, аминдэмээр баялаг, олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн авах, хэрэглэх, зөв хадгалах, халуун бүлээн уух шингэн зүйлийг хангалттай уулгана.

4.19. Эцэг эх, асран хамгаалагч нь гэрийн нөхцөлд хүүхдийнхээ хэрэглэдэг аяга, таваг, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг угааж, содын уусмалаар ариутгах ба хана, шал, хатуу гадаргууг ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодисоор угааж цэвэрлэх, чийгтэй цэвэрлэгээ, агаар сэлгэлтийг тогтмол хийж, гэртээ олон хүн цуглуулахгүй байхад анхаарна.

---000---

Загвар

**ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ, АЖИЛТАН, ЭЦЭГ ЭХ, АСРАН
ХАМГААЛАГЧААС АВАХ АСУУМЖИЙН ХУУДАС**

2020 оны . . . сарын . . . өдөр цэцэрлэг

Энэхүү асуумжийг үнэн зөв бөглөх нь онцгой байдлын үед Та болон таны хүүхэд, нийт иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэж байгааг анхаарна уу.

1	Эцэг/эхийн нэр		2	Өөрийн нэр		
3	Хүйс		4	Иргэний харьяалал		
5	Эрхэлж буй ажил /багш, тогооч, эцэг эх гэх мэт/		6	Хүүхдийн нэр, суралцдаг бүлгийн нэр (бага, дунд гэх мэт)		
7	Оршин суугаа хаяг					
8	Утасны дугаар					
9	Шаардлагатай үед холбоо барих утасны дугаар					
10	Сүүлийн 5 сарын хугацаанд гадаад улс орноос ирсэн эсэх, ирсэн огноо					
11	Хэрвээ гадаад улсаас ирсэн бол аль хотод хэдий хугацаанд байсан бэ?					
12	Дараах шинж тэмдэг илэрч байвал (+), үгүй бол (-) тэмдэг тавина уу. (Багш ажилтан өөрийн , эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ талаарх мэдээллийг бичнэ.)					
13	<i>№</i>	<i>Илэрсэн шинж тэмдэг</i>	<i>+, -</i>	<i>№</i>	<i>Илэрсэн шинж тэмдэг</i>	<i>+, -</i>
	1	37°C-ээс дээш халуурах		8	Хэвлийгээр өвдөх	
	2	Толгой өвдөх		9	Бөөлжих	
	3	Амьсгал давчдах		10	Суулгах	
	4	Нүд улайх		11	Чичрэх	
	5	Хоолой өвдөх		12	Булчингаар өвдөх	
	6	Ханиалгах		13	Унтаа байдалд байх	
	7	Хамраас цус гоожих		14	Бие сулрах	
15	Сүүлийн 1 сарын хугацаанд сэжигтэй болон халдварт өвчинтэй хүнтэй хамт байсан эсэх?				Тийм	Үгүй
16	Сүүлийн 7-14 хоногт эм/антибиотик хэрэглэсэн үү?				Тийм	Үгүй
17	Халуун бууруулах эм хэрэглэсэн үү?				Тийм	Үгүй
18	Тогтмол хэрэглэдэг эм байдаг уу? /цусны даралт, харшлын гэх мэт/				Тийм	Үгүй Эмийн төрөл:
19	Асуумж бөглөсөн			20.... оны . . . сарын . . . -ний өдөр		
20	Асуумж бөглөсөн хүний гарын үсэг					

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2020 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн
А/142 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ТҮР ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Коронавируст халдварын цар тахлаас хамаарсан онцгой нөхцөл байдалд ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад энэхүү түр журмыг мөрдөнө.

1.2. Энэхүү түр журам нь ерөнхий боловсролын сургууль/цаашид “сургууль” гэх/ онцгой нөхцөл байдалд хичээллэх үеийн сургалтын зохицуулалт, хүний нөөц, анги танхимын бэлэн байдлыг хангах, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм баримтлах зэрэг асуудлыг хамаарна.

1.3. Түр журмыг хэрэгжүүлэхэд хичээл, сургалтын үйл ажиллагаанд оролцогч талууд халдвар хамгааллын дэглэм баримтлах, суралцагчдад сургалтын хэлбэрийг сонгох, суралцах адил тэгш боломж олгох, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, эрүүл мэнд, онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагаас баталсан журам, зааврыг хэрэгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэг авах зарчим баримтална.

1.4. Сургууль коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, хичээл эхлүүлэх бэлэн байдал хангах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөний хэрэгжилтээс шалтгаалан тодотгол хийж бэлэн байдлыг хангана.

1.5. Сургууль нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/140 дүгээр тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж”-ийг баримтлан ажиллана.

**Хоёр. Хичээл, сургалтын үйл ажиллагааны
зохион байгуулалт**

2.1. Хичээлийг сургуулийн байршлаас хамаарч танхимын болон танхимын бус/теле, цахим/ хосолсон хэлбэрээр зохион байгуулна.

2.1.1. Нийслэлийн засаг захиргааны нэгжид хамаарах тосгоноос бусад сум, тосгон, багийн сургуулийн хичээлийг танхимаар, аймгийн төв, нийслэлд байршилтай сургуулийн хичээлийг гурван өдөр танхимаар, хоёр өдөр теле/цахим хэлбэрээр тус тус зохион байгуулна.

2.2. Танхимын сургалтаар бага ангид монгол хэл, математик; дунд ангид монгол хэл бичиг, математик, хими, физик, биологи, түүх-нийгэм судлал, англи хэл, эрүүл мэнд; ахлах ангид монгол хэл бичиг, математик, эрүүл мэнд, сонгон судлах 3 хүртэл хичээлийг тус тус судална.

2.2.1. Энэ журмын 2.2 дахь заалтыг хэрэгжүүлэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/491 дүгээр тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөн дэх дээр дурдсан хичээлүүдийн цагт журмын 2.3 дахь заалтыг баримтлан зохицуулалт хийнэ.

2.3. Суралцагч танхимын сургалтаар өдөрт 3-4 хүртэл цаг /60 минутаар 2-3 цаг хичээллэх/-ийн хичээл судална. Энэ журмын 2.2-т заасан хичээлүүдийн 7 хоногт судлах сургалтын нийт цаг 12-оос хэтрэхгүй байна.

2.3.1. Тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчдад энэ журмын 2.2-т заасан хичээлээс гадна тэдний онцлог, хэрэгцээнд нийцүүлэн засан сайжруулах, нөхөн сэргээх хичээл зохион байгуулна.

2.3.2. Бүлэг дүүргэлт 20-оос илүүгүйгээр зохион байгуулахад нэг ээлжээр хичээллэх боломжтой аймгийн төв, нийслэлийн сургууль эцэг эх, асран хамгаалагчийн санал, тэдэнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр танхимаар хичээллэх цагийг нэмэгдүүлж болно. Энэ тохиолдолд суралцагчийн танхимд хичээллэх хугацаа 4.5 цагаас хэтрэхгүй байна.

2.4. Танхимын сургалт зохион байгуулахад мэргэжлийн байгууллагаас өгсөн хүн хоорондын зай баримтлах зөвлөмжийн дагуу нэг хүүхдэд ногдох талбай 1-1.5м² байх бөгөөд хичээллэх танхимын багтаамжаас хамаарч нэг анги, бүлэгт хичээллэх хүүхдийн тоо 20±5 байхаар тус тус тооцож анги, дэд бүлэг үүсгэх зохион байгуулалтыг хийнэ.

2.5. Сум, тосгон, багийн сургууль халдвар хамгааллын дэглэм баримтлан хүчин төгөлдөр мөрдөж байгаа сургалтын төлөвлөгөөний дагуу танхимын сургалтыг зохион байгуулах бөгөөд энэ журмын 2.2, 2.3 дахь заалт тус тус хамаарахгүй.

2.6. Боловсролын хүрээлэнгээс хүргүүлсэн арга зүйн зөвлөмжийн дагуу хичээлийн жилийн эхний сард өмнөх ангид эзэмшсэн байх агуулгыг бататгах хичээл зохион байгуулна.

2.7. Нэгдүгээр анги удирдах багш хичээлийн жилийн эхний гурван 7 хоногт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу бэлтгэл хөтөлбөр, дөрөв дэх 7 хоногоос монгол хэл, математикийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.8. Энэ тушаалын 2.2-т заасан хичээлээс бусад хичээлийг теле болон цахим хэлбэрээр зохион байгуулах бөгөөд боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаас хүргүүлсэн теле хичээлийн хуваарийг суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад хүртээмжтэй хэлбэрээр ил тод байршуулж мэдээлнэ.

2.9. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд ажиллах багшийн тоог хүчин төгөлдөр мөрдөж байгаа сургалтын төлөвлөгөөнд үндэслэн тогтоох бөгөөд сургалтын үйл ажиллагаа хэвийн горимоор хичээллэх үед багш илүүдэхгүй байхаар тооцно.

2.10. Хичээллэх гараг, хичээл эхлэх, завсарлах, дуусах цагийг анги бүлэг бүрд ялгаатай байхаар тогтоох, хичээлийн байранд орох, гарах боломжит бүх хаалгыг ашиглахаар зохицуулалт хийж, хичээлийн хуваарийг батална.

2.11. Онцгой нөхцөл байдалд хичээллэх үед багш нарын ажлын чиг үүргийг багш нарын зөвлөлийн хурлаар нарийвчлан тогтоож, сургуулийн захирлын тушаалаар баталж мөрдөнө.

2.12. Багш нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам"-ын 10-т заасан цагаар ажиллана.

2.13. Теле болон цахим хичээл удирдаж байгаа багш нар суралцагчтай эргэх холбоотой ажиллах, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө, мэдээлэл бэлтгэж хүргэх болон энэ тушаалын 2.11-т заасан журмын 11 дэх заалтыг баримтлан арга

зүйн цаг/ сургалтын хөтөлбөр, стандартыг хэрэгжүүлэх ажил/-ийн хүрээнд танхимаар хичээл зааж буй багш нарт туслах, дэмжлэг үзүүлэх, хичээлийг интеграци байдлаар төлөвлөж хамтран хэрэгжүүлэх зэрэг зохицуулалт хийж багш нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлнэ.

2.13. Онцгой нөхцөл байдалд хичээллэх үед суралцагчдын бие даан гүйцэтгэх ажил, гэрийн даалгаврын хэмжээг зохистой тогтоох, даалгаврын гүйцэтгэлээс шалтгаалан хүүхэд айдас түгшүүрт өртөж болзошгүй тул урьдчилан сэргийлэх арга хэмжээг заах аргын нэгдлийн ахлагч, нийгмийн ажилтан авч хэрэгжүүлэх бөгөөд түүнд сургалтын менежер хяналт тавина.

2.14. Эцэг эх, асран хамгаалагчаас танхимын сургалтад хүүхдээ хамруулахаас татгалзах албан ёсны хүсэлт бичгээр гаргасан тохиолдолд танхимаар орж байгаа хичээлийг бие даан судлах, багштай эргэх холбоотой ажиллах, хүүхдээ хоцрогдолгүй сургах талаар сургалтын менежер, анги удирдсан багш тэдэнтэй тусгайлан гэрээ байгуулж ажиллана.

2.15. Гадаад улсын ерөнхий боловсролын сургуулиас өөрийн орны ерөнхий боловсролын сургуульд үргэлжлүүлэн суралцахаар ирсэн хүүхдийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар баталсан “Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам”-ын 6 дахь хэсгийг баримтлан иргэнд хүндрэл үүсгэхгүйгээр элсүүлэн сургуулийн орчинд дасан зохицох, монгол хэлээр суралцахад дэмжлэг үзүүлж, сурлагаар хоцрогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

2.16. Дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан хүүхдийг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм баримтлан хүлээн авах бөгөөд энэ тохиолдолд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/508 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар”-т нийцүүлэн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулж ажиллана.

2.17. Бага ангийн суралцагчдад үдийн цайны үйлчилгээг анги, танхимд эсхүл эрүүл ахуй, халдвар хамгааллын горим баримтлан цайны газарт сургуулийн эмч, нийгмийн ажилтны хяналт дор зохион байгуулна.

2.18. Онцгой нөхцөл байдалд хичээллэх үед кабинетын системээр хичээллэхгүй бөгөөд номын сан, хүүхэд хөгжлийн танхимыг сургалтын зориулалтаар ашиглах зохицуулалт хийнэ.

Гурав. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх

3.1. Эрүүл мэнд, онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг ил тод байршуулж мөрдөнө.

3.2. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-д заасны дагуу холбогдох багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хичээл эхлэхээс өмнө хамруулсан байна.

3.3. Хичээлийн болон дотуур байрын нийтийн эзэмшлийн зам талбайд зай барих тэмдэг, тэмдэглэгээ заавал хийсэн байна.

3.4. Хичээлийн жил эхлэхээс өмнө мэргэжлийн байгууллагаар ундны усны дүгнэлт гаргуулах, шавж мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн байна.

3.5. Шаардлагатай цэгүүдэд (ариун цэврийн өрөө, нийтийн эзэмшлийн талбай, хоол үйлдвэрлэх хэсэг, хувцас өлгөх, хурлын танхим, анги танхим бүрд, орох гарах хаалганы хажууд) гар халдваргүйжүүлэх уусмалыг байршуулна.

3.6. Ариун цэврийн өрөө, угаагуур, нүхэн жорлонд дараалал үүсгэхгүй байхаар зохицуулалт хийж, ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийнэ.

3.7. Гар угаах төхөөрөмжийн тоог нэмэгдүүлж, саван, гар халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцээтэй байлгаж, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлнэ.

3.8. Сургуулийн эмч, нийгмийн ажилтан нь багш, ажилтан, суралцагчаас батлагдсан загвар хуудасны дагуу асуумжийг хичээлийн жилийн эхний 7 хоногт багтаан авч нэгтгэн үр дүнг сургуулийн захиралд танилцуулна.

3.9. Хичээлийн болон дотуур байранд багш, ажилтан, суралцагчийг амны хаалттай нэвтрүүлэх, биеийн халууныг тогтмол хэмжиж тэмдэглэл хөтлөх, гарыг халдваргүйжүүлэх арга хэмжээ авна.

3.10. Ээлж хооронд анги танхимд цэвэрлэгээ хийх бөгөөд хичээлийн завсарлагаа бүрд салхивчаар агаар сэлгэлт хийнэ.

3.11. Хичээлийн болон дотуур байранд багш, ажилтан, суралцагч ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.

3.12. Дотуур байранд амьдрах хүүхдийн хоолойг сод эсхүл давсны уусмалаар өглөө, оройд зайлуулах боломжоор хангана.

3.13. Сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэглэл, аяга тавгийг хүнсний содын уусмалаар угааж, ариутгана.

3.14. Бага анги болон тусгай сургуулийн суралцагч, дотуур байранд амьдрах хүүхдэд үдийн цай, хоолны үйлчилгээ үзүүлэхэд түргэн гэмтэх бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй бөгөөд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн шим тэжээллэг, амин дэмээр баялаг бүтээгдэхүүн, халуун ундаа сонгож хэрэглэнэ.

3.15. Анги танхим, дотуур байрын хатуу, зөөлөн эдлэлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг эрүүл мэндийн байгууллагын заавар, зөвлөмжийн дагуу 7 хоногт хоёроос доошгүй удаа хийнэ.

3.16. Сургууль нь хүүхэд тээвэрлэх автобусны үйлчилгээ үзүүлэх тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт хамруулж, мэргэжлийн байгууллагаас зөвшөөрөл авсан байх бөгөөд халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг тээврийн хэрэгсэлд байршуулан, ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийнэ.

3.17. Багш, ажилтан, суралцагч хичээл, сургалтын үеэр ханиалгах, халуурах, хоолой өвдөх, амьсгал давчдах гэх зэрэг өвчний шинж тэмдэг илэрсэн үед анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх түр тусгаарлах өрөө гаргаж, бэлэн байдлыг хангана.

3.18. Багш, суралцагчид хичээллэх танхимд орох, гарахад олноороо нэг дор цугларахгүй байхаар зохицуулалт хийж, зураглал гаргана.

3.19. Онцгой нөхцөл байдалд хичээллэх үед гадны хүнийг хичээлийн болон дотуур байранд нэвтрүүлэхийг хориглоно.

Дөрөв. Хичээл, сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг, оролцоо

4.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах сургалтад багш, ажилтныг бүрэн хамруулах ажлыг сургуулийн удирдлага зохион байгуулна.

4.2. Хувийн ариун цэвэр сахиx, шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх, гэрийн нөхцөлд дасгал хөдөлгөөн хийх, стрессээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг эрүүл мэнд, биеийн тамирын болон тухайн хичээл зааж байгаа багш нар хичээл эхлэхийн өмнө болон дараа суралцагчдад өгөх ажлыг зохион байгуулна.

4.3. Сургуулийн эмч нь нийгмийн ажилтан, анги удирдсан багштай хамтран халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна.

4.4. Дотуур байрын өрөө, тасалгаанд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх ажлыг дотуур байр хариуцсан багш удирдан зохион байгуулж, агаар сэлгэлт хийх, эрүүл ахуйн дэглэм баримтлах, хүүхдийн эрүүл мэндийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд сургуулийн эмчид мэдээлэл өгч ажиллана.

4.5. Анги удирдсан багш бүх суралцагч эсхүл тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хичээлийн жил эхлэхээс өмнө холбоо тогтоож, танхимын сургалтад хамрагдахгүй байж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд шалтгааныг тодруулах, сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4.6. Хичээл удаан хугацаанд завсарласны дараа сургуулийн орчинд хичээллэх үед багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад гарч болзошгүй айдас, түгшүүр, эргэлзээг тайлах, тайвшруулах нийгэм-сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагааг нийгмийн ажилтан холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.7. Хичээл, сургалтын үйл ажиллагааны үед багш, туслах багш, ажилтан, суралцагч амны эсхүл нүүрний хаалт тогтмол хэрэглэнэ.

4.8. Багш, ажилтан, суралцагч сургуульд нэвтрэхдээ биеийн халуунаа хэмжүүлнэ. Халуурсан, ханиалгасан, нүд улайсан гэх зэрэг шинж тэмдэг илэрсэн суралцагчийг тухайн өдрийн хичээлээс чөлөөлж, эцэг эх, асран хамгаалагчид хүлээлгэн өгнө.

4.9. Багш, ажилтан нь сургуулийн орчинд тогтоосон дэгийг суралцагчид баримталж буй байдал, тэдний эрүүл мэндэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сургуулийн эмчид мэдээлэл өгч ажиллана.

4.10. Бага анги болон тусгай сургуулийн суралцагч, дотуур байранд амьдарч байгаа хүүхдэд үдийн цай, хоолоор үйлчлэх ажилтан нэг удаагийн бээлий, амны болон нүүрний хаалт хэрэглэнэ.

4.11. Суралцагч хуваарилсан суудалд сууж, суудал солихгүйгээр хичээллэнэ.

4.12. Суралцагч өөр хоорондоо бал үзэг, цаас, ном дэвтэр, гар утас гэх мэт аливаа хэрэглэгдэхүүнийг дамжуулж хэрэглэхийг хориглоно.

4.13. Суралцагч гэрээсээ ус, ундааны зүйл, хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн ирсэн тохиолдолд өөр хоорондоо дамжуулан хэрэглэхгүй байна.

4.14. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдэдээ амны хаалт, нойтон салфетка, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгчийг бэлтгэж өгнө. Хичээлд ирэхээс өмнө хүүхдэд цай, хоол идүүлсэн байна.

4.15. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ биеийн байдлыг тогтмол ажиглаж, өвдсөн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд хичээлд явуулахгүй байх арга хэмжээ авна. Хүүхдийнхээ танхимын хичээлийн хуваарьтай танилцаж, "Гэр-сургууль-гэр" маршрутыг мөрдүүлнэ.

4.16. Багш, ажилтан, суралцагч хичээлийн болон дотуур байранд ундны цэвэр ус уух нөхцөлд өөрсдийн аяга, усны савтай байна.

4.17. Бага ангийн суралцагчийг хүлээн авах, тарах үйл ажиллагааг бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулах бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч сургуулийн орох, гарах хаалгаар хүүхдээ хүлээлгэн өгч, авна.

4.18. Сургуулийн орчинд хичээлийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, ус ундаа, амны болон нүүрний хаалт, гар халдваргүйжүүлэгч, бээлий, улавч гэх мэтийг худалдан борлуулахыг хориглоно.

---000---

Загвар

БАГШ, АЖИЛТАН, СУРАЛЦАГЧААС АВАХ АСУУМЖИЙН ХУУДАС

2020 оны . . . сарын . . . өдөр сургууль

Энэхүү асуумжийг үнэн зөв бөглөх нь онцгой нөхцөл байдлын үед Та болон таны хүүхэд, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэж байгааг анхаарна уу.

1	Овог		2	Өөрийн нэр		
3	Хүйс		4	Иргэний харьяалал		
5	Эрхэлж буй ажил /суралцагч, багш, тогооч гэх мэт/		6	Суралцагч бол анги, бүлэг		
7	Оршин суугаа хаяг					
8	Утасны дугаар					
9	Шаардлагатай үед холбоо барих утасны дугаар					
10	Сүүлийн 5 сарын хугацаанд гадаад улс орноос ирсэн эсэх, ирсэн огноо					
11	Хэрвээ гадаад улсаас ирсэн бол аль хотод хэдий хугацаанд байсан бэ?					
12	Таны биед дараах шинж тэмдэг илэрч байвал (+), үгүй бол (-) тэмдэг тавина уу.					
13	<i>№</i>	<i>Илэрсэн шинж тэмдэг</i>	<i>+-</i>	<i>№</i>	<i>Илэрсэн шинж тэмдэг</i>	<i>+-</i>
	1	37°C-ээс дээш халуурах		8	Хэвлийгээр өвдөх	
	2	Толгой өвдөх		9	Бөөлжих	
	3	Амьсгал давчдах		10	Суулгах	
	4	Нүд улайх		11	Чичрэх	
	5	Хоолой өвдөх		12	Булчингаар өвдөх	
	6	Ханиалгах		13	Унтаа байдалд байх	
	7	Хамраас цус гоожих		14	Бие сулрах	
14	Сүүлийн 1 сарын хугацаанд сэжигтэй болон халдварт өвчинтэй хүнтэй хамт байсан эсэх?				Тийм	Үгүй
15	Сүүлийн 7-14 хоногт эм/антибиотик хэрэглэсэн үү?				Тийм	Үгүй
16	Халуун бууруулах эм хэрэглэсэн үү?				Тийм	Үгүй
17	Тогтмол хэрэглэдэг эм байдаг уу? /цусны даралт, харшлын гэх мэт/				Тийм	Үгүй
					Эмийн төрөл:	
18	Асуумж бөглөсөн			20... оны . . . сарын . . . -ний өдөр		
19	Асуумж бөглөсөн хүний гарын үсэг					



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хичээл, сургалтын үйл ажиллагааг
эхлүүлэх зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын 2020 оны "Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 32 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн хичээл, сургалтын үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэхтэй холбогдуулан санхүү төсөв, дэд бүтэц, хүний нөөцийн бэлэн байдлыг хангаж, тогтоосон хугацаанд өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэх арга хэмжээ авах;

1.2. Сургалтын үйл ажиллагаа эхлэхээс 14 хоногийн өмнө цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжид халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, түүнд шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх;

1.3. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 145 дугаар тушаалаар баталсан "Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам"-ын дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хүний бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулж, багш, ажилтныг бүрэн хамруулах;

1.4. Коронавируст халдвар (КОВИД 19)-т цар тахлын аюулын бэлэн байдлын нөөцийг нэмэгдүүлэх, цэцэрлэг, сургуульд гар угаах нөхцөлийг бүрдүүлэх, /халуун, хүйтэн ус, гар угаах угаалтуурын тоог нэмэх, шингэн саван, гар арчих салфетка, агаар цэвэршүүлэгч/, цэвэрлэгээний бодисын нөөцийг хангах /ахуйн хэрэглээний цэвэрлэх бодис, цэвэрлэгээний болон гар халдваргүйжүүлэх бодис/, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах /суултуур, энгийн бие засах газар/ талаар бэлэн байдлыг хангаж, нөхөн хангалтыг гэрээ хэлцлийн үндсэн дээр зохицуулах;

1.5. Хүүхдэд шаардлагатай амин дэм бүхий дархлаа дэмжих хоол, хүнсээр хангах, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, чанар, үнэ өртөгт тавих хяналтыг сайжруулж, хоол хүнсээр дамжих өвчнөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нэгдсэн зохицуулалт хийх;

1.6. Сургууль, хүүхдийн байгууллагын үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох мэргэжлийн байгууллагаар ундны усанд хими, нян судлалын

шинжилгээ хийлгүүлж дүгнэлт гаргуулах, төвлөрсөн бус ус хангамжтай /өөрийн эх үүсвэр/ нөхцөлд эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулах, эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор бохирдуулагч эх үүсвэргүй байлгах;

1.7. Сургууль, хүүхдийн байгууллагын энгийн бие засах газар, бохир ус цэвэрлэх байгууламжийг эрүүл ахуй, стандартын шаардлага хангуулах, байнгын халдваргүйжүүлэлт хийж хэвшүүлэх;

1.8. Орчны аюулгүй байдлыг бүрэн хангахтай холбогдуулан бүх шатны боловсролын сургалтын байгууллагын камержуулалт, замын гэрэлтүүлэг, авто замын тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу чанартай хийх, сэргээн засварлах, шаардлагатай тохиолдолд хурд сааруулагч, явган хүний гарц, гэрлэн дохиог шинээр байрлуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

1.9. Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл ахуйн зан үйл, гарын ариун цэвэр сахиx, амны хаалт хэрэглэх, зөв ханиаж найтаах, халуун хэмжих, гэрийн дэглэм сахиx, дархлаа дэмжих зэрэг сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүргэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.

Хоёр. Аймаг, нийслэлийн Онцгой комиссын нарийн бичгийн даргад:

2.1. Боловсролын байгууллага, цэцэрлэг, сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, коронавируст халдвар (КОВИД 19)-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээний салбар төлөвлөгөө боловсруулж, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээр хянуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.2. Өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэмийг мөрдөж ажиллах дадлага сургууль зохион байгуулж, сум, дүүргийн цэцэрлэг, сургуульд чиглэл, зөвлөмж өгөх;


2.3. Цэцэрлэг, сургууль орчмын бүсэд орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсгээр эрсдэлийн үнэлгээ хийлгэж, хичээлийн жил эхлэхээс өмнө аюулгүй байдлыг бүрэн хангуулах арга хэмжээ авах;

2.4. Эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтэд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ, өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн дэглэмийг чанд мөрдүүлэх, энэ чиглэлээр явуулж буй сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлын үр дүнг сайжруулж хяналт тавих;

2.5. Аюулт үзэгдэл, ослын улмаас хэвийн үйл ажиллагаа алдагдсан сургалтын байгууллагын барилга байгууламжийн нөхцөл байдлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын хурлаар хэлэлцэж, үүссэн хохирлыг арилгах шуурхай арга хэмжээ авч ажиллах.

Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг Улсын Онцгой комиссын Ажлын албанд 2020 оны 8 дугаар сарын 14, 31-ний өдрүүдэд ирүүлэхийг үүрэг болгож байна.

ДАРГА,
ШАДАР САЙД



Я.СОДБААТАР

УХААН169

БАТЛАВ
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД Л.ЦЭДЭВСҮРЭН

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН
2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилт**

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлж байна. Энэхүү зорилгыг хангах чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Танхимын сургалт удаан хугацаагаар зогссоны улмаас хүүхдийн дунд үүсэж болзошгүй түгшүүр, хөгжлийн ялгаатай байдал, сурлагаар хоцрох, сургууль завсардах зэрэг эрсдэлээс сэргийлэх хариу арга хэмжээ авч, тэгш бус байдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлж үр дүнг тооцох;
2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах;
3. Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж, үр дүнтэй хэрэгжүүлэх;
4. Багшид үзүүлэх мэргэжил арга зүйн дэмжлэг, тусалцааг суралцагч асуудалд бүтээлчээр хандах, учир шалтгааныг эрэлхийлэх, дүн шинжилгээ хийх, шинэ санаа, шийдэл гаргах, асуудал шийдвэрлэх гэх зэрэг суралцах идэвхтэй үйлийг дэмжсэн арга зүйг хөгжүүлэхэд чиглүүлэх;
5. Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих, тэдний мэдээлэл харилцаа, холбооны технологийн ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг бүх шатны боловсрол, сургалтын байгууллага тэргүүлэх чиглэлээ болгож, хүний нөөцийг чадавхжуулах, заах аргын нэгдэл, сонирхлын бүлгээр хамтран цахим хичээл, хэрэглэгдэхүүн бэлтгэн туршиж сайжруулах;
6. Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлын удирдах арга барил, манлайллын ур чадварыг дээшлүүлэх төрөлжсөн сургалтыг үе шаттай хэрэгжүүлэх;
7. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчдад мэргэжлээ зөв сонгох, элсэлтийн нэгдсэн шалгалтад амжилттай бэлтгэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;
8. Цэцэрлэг, сургууль бүр үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээг хамтын оролцоотой хийж, үр дүнд суурилан хариу арга хэмжээ авах;
9. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлийг өргөжүүлэх.

----000----

2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ЗӨВЛӨМЖ

Нийтлэг мөрдөх зөвлөмж

Бэлтгэл байдлыг хангах талаар:

- Хичээл эхлэхээс өмнө халдваргүйжүүлэлт хийх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар сургуулийн дотоод болон гадаад орчны халдваргүйжүүлэлтийг хийлгэх,
- ЭМС-ийн 2017 оны 145 дугаар тушаал “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ын дагуу багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хүний бөөгнөрөл үүсгэхгүйгээр хамруулах,
- Сургуулийн хоол үйлдвэрлэлийн байрны бэлэн байдлыг хангах,
- Сургуулийн байгууллагад цэвэрлэгээ үйлчилгээний багаж хэрэгслийн тоо хэмжээ, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, ажилтны хөдөлмөрийн хамгаалах хувцас хэрэгслийн тооцоог гаргаж, бэлэн байдлыг хангах,
- Байгууллагын эмчийн өрөөнд шаардлагатай эм, багаж хэрэгсэл (зайнаас халуун хэмжигч, пульсоксиметр, даралтын аппарат, автомакс зэрэг), хамгаалах хувцас хэрэгсэл (нэг удаагийн малгай, улавч, бээлий, N95 шүүлтүүртэй болон нэг удаагийн амны хаалт, конбинзон, гутал, хормогч зэрэг), цэвэрлэх цомог (салфетка, нойлын цаас, халдваргүйжүүлэх уусмалтай шүршигч сав, зузаан бээлий, хогийн жижиг уут зэрэг), ариутгах, халдваргүйжүүлэх бодисын нөөцийг бэлтгэх,
- Шаардлагатай цэгүүдэд (ариун цэврийн өрөө, нийтийн эзэмшлийн талбай, хоол үйлдвэрлэх хэсэг, хувцас өлгөх, хурлын танхим, анги танхим бүрд, орох гарах хаалганы хажууд) гар халдваргүйжүүлэх уусмалыг байршуулах,
- Байгууллагад гар угаах нөхцөлийг бүрдүүлж, угаалтуур бүрд гар угаах, халдваргүйжүүлэх заавар, шингэн саван, гар арчих салфеткыг байршуулах,
- Халдварын сэжигтэй тохиолдол илрэх үед шуурхай мэдээлэх, тусгаарлах, мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх, хариу арга хэмжээний зураглал, маршрутыг дэлгэрэнгүй гаргаж, бэлтгэсэн байх,
- Коронавируст халдвар (КОВИД 19)-аас сэргийлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар багш ажилчид, оюутан сурагч, эцэг эхэд зохион байгуулахаар сургалтын төлөвлөгөө, хуваарийг гаргасан байх,

Халдварын эрсдэлээс сэргийлэх талаар:

- Коронавируст халдвар (КОВИД 19)-аас сэргийлэх зөвлөмжийг ил тод байршуулах,
- Нийтийг хамарсан хурал, цуглаан, тэмцээн, уралдаан, хичээлийн шинэ жилийн нээлт, урлаг соёлын арга хэмжээ зэрэг тэмдэглэлт арга хэмжээг зохион байгуулахыг хориглох,
- Сургууль руу орох, гарах хөдөлгөөнийг бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохицуулах,

- Танхимын хичээлийг 20-оос дээшгүй хүнтэйгээр богиносгосон цагаар зохион байгуулж, сандал хоорондын зайг 1-1.5 метр байхаар тооцох,
- Танхимын агаарыг 30 минут тутамд 10-аас доошгүй минутаар сэлгэх,
- Бөөгнөрөл үүсэхээс сэргийлж, хичээл эхлэх, завсарлах, дуусах хугацааг анги, бүлэг бүрд ялгаатай тогтоож мөрдөх,
- Танхимд хичээллэж байгаа үед ширээ сандлыг сольж суулгахгүй байх, анги сэлгэж хичээллэхгүй байх,
- Биеийн тамирын болон урлагийн заал, хурлын танхим зэрэгт агааржуулалт тогтмол хийх, агааржуулалт хийх боломжтой болгох,
- Дотуур байранд өрөөний 50 хувийг ашиглахаар тавилга, эд зүйлсийг байрлуулах, гадны хүн оруулахгүй байх, орсон тохиолдолд дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж байх,
- Цэцэрлэг, хүүхэд харах газарт хүүхдийг толгойгоор нь нийлүүлж унтуулахгүй байх, орыг зайтай байлгах,
- Амны хаалтыг тогтмол зүүх,
- Амны хаалт зүүх, хувийн ариун цэврийг сайн сахих, гараа савангаар хөөсрүүлж, угаах, ханиаж найтаахдаа тохойн дотор тал руу ханиах, бол гараа халдваргүйжүүлэх талаар зөвлөгөөг багш нар оюутан сурагчдад байнга өгөх
- Нийтийн эзэмшлийн газар, гудамж талбайд нус, цэр, шүлсээ ил задгай хаяхгүй байх,
- Багш ажилчид, оюутан сурагч, хүүхдүүдийн халууныг өдөр бүр зайнаас халуун хэмжигчээр хэмжиж, тэмдэглэл хөтөлж байх, гаргасан төлөвлөгөө, хуваарийн дагуу Коронавируст халдвар (КОВИД 19)-аас сэргийлэх сургалтыг зохион байгуулах

Тусгайлсан шаардлага:

- Өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээнд ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодисыг хэрэглэх,
- Шаардлагатай үед хэрэглэх ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны А/125, А-69, А/143 дугаар тушаалаар батлагдсан тусгай зөвшөөрөлтэй бодисыг хэрэглэх,
- Сургуулийн дотоод болон гадаад орчны халдваргүйжүүлэлтийг улирал бүр халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх,
- Амны хаалт хэрэглэх боломжгүй тохиолдолд (астма, зүрх судасны зэрэг бусад өвчтэй), багш нар хичээл заахдаа болон биеийн тамирын хичээл, биеийн хүчний ажил хийх зэрэгт амны хаалтыг хэрэглэхгүй, нүүрний хаалтыг хэрэглэж болно. Нүүрний хаалтыг өдөр бүр угааж, цэвэрлэж байх.

Цэвэрлэгээ хийх талаар:

- Цэвэрлэгээ, үйлчилгээний хяналтын хуудас гаргаж, байнга шалгаж байх,
- Хичээл эхлэхээс өмнө болон дараа нийтийн талбай, анги танхимд цэвэрлэгээг хийх,
- Ариун цэврийн өрөө, тосгуур, хөтөвч, угаалтуур, суултуур зэргийг ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодисоор 2 цаг тутам, бохирдсон тохиолдол бүрт цэвэрлэх,

- Ил бөөлжис, нус, цэр, ялгадсыг салфетка, нойлын цаасыг ашиглан арчиж, халдваргүйжүүлэх бодисоор бохирдсон газар болон орчин тойрныг халдваргүйжүүлэх,
- Цэвэрлэгээг хамгийн дээд хэсэгт байрлаж буй зүйлээс эхэлж, дээрээс доош нь чиглэлтэйгээр хийх,
- Ямарваа нэгэн эд зүйлсийн дээд тал, хөндий, доод хэсэг, паар, шалны завсар зэргийг сайтар цэвэрлэж, хог хаягдлыг зайлуулж байх,
- Хивс, хивсэнцэр, буйдан зэрэг зүйлсийг тоос сорогч ашиглан сайтар цэвэрлэнэ. Халдварт өвчин гарсан тохиолдолд аль болох хивс, хивсэнцэр ашиглахгүй байх,
- Олон хүний гар хүрч амархан бохирддог компьютерийн гар, залгуур, хаалганы бариул, унтраагуур, цахилгаан шатны дотор орчин, цахилгаан шатны товчлуур, ширээ, шатны бариул, зурагтын удирдлага, номын тавиур, цонхны бариул, сандлын түшлэг, нийтийн заалны сандал зэргийг тогтмол цэвэрлэж байх,
- Дотуур байр, цэцэрлэгийн орны цагаан хэрэглэл, бүтээлэг, гар нүүрийн алчуур зэрэг зөөлөн эдлэлийг агаарт сэгсэрч, агаарын хөдөлгөөн үүсгэхгүйгээр хумьж аван, сайтар угааж, цэвэрлэхийг зөвлөх,
- Угаах боломжгүй орны зөөлөн эдлэл болох хөнжил, гудас, бүтээлэг, дэр зэргийг дотуур байр, хүүхдийн байгууллага зэрэгт гадаад орчинд гөвж сэгсрэх, нарны гэрэлд байлгах,
- Цонхны хөшиг, ширээ, суудлын бүтээлэг зэрэг зөөлөн эдлэлийг 7 хоног бүр угааж индүүдэх,
- Хүүхдийн тоглоомыг угааж цэвэрлэн, 2 хувийн содын уусмалаар халдваргүйжүүлэх, угааж цэвэрлэх боломжгүй тоглоомыг хэрэглэхгүй байх,
- Анги, танхимын хогийн савыг дүүргэлгүй суллаж, өдөр бүр угааж цэвэрлэж байх,
- Гадаад орчинд ил задгай хог хаягдлын хуримтлал үүсгэхгүйгээр хогийн савны тоо, хэмжээ, хоорондын зайг тооцож байршуулан, хогийн сав, хогийн бункерээс хог хаягдлыг хуваарийн дагуу ачиж зайлуулах, шаардлагатай тохиолдолд халдваргүйжүүлэлт хийлгэж байх,
- Хэрэглэсэн амны хаалт, хог хаягдлыг тагтай хогийн саванд хаях, ил задгай хаяхгүй байх,
- Тоглоомын талбай, сандал, сүүдрэвч, гадаа шатны бариул, орцны хаалга, хаалганы бариул, автомат цоожны товчлуур зэргийг тогтмол цэвэрлэх,
- Төвлөрсөн бус зөөврийн усан хангамжтай тохиолдолд усны машины емкост, нөөцлөх савыг өдөр бүр усыг шавхах ба улиралд 1 удаа халдваргүйжүүлэлт хийж, халдваргүйжүүлэх бодисын үлдэгдэлгүй болтол цэвэр усаар сайтар зайлах арга хэмжээг авах,
- Энгийн бие засах газар, хогийн цэг зэргийг хаврын улиралд 4-5 сар, намрын улиралд 7-9 саруудад авгалдай устгах, халдваргүйжүүлэх ажиллагааг хийж гүйцэтгэх,

Хүнс, хоолны эрүүл ахуйн талаар:

- Үдийн цайны өмнө хүүхэд, сурагчдын гарыг угаалгаж, хэвшүүлэх,

- Сургуулийн хоол үйлдвэрлэлийн хэсэгт хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, савлалтын үед хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын ерөнхий зарчмыг баримтлах,
- Өдөр тутмын хоолны бүтцийг чухалчлах, шим тэжээлийн зохистой байдалд анхаарах,
- Хооллохдоо ямар ч тохиолдолд зөвхөн өөрийн аяга, таваг, халбага, сэрээ, савхаар идэх. Хүүхдэдээ хүний уусан аяганаас уухгүй байхыг сануулж, ундааны соруул гэх мэтийг ам дамжуулан хэрэглэхгүй байх талаар хэлж ойлгуулах,

Халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээ:

- Багш, сурагчдын ирцийн бүртгэлийг өдөр бүр хянаж, ажилдаа, хичээлдээ ирээгүй болон өвчтэй, чөлөөтэй хүмүүсийг бүртгэж, өвдсөн шалтгааныг тодруулан эмчид мэдээлнэ,
- Халдварын сэжигтэй шинж тэмдэг (халуурах, цээжээр хөндүүрлэх, ханиах, ихээр ядрах, амьсгал дутлын шинж илрэх зэрэг) илэрсэн тохиолдолд сургуулийн удирдлагад мэдэгдэж, эмч үзлэг хийнэ,
- Эмч үзлэг хийж, халдварын сэжигтэй тохиолдол хэмээн үзсэн үед анх үзлэг хийсэн өрөөндөө түр тусгаарлалтыг хийнэ,
- Халдварын сэжигтэй тохиолдлын дуудлагыг нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 100, 80086829, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 119 дугаарт, орон нутагт хамгийн ойр байгаа эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ,
- Түр тусгаарлах өрөөнд эмч, үйлчлүүлэгч амны хаалт, бээлий шаардлагатай тохиолдолд хамгаалах хувцсыг өмсөнө,
- Үзсэн эмч нь халдварын сэжигтэй тохиолдол, хамт байсан хүний хамт түр тусгаарлагдаж, мэдээлэх урсгалын дагуу эрүүл мэндийн байгууллагад мэдээлж, зөвлөгөө аван, мэргэжлийн байгууллага ирэх хүртэл хүлээнэ.
- Шаардлагатай тохиолдолд анхан шатны тусламжийг үзүүлнэ. Үзүүлсэн тусламжийн талаар мэргэжлийн байгууллагад мэдээлэл өгнө,
- Халдварын сэжигтэй шинж тэмдэг илэрсэн болон өвчний батлагдсан тохиолдолд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллага ирж хийнэ.

2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЭЦЭГ ЭХ,
АСРАН ХАМГААЛАГЧИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

(Цэцэрлэг, хүүхэд харах төв)

1. Цэцэрлэг, хүүхэд харах төвийн сургалтын үйл ажиллагаа эхлэхийн өмнө эцэг эх, асран хамгаалагч дараах бэлтгэлийг заавал хангасан байна. Үүнд:

1.1. Мэргэжлийн байгууллагаас гаргасан эрүүл ахуй, халдварын эрсдэлээс сэргийлэх заавар, зөвлөмжтэй сайтар танилцсан байна.

1.2. Хүүхдэд сургалтын үед хэрэглэх амны хаалт, гар ариутгагчийг 7 хоног, сараар тооцож хүрэлцээтэй бэлтгэнэ.

1.3. Хүүхдийг аливаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, дархлаажуулалтад хамруулж, эрүүл мэндийг нь сахин хамгаална.

1.4. Ариун цэврийн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайдын 2012 оны 266 дугаар тушаалд заасан жагсаалтын дагуу нэг улиралд шаардагдах хэсгийг бэлтгэж, багшид хүлээлгэн өгнө.

1.5 Цэцэрлэг дээрээ өмсөхөд хүүхдэд тохиромжтой хувцас, чийг татахгүй шаахай бэлтгэсэн байна.

2. Эцэг эх, асран хамгаалагч дараах үүргийг хүлээнэ.

Үүнд:

2.1. Хүүхдэд өглөөний цайг гэрт нь тогтмол уулгаж, хоносон болон халаасан хоол, шарсан, хуурсан хоолноос татгалзах, олон нийтийн газарт хооллуулахгүй байхад анхаарна.

2.2. Цаг агаарт тохируулан хүүхдээ хувцаслахад анхаарч, маск болон ахуйн бээлийг тогтмол хэрэглүүлнэ.

2.3 Хүүхдийнхээ биеийн байдлыг ажиглаж, гэр бүлийн гишүүн халдварт өвчнөөр өвдсөн болон талаар оношлогдсон, хүүхдийн биед өвдсөн шинж тэмдэг илэрсэн үед цэцэрлэг, хүүхэд харах төвд явуулахгүй байх арга хэмжээ авна.

2.4. Хүүхдэд дараах зөвлөгөөг тогтмол өгч, өөрөө үлгэрлэн дадал хэвшилтэй болоход нь тусална.

- амны хаалт тогтмол зүүх, цэцэрлэг, хүүхэд харах төвд нэвтрэх үед биеийн халуунаа заавал хэмжүүлэх, амьсгалын замын бусад халдварын шинж тэмдэг ханиах, найтаах, хамар түгжрэх, битүүрэх, хоолой сэрвэгнэх, өвдөх зэрэг шинж тэмдэг илэрсэн бол нэвтрэхгүй байх;
- биед ямар нэг өвчний зовуурь, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд багшдаа мэдэгдэхийг зөвлөх
- гарын ариун цэврийг сайтар сахих, савандаж угаах, хоолойгоо зайлах;
- нүд, ам, хамартаа гар хүрэхгүй байх;
- нийтийн эзэмшлийн газар гудамж, талбайд нус, цэр, шүлсээ ил задгай хаяхгүй байх;

- ханиаж найтаахдаа ам хамраа алчуур буюу цаасан сальфеткаар таглах, гарын шууны дотор тал руу ханиалгах, ханиаж найтааж байгаа хүнээс хол байх;
- бусадтай хүнсний бүтээгдэхүүн хувааж идэхгүй байх;
- хүүхэдтэйгээ олон нийтийн газраар явахгүй байх, “Гэр-цэцэрлэг-гэр” маршрутыг мөрдөх, баталгаат бус цэгээс хүнсний бүтээгдэхүүн худалдан авахуулахгүй байх, цэцэрлэг, хүүхэд харах төвд тоглоом, хүнсний бүтээгдэхүүн өгч оруулахгүй байх.
 - олон хүн цугларсан газарт очуулахгүй байх.

2.6. Хүүхдээ тогтоосон цагт хүргэж өгч, авч байх, хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн биеэр хүүхдээ хүргэх, авах боломжгүй тохиолдолд багшид мэдэгдэн, хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг бүрэн хариуцах хүнээр хүргүүлж, авахуулж байна.

2.7 Оршин суугаа газар, гэрийн хаяг, холбоо барих утас өөрчлөгдсөн бол багшид нэн даруй мэдэгдэнэ.

2.8. Хүүхдээ 22 цагаас өмнө унтуулж, дархлааг нь дэмжинэ.

2.9. Хүнсний бүтээгдэхүүн сонгохдоо аль болох хүүхдийн биеийн дархлааг дэмжих шинэ, шим тэжээллэг, эрдэс бодис, аминдэмээр баялаг, олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн авах, хэрэглэх, зөв хадгалах, халуун бүлээн уух шингэн зүйлийг хангалттай уулгана.

2.10. Эцэг эх, асран хамгаалагч нь ахуйн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор аяга, таваг угааж, цэвэр усаар сайтар зайлах, хүүхдийнхээ тоглоомыг содын уусмалаар угааж цэвэрлэх, хана, шал, хатуу гадаргууг ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодисоор угааж цэвэрлэх, чийгтэй цэвэрлэгээ, агаар сэлгэлтийг тогтмол хийж, гэртээ олон хүн цуглуулахгүй байхад анхаарна.

.....000.....

2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ХАРГАЛЗАН ДЭМЖИГЧИД
ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. Хичээл, сургалтын үйл ажиллагаа эхлэхийн өмнө эцэг эх, асран хамгаалагч нь дараах бэлтгэлийг заавал хангасан байна. Үүнд:

1.1. Мэргэжлийн байгууллагаас гаргасан эрүүл ахуй, халдварын эрсдэлээс сэргийлэх заавар, зөвлөмжтэй сайтар танилцсан байна.

1.2. Хүүхдэд хичээл сургалтын үед хэрэглэх амны хаалт, гар ариутгагчийг 7 хоног, сараар тооцож, хүрэлцээтэй бэлтгэнэ.

1.3. Дотуур байранд амьдарч байгаа хүүхдэдээ шаардлагатай ахуйн болон ариун цэврийн хэрэглэл, хувцас, хичээлийн хэрэглэл болон амны хаалт, гар ариутгагчийг сар, улирлаар тооцож, хангалттай бэлтгэж өгнө.

1.4. Хүүхдийг аливаа халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, дархлаажуулалтад хамруулж, эрүүл мэндийг нь сахин хамгаална.

1.5. Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага, ном сурах бичгийг бэлтгэж, суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

2. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

2.1. Хүүхдэд өглөө, өдрийн хоол, цайг гэрт нь тогтмол уулгаж, хоносон болон халаасан хоол, шарсан, хуурсан хоолноос татгалзах, олон нийтийн газарт хооллохгүй байхад анхаарна.

2.2. Хүүхдийн хичээл, сургалтын цагийн хуваарьтай танилцаж, “Гэр-сургууль-гэр” маршрутыг мөрдүүлнэ.

2.3. Хүүхдээ цаг агаарт тохируулан хувцаслахад анхаарч, маск болон ахуйн бээлийг тогтмол хэрэглүүлнэ.

2.4. Хүүхдийнхээ биеийн байдлыг ажиглаж, гэр бүлийн хэн нэг нь халдварт өвчнөөр өвчилсөн талаар оношлогдсон болон хүүхдийн биед шинж тэмдэг илэрсэн үед хичээл, сургуульд явуулахгүй байх арга хэмжээ авна.

2.6. Хүүхдэдээ дараах зөвлөгөөг тогтмол өгч, өөрөө үлгэрлэн хэвшүүлнэ.

- амны хаалт тогтмол зүүх, сургуульд нэвтрэхдээ биеийн халуунаа заавал хэмжүүлэх;
- гарын ариун цэврийг сайтар сахих, савандаж угаах, хоолойгоо зайлах;
- нүд, ам, хамартаа гар хүрэхгүй байх;
- нийтийн эзэмшлийн газар гудамж, талбайд нус, цэр, шүлсээ ил задгай хаяхгүй байх;
- Ханиаж найтаахдаа ам хамраа алчуураар таглах, гарын шууны дотор тал руу ханиалгах, ханиаж найтааж байгаа хүнээс хол байх;
- “Гэр-сургууль-гэр” маршрутыг сайтар мөрдөх, олон нийтийн газраар явахгүй байх;

- Зөвхөн хуваарьт хичээлд хамрагдах;
- Бусадтайгаа 1-1,5 метрээс дотогш зайд ойртож харилцахгүй байх;
 - Олон цурларсан газарт очихгүй байна.
- Бал үзэг, цаас, ном дэвтэр, утас, таблет, notebook, флаш зэрэг аливаа хэрэглэгдэхүүнийг бусдад дамжуулж хэрэглэхгүй байх, бусадтай хүнсний бүтээгдэхүүнийг хувааж идэхгүй байх;
- Биед ямар нэг өвчний зовуурь, шинж тэмдэг (халуурах, ханиалгах, амьсгалахад төвөгтэй болох, суулгах, бөөлжих гэх мэт) илэрсэн тохиолдолд багшдаа мэдэгдэж, яаралтай эцэг эх, асран хамгаалагчтай холбоо барих;
- Ил задгай худалдаа болон үйлчилгээний газруудаас хэзээ хаана үйлдвэрлэсэн нь тодорхойгүй, хаяг шошгогүй, хүнсний бүтээгдэхүүн тэр дундаа бүх төрлийн хийжүүлсэн ундаа, шарсан төмс, чихэрлэг зүйлс, хиам зайдас зэрэг түргэн гэмтэх бүтээгдэхүүнээр хийсэн эрүүл бус бэлэн хоол, хүнсийг худалдан авахгүй байх
- Хүүхдийн биеийн дархлаа, эрүүл мэндийг дэмжих, шим тэжээллэг, эрдэс бодис, аминдэмээр баялаг хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, зөв хэрэглэх, зөв хадгалах, байгалийн гаралтай жимс жимсгэнийн халуун ундаа, цэвэр усыг хангалттай хэмжээгээр уулгах,
- Цэвэр агаарт гарах, дасгал хөдөлгөөнийг идэвхтэй хийх, зөв хооллолт, зөв дадлыг гэр бүлдээ хэвшүүлэх.

2.7. Олон нийтийн газраар явуулахгүй байх, сургуулийн ойр орчмоос хүнсний бүтээгдэхүүн худалдан авахуулахгүй байхад хяналт тавина.

2.8. Арав хүртэлх насны хүүхдээ харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байхад анхаарч, гэрэл ойлгогч /цацруулагч тууз/-ыг цүнхэнд нь байршуулж өгнө.

2.9. Хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн биеэр хүүхдээ хүргэх, авах боломжгүй тохиолдолд багшид мэдэгдэн, хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг бүрэн хариуцах хүнээр хүргүүлж, авахуулж байна.

2.10. Дотуур байранд амьдарч байгаа хүүхэдтэйгээ байнга холбоотой байх, эргэлтээр ирж, дотуур байрны болон анги удирдсан багштай уулзаж, зөвлөгөө авах, мэдээлэл солилцоно.

2.11. Оршин суугаа газар, гэрийн хаяг, холбоо барих утас өөрчлөгдсөн бол анги удирдсан багшид даруй мэдэгдэнэ.

2.12. Хүүхдийнхээ онлайн хичээл, сургалтад хяналт тавьж сургалтыг хэвийн явуулахад туслах, анги удирдсан болон мэргэжлийн багш нартай утсаар болон цахимаар холбогдож мэдээлэл байнга авч, тусалж дэмжинэ.

2.13. Хүүхдээ 22 цагаас өмнө унтуулж, дархлааг нь дэмжинэ.

2.14. Хүүхдийнхээ гар утас, компьютер, ширээ сандал, хаалганы бариул, номын тавиур зэрэг гар байнга хүрдэг эд зүйлийг арчиж цэвэрлэнэ.

2.15. Эцэг эх, асран хамгаалагчид нь ахуйн хэрэглээний шингэн, цэвэрлэгээний бодисоор аяга, таваг угааж, цэвэр усаар сайтар зайлах, хүүхдийнхээ тоглоомыг содын уусмалаар угааж цэвэрлэх, хана, шал, хатуу гадаргууг ахуйн хэрэглээний цэвэрлэгээний бодисоор угааж цэвэрлэх, чийгтэй цэвэрлэгээ, агаар сэлгэлтийг тогтмол хийж, гэртээ олон хүн цуглуулахгүй байхад анхаарна.

2.16. Хүнсний бүтээгдэхүүнээ сонгохдоо аль болох хүний биеийн дархлааг дэмжих шинэ, шим тэжээллэг, эрдэс бодис, аминдэмээр баялаг, олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хүнсэндээ хэрэглэх, зөв хадгалах арга хэмжээ авна.

.....000.....

2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ,
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ, ХАРГАЛЗАН
ДЭМЖИГЧИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. Хичээл, сургалтын үйл ажиллагаа эхлэхийн өмнө эцэг эх, асран хамгаалагч нь дараах бэлтгэлийг заавал хангасан байна. Үүнд:

1.1. Мэргэжлийн байгууллагаас гаргасан эрүүл ахуй, халдварын эрсдэлээс сэргийлэх заавар, зөвлөмжтэй сайтар танилцсан байна.

1.2. Хүүхдэд хичээл сургалтын үед хэрэглэх амны хаалт, гар ариутгагчийг 7 хоног, сараар тооцож, хүрэлцээтэй бэлтгэнэ.

1.3. Дотуур байранд амьдарч байгаа хүүхдэдээ шаардлагатай ахуйн болон ариун цэврийн хэрэглэл, хувцас, хичээлийн хэрэглэл болон амны хаалт, гар ариутгагчийг сар, улирлаар тооцож, хангалттай бэлтгэж өгнө.

1.4. Хүүхдийг аливаа халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, дархлаажуулалтад хамруулж, эрүүл мэндийг нь сахин хамгаална.

1.5. Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага, ном сурах бичгийг бэлтгэж, суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

2. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

2.1. Хүүхдэд өглөө, өдрийн хоол, цайг гэрт нь тогтмол уулгаж, хоносон болон халаасан хоол, шарсан, хуурсан хоолноос татгалзах, олон нийтийн газарт хооллохгүй байхад анхаарна.

2.2. Хүүхдийнх хичээл, сургалтын цагийн хуваарьтай танилцаж, “Гэр-сургууль-гэр” маршрутыг мөрдүүлнэ.

2.3. Хүүхдээ цаг агаарт тохируулан хувцаслахад анхаарч, маск болон ахуйн бээлийг тогтмол хэрэглүүлнэ.

2.4. Хүүхдийнхээ биеийн байдлыг ажиглаж, гэр бүлийн хэн нэг нь халдварт өвчнөөр өвчилсөн талаар оношлогдсон болон хүүхдийн биед шинж тэмдэг илэрсэн үед хичээл, сургуульд явуулахгүй байх арга хэмжээ авна.

2.6. Хүүхдэдээ дараах зөвлөгөөг тогтмол өгч, өөрөө үлгэрлэн хэвшүүлнэ.

- Амны хаалт тогтмол зүүх, сургуульд нэвтрэхдээ биеийн халуунаа заавал хэмжүүлэх;
- Гарын ариун цэврийг сайтар сахих, савандаж угаах, хоолойгоо зайлах;
- Нүд, ам, хамартаа гар хүрэхгүй байх;
- Нийтийн эзэмшлийн газар гудамж, талбайд нус, цэр, шүлсээ ил задгай хаяхгүй байх;
- Ханиаж найтаахдаа ам хамраа алчуураар таглах, гарын шууны дотор тал руу ханиалгах, ханиаж найтааж байгаа хүнээс хол байх;

- “Гэр-сургууль-гэр” маршрутыг сайтар мөрдөх, олон нийтийн газраар явахгүй байх;
- Зөвхөн хуваарьт хичээлд хамрагдах;
- Бусадтайгаа 1-1,5 метрээс дотогш зайд ойртож харилцахгүй байх;
 - Олон хүн цугласан газарт очихгүй байх
- Бал үзэг, цаас, ном дэвтэр, утас, таблет, notebook, флаш зэрэг аливаа хэрэглэгдэхүүнийг бусдад дамжуулж хэрэглэхгүй байх, бусадтай хүнсний бүтээгдэхүүнийг хувааж идэхгүй байх;
- Биед ямар нэг өвчний зовуурь, шинж тэмдэг (халуурах, ханиалгах, амьсгалахад төвөгтэй болох, суулгах, бөөлжих гэх мэт) илэрсэн тохиолдолд багшдаа мэдэгдэж, яаралтай эцэг эх, асран хамгаалагчтай холбоо барих;
- Ил задгай худалдаа болон үйлчилгээний газруудаас хэзээ хаана үйлдвэрлэсэн нь тодорхойгүй, хаяг шошгогүй, хүнсний бүтээгдэхүүн тэр дундаа бүх төрлийн хийжүүлсэн ундаа, шарсан төмс, чихэрлэг зүйлс, хиам зайдас зэрэг түргэн гэмтэх бүтээгдэхүүнээр хийсэн эрүүл бус бэлэн хоол, хүнсийг худалдан авахгүй байх
- Хүүхдийн биеийн дархлаа, эрүүл мэндийг дэмжих, шим тэжээллэг, эрдэс бодис, аминдэмээр баялаг хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, зөв хэрэглэх, зөв хадгалах, байгалийн гаралтай жимс жимсгэнийн халуун ундаа, цэвэр усыг хангалттай хэмжээгээр уулгах,
- Цэвэр агаарт гарах, дасгал хөдөлгөөнийг идэвхтэй хийх, зөв хооллолт, зөв дадлыг гэр бүлдээ хэвшүүлэх.

2.7. Олон нийтийн газраар явуулахгүй байх, сургуулийн ойр орчмоос хүнсний бүтээгдэхүүн худалдан авахуулахгүй байхад хяналт тавина.

2.8. Арав хүртэлх насны хүүхдээ харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байхад анхаарч, гэрэл ойлгогч /цацруулагч тууз/-ыг цүнхэнд нь байршуулж өгнө.

2.9. Хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн биеэр хүүхдээ хүргэх, авах боломжгүй тохиолдолд багшид мэдэгдэн, хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг бүрэн хариуцах хүнээр хүргүүлж, авахуулж байна.

2.10. Дотуур байранд амьдарч байгаа хүүхэдтэйгээ байнга холбоотой байх, эргэлтээр ирж, дотуур байрны болон анги удирдсан багштай уулзаж, зөвлөгөө авах, мэдээлэл солилцоно.

2.11. Оршин суугаа газар, гэрийн хаяг, холбоо барих утас өөрчлөгдсөн бол анги удирдсан багшид даруй мэдэгдэнэ.

2.12. Хүүхдийнхээ онлайн хичээл, сургалтад хяналт тавьж сургалтыг хэвийн явуулахад туслах, анги удирдсан болон мэргэжлийн багш нартай утсаар болон цахимаар холбогдож мэдээлэл байнга авч, тусалж дэмжинэ.

2.13. Хүүхдээ 22 цагаас өмнө унтуулж, дархлааг нь дэмжинэ.

2.14. Хүүхдийнхээ гар утас, компьютер, ширээ сандал, хаалганы бариул, номын тавиур зэрэг гар байнга хүрдэг эд зүйлийг арчиж цэвэрлэнэ.

2.15. Эцэг эх, асран хамгаалагчид нь ахуйн хэрэглээний шингэн, цэвэрлэгээний бодисоор аяга, таваг угааж, цэвэр усаар сайтар зайлах, хүүхдийнхээ тоглоомыг содын уусмалаар угааж цэвэрлэх, хана, шал, хатуу гадаргууг ахуйн

хэрэглээний цэвэрлэгээний бодисоор угааж цэвэрлэх, чийгтэй цэвэрлэгээ, агаар сэлгэлтийг тогтмол хийж, гэртээ олон хүн цуглуулахгүй байхад анхаарна.

2.16. Хүнсний бүтээгдэхүүнээ сонгохдоо аль болох хүний биеийн дархлааг дэмжих шинэ, шим тэжээллэг, эрдэс бодис, аминдэмээр баялаг, олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хүнсэндээ хэрэглэх, зөв хадгалах арга хэмжээ авна.

.....000.....

2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

(Их, дээд сургууль, коллеж)

Их, дээд сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаа эхлэхийн өмнө эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь дараах бэлтгэлийг заавал хангасан байна. Үүнд:

1. Мэргэжлийн байгууллагаас гаргасан эрүүл ахуй, халдварын эрсдэлээс сэргийлэх заавар, зөвлөмжтэй сайтар танилцсан байна.
2. Эцэг эх нь хүүхдээ амны хаалт, гар халдваргүйжүүлэх уусмалыг долоо хоног, сараар тооцож бэлтгэнэ.
3. Дотуур байранд амьдрах хүүхдэдээ шаардлагатай ахуйн болон ариун цэврийн хэрэглэл, хувцас, хичээлийн хэрэглэл, амны хаалт, гар халдваргүйжүүлэх уусмалыг хангалттай бэлтгэж өгнө.
4. Шинээр элсэгч болон дотуур байранд амьдрах хүүхдээ урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, дархлаажуулалтад оршин суугаа харьяаллын дагуу хамруулна

Эцэг эх, асран хамгаалагч дараах үүргийг хүлээнэ.

5. Хүүхдэдээ өглөөний цайг тогтмол уулгаж, хоносон болон халаасан хоол, шарсан, хуурсан хоол, бэлэн гоймон, хийжүүлсэн ундаа, түргэн хоол зэргээс татгалзах, амралт зугаалга, цэнгээний газраар үйлчлүүлэхгүй байхыг зөвлөж, хяналт тавина.
6. Хөдөө, орон нутгийн суралцагчид хамаатан садан, түрээс болон нийтийн байранд амьдрах тохиолдолд цар тахлаас сэргийлэх заавар, зөвлөмжийг байнга мөрдөхийг зөвлөж, хяналт тавина.
7. Сургуулийн захиргаанд оюутан, суралцагчдын оршин суугаа хаяг, утас, яаралтай үед холбоо барих утасны мэдээллийг үнэн зөв гаргаж өгнө.
8. Хүүхдийн биеийн байдлыг тогтмол ажиглаж, гэр бүлийн гишүүн халдварт өвчнөөр өвдсөн болоод халдварын сэжигтэй шинж тэмдэг илэрсэн үед сургалтын захиргаа, эрүүл мэндийн байгууллагад мэдээлж, гэртээ түр тусгаарлах арга хэмжээ авна.
9. Эцэг эх, асран хамгаалагч нь ахуйн хэрэглээний угаагч шингэн, цэвэрлэгээний бодисоор хоолны хэрэгсэл, гэр доторх цэвэрлэгээг хийж, агаар сэлгэлтийг тогтмол хийх, олон хүн гэрт урихгүй байхад анхаарна.

Хүүхдэдээ дараах зөвлөмжийг өгнө.

- Нийтийн эзэмшлийн газар, гудамж талбайд нус, цэр, шүлсээ ил задгай хаяхгүй байх
- Ханиаж, найтаах зөв дадал хэвшилд сургах
- Амны хаалт тогтмол зүүх, сургуулиас тавьж байгаа хорио цээрийн дэглэмийг биелүүлэх
- Гарын ариун цэврийг сайтар сахих, савандаж угаах, хоолойгоо зайлах
- Хичээлийн бус цагаар амралт зугаалга, цэнгээний газраар үйлчлүүлэхгүй байх, олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдахгүй байх
- Бэлэн мөнгө аль болох хэрэглэхгүй байх
- “Гэр-сургууль-гэр” маршрутыг сайтар мөрдөх, олон нийтийн газраар явахгүй байх;

- Гар утас, компьютер, ширээ сандал, хаалганы бариул, номын тавиур, зурагтын удирдлага зэрэг гар байнга хүрэх хэсгүүдийг тогтмол арчиж цэвэрлэх
- Гэр бүлийн хэн нэг нь халдварт өвчнөөр өвчилсөн талаар оношлогдсон болон хүүхдийн бие өвдсөн шинж тэмдэг илэрсэн үед хичээл, сургуульд явахгүй байхыг зөвлөх
- Ил задгай худалдаа болон үйлчилгээний газруудаас хэзээ хаана үйлдвэрлэсэн нь тодорхойгүй, хаяг шошгогүй, хүнсний бүтээгдэхүүн, бүх төрлийн хийжүүлсэн ундаа, шарсан төмс, чихэрлэг зүйлс, хиам зайдас зэрэг түргэн гэмтэх бүтээгдэхүүнээр хийсэн эрүүл бус бэлэн хоол, хүнсийг худалдан авахгүй байх
- Хүүхдийн биеийн дархлаа, эрүүл мэндийг дэмжих, шим тэжээллэг, эрдэс бодис, аминдэмээр баялаг хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, зөв хэрэглэх, зөв хадгалах, байгалийн гаралтай жимс жимсгэнийн халуун ундаа, цэвэр ус хангалттай хэмжээгээр уухыг зөвлөх
- Цэвэр агаарт гарах, дасгал хөдөлгөөнийг идэвхтэй хийх, зөв хооллолт, зөв дадлыг гэр бүлдээ хэвшүүлэх.



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/176

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.1.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 96 дугаар тогтоолын 2 дахь заалт, Ерөнхий сайдын 2020 оны 77 дугаар захирамжийн дагуу байгуулсан Ажлын хэсгийн 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2021-2024-г хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөг хугацаанд нь чанартай хэрэгжүүлж ажиллахыг хэрэгжүүлэгч байгууллагын дарга, захирал, удирдлага нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Дээд боловсролын газар /Г.Батнэмэх/ Шинжлэх ухааны газар /С.Мөнхбат/-т тус тус үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын мэдээллийг улирал тутам нэгтгэн гаргаж, танилцуулах арга хэмжээг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нартай хамтран хэрэгжүүлэхийг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/-т даалгасугай.

5. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III" болон төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хагас жил тутам тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Г.Энхжаргал/-т үүрэг болгосугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

142010631



Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2020 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн
А/15/Дүгээр тушаалын хавсралт

**“МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР III”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2020-2024/**

Монгол хэлний тухай хуулийн заалт, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ын зорилт/ үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн/шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хариуцагч байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа/ ажлын явц, гүйцэтгэл				Санхүү-жилтийн эх үүсвэр
					2021	2022	2023	2024	
Хөтөлбөрийн зорилт 1. “Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх”									
1.1. МХТХ-15.1.3, 22.2.6 МБҮХ-III 1.1. Монгол бичгийн кодчилол, стандартыг боловсронгуй болгож, олон улсын жишигт хүргэх	“Монгол бичгийн юникод стандарт 3.0, олон улсын ISO/IEC 10646-1”-ыг боловсронгуй болгох, “Товчлуур дээрх монгол үсэг, тэмдэгтийн стандартын байршил” төслийг боловсруулж батлан, хэрэгжилтийг хангах	Хүрэх үр дүн/шалгуур үзүүлэлт	СХЗГ ХХМТГ ХБҮЗ	БШУЯ	70%	100%	-	-	Улсын төсөв
1.2. МХТХ-11.1.4, 22.2.2 22.2.6, МБҮХ-III 1.2. Албан хэргийг кирилл, монгол бичгээр хөтлөх стандартыг боловсруулж батлах,	“Баримт бичгийн MNS стандарт” 5140:2011 стандарт болон “Монгол хэлний компьютерын үсгийн тогтолцоо. Кирилл ба Монгол үсгийн нэгдсэн код” MNS	Стандартыг шинэчлэн баталсан байна. Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь	СХЗГ АЕГ ХБҮЗ	ШУА ХЗХ	-	70%	90%	100%	-

эрх зүйн бүрдүүлэх;	орчин	5552:2005 стандартыг шинэчлэн боловсруулах	Стандартыг шинэчлэн баталсан байна.	АЕГ ХБҮЗ СХЗГ	ШУА ХЗХ	-	70%	100%	-	-
1.3.		Монгол бичгээр үйлдэх албан бичиг захидал, тэдгээрийн бүрдлийн хуудас, бүрдлийн байрлалд тавих үндсэн шаардлага "MNS 6395:2013" стандартыг шинэчлэн боловсруулж батлах	Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь							
1.4.		Ургийн овог, хүний нэр, хуулийн этгээдийн нэршлийн цахим сан бий болгох, баяжуулах, байгууллага, иргэд ашиглах боломжийг бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	Цахим санг олон нийт нээлттэй ашиглах боломжийг бүрдүүлсэн байна	ХБҮЗ УБЕГ ШУА ХЗХ	ХХМТГ БШУЯ Түүх, угсаатны зүйн хүрээлэн	70%	100%	-	-	Улсын төсөв
1.5.	МХТХ-15.1.1, 15.1.3, 21.7.12 МБУХ-III 1.3	Монгол бичгийн үндэсний цахим хуудас (портал сайт) нээж, хэрэглэгч тогтмолжуулах	1 портал сайт хөгжүүлсэн байна.	ХХМТГ Хэвлэлийн хүрээлэн	МТҮП Дата төв МОСА БШУЯ НТБҮТ ТББ	1	-	-	-	Улсын төсөв
1.6.	МХТХ-15.1.1, 15.1.3 21.7.8, 21.7.12 МБУХ-III 1.4.	Фэйсбүүк, Ютүүб зэрэг нийгмийн сүлжээнд монгол бичгийн шинээр хичээлийг хөгжүүлэх	Иргэдэд монгол цахим суралцах боломж нэмэгдсэн байна.	ХХМТГ	РТНМСБЗГ ТББ, иргэд	2	2	-	-	-
1.7.	Бичгээ хэрэглэх технологийг нэвтрүүлж, контентын төрөл, хэлбарийг олшруулах	Цахим орчинд монгол бичгээр	Аппликэйшн хэрэглээнд нэвтрэгдсэн байна.	ХХМТГ Хувийн хэвшил	ТББ, Иргэд	40%	100%	-	-	-

		Боловсруулах аппликэйшн нэвтрүүлэх	Шинэ арга зүйгээр Боловсруулсан сурах Бичиг, толь бичиг хэвлэгдсэн байна Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь	БШУЯ БХ МСУТ,	Их дээд сургууль, МСУТ	30%	40%	70%	100%	Улсын төсөв
1.8.	МХТХ-13.1.1 МБУХ-III 1.5. Суралцагчдын нас сэтгэхүйн онцлолт тохируулан монгол бичгийн сурах бичиг, толь бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүнийг шинэлэг арга зүйгээр боловсруулж гаргах;	Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их, дээд сургууль, коллежид судлах монгол бичгийн сурах бичиг, толь бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүнийг шинэчлэн боловсруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	1 мобайл аппликэйшн хөгжүүлсэн байна.	ХХМТТ	МТУП МОСА	40%	100%	-	-	Улсын төсөв
1.9.		Хүүхдэд зориулан хялбаршуулсан монгол аргачлалтай мобайл бичиг сурах мобайл аппликэйшн хөгжүүлэх	Брайл үсэг, дохионы хэлээр монгол бичиг сурах боломжийг бүрдүүлсэн байна. Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн явцын хувиар	БШУЯ	БХ	40%	70%	90%	100%	Улсын төсөв
1.10.		Тусгай сургуулиудад монгол бичгийн хичээл заахад шаардлагатай стандарт, сурах бичиг, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинээр боловсруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	Шалгуур үзүүлэлт: Толь бичгийн тоо	ХХМТТ БШУЯ ШУА ХБҮЗ	ШУТСан ХЗХ	1	-	-	-	Улсын төсөв
1.11.	МХТХ-11.1.2 13.1.1 21.7.8 МБУХ-III- 1.6. Цахим сурах бичиг, толь бичиг, цахим хичээл сургалтын хэрэгслийг хэрэглээнд нэвтрүүлэх	"Монгол бичгийн зөв бичих зүйн журамласан толь"-ийг бүтээж, цахим болон хэвлэмэл хэлбэрээр хэрэглээнд нэвтрүүлэх								

1.12.	МХТХ-13.1.515.1.1 МБУХ-III 1.7.Цахимд монгол бичгээр бичвэр боловсруулах чиглэлийн мэргэшүүлэх сургалтыг эрчимжүүлэх;	Монгол бичгээр албан хэрэг хөтлөх, программ ашиглах цахимд бичвэр бичих арга зүйн сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлах	Шалгуур үзүүлэлт: Батлагдсан сургалтын хөтөлбөр	АЕГ БШУЯ ХХМТГ ХБУЗ	БХ	40%	100%	-	-	-	
1.13.		Архив, албан хэрэг хөтөлтийн ажилтны монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, даvtан сургах ажлыг үе шаттай зохион байгуулах	Шалгуур үзүүлэлт: Сургалтад хамрагдсан, хүний тоо, түүнээс төрийн байгууллагын ажилтны тоо/ хувь	АЕГ ХБУЗ	Сургалтын байгууллагуу Д ТББ, иргэд	-	1500	2000	2500	-	
1.14.	МХТХ-14.1.1, НСТХ-9.4.1, 9.4.2, 21.1, 21.2 СӨХТХ-16.1.8, ЗТХ-ийн 9.7 дугаар зүйл, 1.1, 1.2 МБУХ-III 1.8 Монгол бичгээр уламжлан ирсэн түүх соёлын үнэт дурсгалуудыг хамгаалах,	Жил тутамд монгол бичгээрх түүх соёлын архивын дурсгал, баримтыг 2-оос доошгүй ном, катологи, товхимол, зурагт хуудас хэлбэрээр хэвлэх, 1-ээс доошгүй мөсбэйл аппликейшн хөгжүүлэх	Шалгуур үзүүлэлт: Хэвлэсэн ном, катологи, зурагт хуудас хөгжүүлсэн мобайл аппликейшний тоо	Соёлын яам ХХМТГ АЕГ	СУГ	3	3	3	3	3	Улсын төсөв
1.15.	судалгааны эргэлтэд оруулах, сурталчлах, цахим болон хуулбар хэлбэрээр хэвлэн нийтлэх, олшруулах	Монгол бичгээр уламжлан ирсэн түүх соёлын үнэт дурсгалуудыг хамгаалах, дурсгалуудыг хамгаалах, бүртгэх үйл ажиллагаанд ханалт тавих	Шалгуур үзүүлэлт: Соёлын өвийн РСН мэдээллийн санд бүртгэсэн бичиг, соёлын дурсгалын тоо	Соёлын яам Соёлын өвийн төв	МХЕГ	40%	70%	100%	-	-	Улсын төсөв
1.16.	МХТХ-14.1.1, МБУХ-III 1.9 Утга зохиолын бүтээлийг монгол бичгээр хэвлэхийг дэмжих	Утга зохиолын бүтээлийг монгол бичгээр хэвлэн нийтлэх чиглэлээр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх	Жилд 5-аас доошгүй монгол бичгээр ном бүтээл хэвлэгдсэн байна. Шалгуур үзүүлэлт: Хэвлэгдсэн ном бүтээлийн тоо	Соёлын яам	ШУА, СУГ МЗЭ	5	5	5	5	5	Улсын төсөв

		"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийг хос бичгээр хэвлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	Шалгуур үзүүлэлт: Сэтгүүлийн агуулгад монгол бичгээр зэрэгцүүлсэн агуулгын эзлэх хувь	УИХТГ ЗГХЭГ	ХБҮЗ	30%	40%	70%	100%	Улсын төсөв
1.17.	МХТХ-10.1.2, 11.1.1 1.1.1.4, 27.1.9, МБУХ-III "Төрийн мэдээлэл" сэтгүүлийг 2020 оноос эхлэн хос бичгээр хэвлэж, 2023 оноос зөвхөн монгол бичгээр хэвлэх бэлтгэл хангаж, хэрэгжүүлэх									
1.18.	МХТХ-19.1.1, 19.1.3 27.1.9, МБУХ-III 1.11. Монгол бичгээр хэвлэгддэг сонин, сэтгүүлийн давтамжийг нэмэгдүүлэхэд санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх	Монгол бичгээр хэвлэгдэх өдөр тутмын хэвлэлийг дэмжих арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Хүмүүн бичиг сонин өдөр тутмын хэвлэл болсон байна. Шалгуур үзүүлэлт: Монгол бичгээр хэвлэгдэх өдөр тутмын хэвлэлийн тоо	МОНЦАМЭ	Хэвлэлийн хүрээлэн ТББ Иргэд	1	1-2	2	2	Улсын төсөв
1.19.	МХТХ-13.1.5 14.1.1 21.7.9, МБУХ-III 1.12. Сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлийн агуулгын 30-аас доошгүй хувийг монгол бичгээр гаргах,	Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөтөлбөрийн хүрээнд монгол бичгээр хэвлэгддэг сар тутмын сэтгүүл, сонинд дэмжлэг үзүүлэх	Уламжлал, Эх хэл сэтгүүлд зохих дэмжлэг үзүүлсэн байна. Шалгуур үзүүлэлт: Сар тутмын сэтгүүлийн тоо	Соёлын яам БШУЯ	Соёл урлагийн газар	1	1-2	2	2	Улсын төсөв
1.20.	МХТХ-13.1.5 14.1.1 21.7.9, МБУХ-III 1.12. Сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлийн агуулгын 30-аас доошгүй хувийг монгол бичгээр гаргах,	Телевиз, сэтгүүлийн нэвтрүүлэг, бичвэрийн 30 хувийг монгол бичгээр хөтлөх эрхзүйн зохицуулалтыг бий болгож, хэрэгжүүлэх	Эрхзүйн зохицуулалт /дүрэм, журам, зөвлөмж/-ыг баталсан байна. Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь	Соёлын яам Хэвлэлийн хүрээлэн Телевизүүд ийн холбоо	ХБҮЗ Хэвлэл мэдээллийн байгууллага Д МХЕГ	40%	70%	100%	-	-

1.21.	сэтгүүлийн нэрийг нуруу хэсэгт монгол бичгээр зохицуулалтыг бий болгох, хэвшүүлэх	Ном, товхимлын нэрийг нуруу хэсэгт монгол бичгээр зохицуулалтыг бий болгох, хэвшүүлэх	Шалгуур үзүүлэлт: Эрхзүйн зохицуулалт /дүрэм, журам, зөвлөмж/	Соёлын яам, Хэвлэлийн хүрээлэн МЗЭ	ХБҮЗ ХЗХ	100%	100%	100%	100%
1.22.	Засгийн газрын 2013 оны "Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай" 37 дугаар тогтоолын 5 дахь хэсгийн хэрэгжилтийн тайланг 2 жил тутам хэлэлцэх	Засгийн газрын 2013 оны "Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай" 37 дугаар тогтоолын 5 дахь хэсгийн хэрэгжилтийн тайланг 2 жил тутам хэлэлцэх	Албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийн судалгааг аймаг нийслэл, улсын дүнгээр тайлагнах. Шалгуур үзүүлэлт: Судалгааны дүн тайлан.	ХБҮЗ МХЕГ ХЗХ	Аймаг, нийслэлийн Засаг дарга, ХБҮЗ-ийн салбар зөвлөл	1	-	1	-
1.23.	МХТХ-21.7.6, 17.1.2, 21.7.12, МБҮХ-III 1.13. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, нэрийн хуудас, бүтээгдэхүүний шолго, танилцуулга, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүлэх	Төрийн бүх шатны байгууллагын гадна хаяг, албан ерөө тасалгааны хаяг болон гудамж талбайн нэрийг хос бичгээр зохицуулалтыг бий болгох, мөрдүүлэх ААН, хуулийн этгээд нь монгол бичигт суурилсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх хаяг, таних тэмдэг, бүтээгдэхүүний шолго, зар сурталчилгаандаа монгол бичиг хэрэглэх, ХАУТанхимаас оны шилдэг аж ахуйн нэгжийг шалгаруулахад дээрх үзүүлэлтийг харгалзах	Төрийн байгууллагын хаягийн стандарт, загвар бий болсон байна. Шалгуур үзүүлэлт: Стандарт, /зааваар, загвар, журам/	ХБҮЗ	Аймаг, нийслэлийн Засаг дарга	70%	100%	100%	100%
1.24.			Байгууллагын хаяг, нэршил, шолго, зар сурталчилгааг монгол бичгээр хэвшсэн байна. Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь	ХБҮЗ Засаг дарга ХАУТанхим ААН ТББ	-	40%	70%	100%	100%

	МХТХ-11.1.4, 19.1.1 21.7.9 МБҮХ-III 1.14. Монголын үндэсний телевизийн нийтийн телевизийн дэлгэцийг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн кирилл монгол бичгээр зэрэгцүүлэн бичих	Монголын үндэсний олон нийтийн телевизийн дэлгэцийн бүх бичвэрийг хос бичгээр зэрэгцүүлэн бичих нөхцөлийг бүрдүүлж, ажлын байр бий болгох, хос бичвэрийг хэвшүүлэх	УИХТГ Монголын Үндэсний олон нийтийн телевиз	ХБУЗ	100%	100%	100%	100%	Улсын төсөв
1.25.									
Хөтөлбөрийн зорилт 2. "Монгол бичигт сургах ажлыг эрчимжүүлж, шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх"									
2.1.	БТХ-14.1.1, 17.1.1 БДБТХ-21.6, МБҮХ-III 2.1. Монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарын бүсийн зөвлөгөөнийг 2 тугам, улсын зөвлөгөөнийг 4 жилд 1 удаа зохион байгуулах	Монгол хэл бичгийн сургалтын чанар, аргазүйн шинэчлэл, мэргэжлийн багшийн хөгжлийн асуудлаар бүсийн болон улсын зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан санал, шийдвэрийг бодлогод тусгаж хэрэгжүүлэх	БШУЯ Аймаг, нийслэлийн Засаг дарга	БХ, БМДИ	2000	3500	3800	Улсын төсөв	
2.2	МХТХ-13.1.2 13.1.3 13.1.4 13.1.5 МБҮХ-III 2.2. Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын хүрээлэнгийн дэргэд монгол бичгийн судалгаа, арга зүйн бие даасан нэгж шинээр байгуулах	Боловсролын Хүрээлэнгийн дэргэд монгол бичгийн сургалт, арга зүй, судалгааны чиг үүрэг бүхий нэгж байгуулах	БШУЯ	БХ	1 нэгж	-	-	Улсын төсөв	

							100%					Улсын төсөв
2.3	МХТХ-13.1.1, БТХ-10.3, ТБТББодлого-4.6, МБУХ-III-2.3 Бүх нийтийн монгол хэл, бичгийн хэрэглээ, хандлага, үнэлэмжийн судалгаанд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл, арга замыг тодорхойлох судалгааг хэрэгжүүлэх	Бүх нийтийн монгол хэл, бичгийн хэрэглээ, хандлага, үнэлэмжийг цаашид ажлын чиглэл, арга замыг тодорхойлох судалгааг хэрэгжүүлэх	Чиглэл, зөвлөмж гарсан байна. Шалгуур үзүүлэлт. Судалгааны тайлан	БШУЯ ШУА ХЗХ ТУЗХ ФХ	ШУТС ИДС	100%						
2.4	МХТХ-13.1.1, БТХ-5.1.4, БДБТХ-4.1.4, 5.1.1, 5.1.2, ТБТБ-4.6 МБУХ-III 2.4. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн монгол хэл, монголын түүх, уран зохиол, иргэний боловсрол, ёс суртахууны хичээлийн сурах бичгийг нэн түрүүнд, бусад хичээлийн сурах бичиг, нэмэлт хэрэглэгдэхүүнийг үе шаттайгаар монгол бичигт хөрвүүлэн хэвлэх	ЕБС-ийн ахлах ангийн монголын түүх, уран зохиол болон зарим хичээлийн сурах бичгийг монгол бичигт хөрвүүлэн хэвлэх, хичээл заах багш нарын монгол бичгийн чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	Сурах сургалтад нэвтрүүлсэн байна. Шалгуур үзүүлэлт: Монгол бичгээр хэвлүүлсэн сурах бичгийн тоо	БШУЯ ШУА БХ	ХЗХ МУБИС	-	1	2	2	2	2	Улсын төсөв, ОУБ-н төсөл хөтөлбөр
2.5	МХТХ-13.1.1, БТХ-5.1.4, БДБТХ-4.1.4, 5.1.1, 5.1.2, ТБТБ-4.6 МБУХ-III 2.4. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн монгол хэл, монголын түүх, уран зохиол, иргэний боловсрол, ёс суртахууны хичээлийн сурах бичгийг нэн түрүүнд, бусад хичээлийн сурах бичиг, нэмэлт хэрэглэгдэхүүнийг үе шаттайгаар монгол бичигт хөрвүүлэн хэвлэх	Түүх, нийгмийн ухааны хичээлийн сурах бичгийн агуулгад нийцүүлэн архивын баримтыг тусгах, ашиглах боломжийг бүрдүүлэх	Шалгуур үзүүлэлт: Архивын баримтаар агуулгыг баяжуулсан сурах бичгийн тоо	АЕГ БШУЯ	БХ	-	-	2	3	3	Улсын төсөв	
2.6	МХТХ-13.1.1 МБУХ-III 2.5. Монгол хэл, бичиг, уран зохиолын нягт хичээлийг	Боловсролын хүрээлэнд түшиглэн монгол хэл бичгийн хичээлийн арга зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх төсөл, арга	Нийт монгол хэл бичгийн багш нарын арга зүйн зөвлөмж, авлага хүргүүлсэн байна.	БШУЯ БХ	-	2000	3000	3500	3800	3800	Улсын төсөв	

	уялдуулан заах арга зүйн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх	хэмжээг үе шаттай зохион байгуулна.	Шалгуур үзүүлэлт: Зөвлөмжийн тоо.	БШУЯ ГХЯ БХ	НТБҮТ	10%	30%	50%	70%	-
2.7	МХТХ-11.1.3,13.1.1 БТХ-28.1.26, 41.4, БДБТХ-7.5, ТБТББодлого-4.5, МБУХ-III	Гадаад дахь монгол сургууль, сургалтын төвүүдэд "Монгол бичгийн өргөө"-г бий болгох чиглэл, зөвлөмж өгөх	Шалгуур үзүүлэлт: "Монгол бичгийн өргөө" байгуулсан сургууль сургалтын төвийн тоо	БШУЯ ГХЯ БХ	НТБҮТ	5-аас доошгүй	5-аас доошгүй	5-аас доошгүй	5-аас доошгүй	Улсын төсөв
2.8	2.6.Хилийн чанадад амьдарч байгаа монгол иргэд, хүүхэд, залууст монгол бичгийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх эрх зүйн болон сургалтын орчин бүрдүүлэх	Хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй монгол сургууль, сургалтын төвийг монгол бичгийн сургалтын хөтөлбөр, сурах бичиг, гарын авлагаар хангах	Шалгуур үзүүлэлт: Сурах бичгээр хангасан гадаад дахь сургууль, сургалтын төвийн тоо	БШУЯ ГХЯ БХ	НТБҮТ	5-аас доошгүй	5-аас доошгүй	5-аас доошгүй	5-аас доошгүй	
2.9	МХТХ-13.1.1, БТХ-45.1.8 МБУХ-III 2.7 Монгол улсад сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн сургуульд монгол хэл, бичгийн хичээлийг заавал судлах эрх зүйн зохицуулалтыг бүрэн хангах, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын цагийн хэрэгжилтэд хяналт тавих	Ерөнхий боловсролын монгол хэл бичгийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр хяналт тавих	Төрийн болон төрийн бус өмчийн бүх дунд сургуулийг хамруулсан байна. Шалгуур үзүүлэлт: Хяналт шалгалтад хамрагдсан сургуулийн тоо	БШУЯ МХЕГ	Аймаг, нийслэлийн Боловсролын газар	40	100	200	-	-
2.10	МХТХ-13.1.2 МБУХ-III	Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн мэргэжлийн	Монгол бичиг заах аргазүйн хичээлийн	БШУЯ БХ	БМИУЗ МХЕГ	50%	100%	-	-	-

2.8. Багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн ангид монгол бичиг заах аргын хичээлийг тусгайлан оруулах	ангид судлах "Монгол бичиг заах аргагүйн хичээл"-ийн хөтөлбөрийг сайжруулах, магадлан итгэмжлэх, хэрэгжилтэд хяналт тавих	хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн байна. Шалгуур үзүүлэлт: Ажлын явц, батлагдсан хөтөлбөр	ИДС	-	-	-	-
2.11 МХТХ-13.1.2 МБУХ-III Ерөнхий боловсролын сургууль төгсөгчид монгол хэл, бичгийн шалгалтыг заавал өгөх, шалгалтын 30-аас доошгүй хувь нь монгол бичгийн хичээлийн агуулга байх бөгөөд монгол хэл, бичгийн шалгалтын босго оноог 400-аас эхлэн тодорхой хугацаанд үе нэмэгдүүлэх	Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоол болон БСШУССайдын 2018 оны №А/194 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах	Тогтоол, тушаал хэрэгжсэн байна. Шалгуур үзүүлэлт: Шалгалт өгсөн төгсөгч, элсэгчийн тоо	БШУЯ БҮТ	БСУГ	TOO	TOO	TOO
2.12 Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн монгол хэл бичгийн шалгалтад монгол бичгийн агуулгыг 30-аас 40 хувьд, босго оноог - 400-аас эхлэн үе шаттайгаар нэмэгдүүлэх	Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн монгол хэл бичгийн шалгалтад монгол бичгийн агуулгыг 30-аас 40 хувьд, босго оноог - 400-аас эхлэн үе шаттайгаар нэмэгдүүлэх	Шалгуур үзүүлэлт: Нэмэгдүүлсэн хувь	БШУЯ БҮТ	БСУГ	5%	-	10%
2.13 Бүх нийтийн монгол бичгийн унших, бичих, ярих, сонсох чадварын төвшнийг үнэлэх онооны системийг /стандарт, журам/ боловсруулах, батлах, хэрэгжүүлэх	Унших, бичих, ярих, сонсох чадварын төвшнийг тогтоож үнэлдэг зохицуулалт бий болсон байна. Шалгуур үзүүлэлт: Журам/стандарт	Унших, бичих, ярих, сонсох чадварын төвшнийг тогтоож үнэлдэг зохицуулалт бий болсон байна. Шалгуур үзүүлэлт: Журам/стандарт	БШУЯ, ШУА, БХ, ХЗХ МУИС, МУБИС	ХБҮЗ	-	1	Улсын төсөв
2.14 МХТХ-13.1.2 МБСТХ-9.3 МБУХ-III 2.10. 2019-2020 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах зохицуулалт бий болгох, хэрэгжилтэд хяналт тавих	Шалгуур үзүүлэлт: Монгол бичгийн хичээл судалдаг их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн тоо	БШУЯ ХНХЯ	МХЕГ БМИУЗ Их, дээд сургууль, коллеж, МСҮТ	TOO	TOO	TOO

<p>Үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах</p>	<p>Их, дээд сургууль, коллежид суралцагчдаас монгол бичгийн хичээлийг шалгалт авах, шалгалтын дүнг бакалаврын дипломд баталгаажуулах чиглэлээр холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх</p>	<p>Монгол бичгийн шалгалтын дүнг боловсролын баримт бичигт баталгаажуулдаг болсон байна. Шалгуур үзүүлэлт: Батлагдсан журам</p>	<p>БШУЯ</p>	<p>БМИУЗ ИДС</p>	<p>-</p>	<p>1</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>
<p>2.15</p>	<p>Их, дээд сургууль, коллежид суралцагчдаас монгол бичгийн хичээлийг шалгалт авах, шалгалтын дүнг бакалаврын дипломд баталгаажуулах чиглэлээр холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх</p>	<p>Сургалт семинарыг жил бүр зохион байгуулсан байна. Шалгуур үзүүлэлт: Хамрагдсан багшийн тоо</p>	<p>БШУЯ БХ Их, дээд сургууль</p>	<p>БМДИ, БХ НТБУТ БСУГ</p>	<p>40%</p>	<p>70%</p>	<p>100%</p>	<p>-</p>	<p>ИДС-ын санхүүжилт</p>
<p>2.16</p>	<p>МХТХ-13.1.1, МБУХ-III 2.12. Бүх шатны сургалтын байгууллагад монгол бичиг заах арга зүй, технологийг шинэчлэн боловсруулах</p>	<p>Багш бэлтгэдэг их, дээд сургуульд монгол бичгийн хичээл заах арга зүй, сургалтын технологийг шинэчлэх, багш нарын мэдлэг ур чадварыг сайжруулах сургалт семинар зохион байгуулах хамруулах</p>	<p>Монгол хэл бичгийн шилдэг арга зүйтэй багш нарыг шалгаруулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх</p>	<p>Шилдэг арга зүйтэй багшийн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн Засаг дарга</p>	<p>Аймаг, нийслэлийн Засаг дарга</p>	<p>40%</p>	<p>70%</p>	<p>100%</p>	<p>Улсын болон орон нутгийн төсөв</p>
<p>2.17</p>	<p>Бүх шатны сургуулиуд багш нарын монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах</p>	<p>Бүх шатны сургуулиуд багш нарын монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах</p>	<p>БШУЯ БМДИ</p>	<p>Нийт ЕБС ИДС МСУТ</p>	<p>40%</p>	<p>70%</p>	<p>100%</p>	<p>-</p>	<p>-</p>

		Сургалтад хамрагдсан багшийн тоо	ЗГХЭГ	БШУЯ					Улсын төсөв
2.18	МХТХ-13.1.1, 21.7.2 МБҮХ-III 2.13. Монгол бичгийн улсын олимпиад, уралдааныг зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх	Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 167-р тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах	Шалгуур үзүүлэлт: Тогтоол нэмэлт өөрчлөлт орсон байна.	БШУЯ	100%	-	-	-	Улсын болон орон нутгийн төсөв
2.19		Улс, аймаг, бүсийн чанартай монгол бичгийн олимпиад, уралдаан, тэмцээний эрх зүйн орчныг сайжруулж, шинэлэг арга хэлбэр, төрөлжүүлэх чиглэлээр удирдаж, чиглэл гаргах, дэмжлэг үзүүлэх	Монгол бичгийн чиглэлээр Аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулах чиглэл баталсан байна.	ТББ-ууд	100%	-	-	-	Улсын болон орон нутгийн төсөв
2.20	МХТХ-9.1.4 17.1.3 МБҮХ-III 2.14. Монгол бичгийн албан бус сургалт явуулах эрх олгох, сургалт явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжих	Монгол бичгийн сургалт эрхлэх хувь хүн, сургалтын төвүүдэд тавих шаардлага, шалгуурыг тогтоож, сургалт эрхлэх зөвшөөрөл олгох эрхзүйн зохицуулалтыг бий болгох, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах	Эрхзүйн зохицуулалт бий болсон байна. Шалгуур үзүүлэлт: Шаардлага хангасан сургалт эрхлэх хувь, сургалтын төвийн тоо	БШУЯ, НХХЯ Аймаг нийслэлийн Засаг дарга ХБҮЗ	100%	100%	100%	100%	-
2.21	МХТХ-9.1.4, 17.1.3 МБҮХ-III- 2.15. Байгууллага, хамт олноороо монгол бичигтэн болох аян өрнүүлэх	МБҮХ-III-ын хэрэгжилт, үндэсний бичгээ дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж, амжилт гаргасан багш нар, бичиг соёлын зүтгэлтэн, төрийн албан хаагч, уран бичээч зэрэг хүмүүсийг төрийн одон медаль, цол, бусад шагналаар урамшуулах	Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь	БСҮГ Төрийн байгууллагууд	100%	100%	100%	100%	Орон нутгийн төсөв

	Монгол хэл, бичиг үсгээ хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гаргасан иргэн, хуулийн этгээдэд дөрвөн жил тутамд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгох ажлыг эхлүүлэх, хэвшүүлэх	Төрийн болон төрийн бус байгуулагаас нэр шагнуулсан байна. Шалгуур үзүүлэлт: Шагнуулсан иргэн, хуулийн этгээдийн тоо	ЕТГ ХБҮЗ	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Тоо	Тоо	Тоо	Тоо	Тоо
2.22									
2.23	Байгууллага, хамт олноороо монгол бичигтэн болох аян хөдөлгөөн, сургалтыг өрнүүлэх	Шалгуур үзүүлэлт: Зохион байгуулсан аяны тоо	Аймаг, нийслэлийн Засаг дарга	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага	Тоо	Тоо	Тоо	Тоо	Тоо
Хөтөлбөрийн зорилт 3. "Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах"									
3.1	МХТХ-12.1ТАТХ-2.1.4,33.6.5, МБҮХ-III 3.1.Төрийн албан хаагчийн анкет/маяг-1/-д монгол бичгээр унших, компьютерт чадварын төвшнийг тэмдэглэх хэсгийг нэмэх	Төрийн албан хаагчийн анкет /маяг-1/-д монгол бичгээр унших, бичих, компьютерт шивэх чадварын төвшнийг тэмдэглэх хэсгийг нэмэх	ТАЗ	ХБҮЗ	1	-	-	-	-
3.2	МХТХ-12.1.21.7.7 22.2.5,ТАТХ-22.1.4, 33.6.5 МБҮХ-III 3.2 Төрийн албаны ерөнхий шалгалтын үнэлгээнд үндэсний бичгийн мэдлэг, чадварыг 20 оноогоор үнэлэх зохицуулалт бий болгох	Төрийн албаны шалгалтын сорилтын санг баяжуулах, монгол бичгийн мэдлэг, чадварыг үнэлгээний оноог нэмэх чиглэлээр холбогдох журам, дүрэмд өөрчлөлт оруулсан байна.	ТАЗ ШУА ХБҮЗ	ХЗХ	Тоо	-	-	-	-

3.3	МХТХ-12.1, ТАТХ-22.1.4, МБҮХ-III-3.3, Төрийн албан хаагчийн ажлын байр /албан тушаалын/-ын тодорхойлолтын тавигдах шаардлагад монгол бичгийн мэдлэг, чадварыг нэмж тусгах	Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтын монгол хэл бичгийн мэдлэг чадварын шаардлагыг нэмж тусгах, монгол бичгийн мэдлэг чадварын үнэлэх ажлыг зохион байгуулна.	Албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагад хэсэгт нэмэлт орсон байна. Төрийн байгууллагууд албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг үнэлсэн байна. Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь	Төрийн байгууллагуд	ХБҮЗ	50%	100%	-	-	-
3.4		Төрийн албан хаагчийн монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгааг 4 жил тутамд явуулах	4 жил тутамд үнэлсэн байна Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн хувь	ЗГХЭГ ТАЗ ХБҮЗ ҮСХ	Төрийн байгууллагууд	100%	-	-	100%	-
3.5		2021 оноос эхлэн төрийн жинхэнэ албаны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн сургалт, төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад монгол бичгийн хичээлийг нэмж тусгана.	Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварын түвшин дээшилсэн байна. Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн явцаар	ТАЗ, ХБҮЗ Удирдлагын академи	Төрийн байгууллагууд	100%				-
3.6		Төрийн бүх шатны албан хаагчдын нэрийн хуудасны загварыг шинэчлэн баталж, англи үндэсний бичиг, англи хэлээр хэвлүүлэх	Шалгуур үзүүлэлт Загварыг шинэчлэн баталсан байна.	ЗГХЭГ ХБҮЗ	-	100%	-	-	-	-
3.7	МХТХ-12.1, 11.1.4, 19.1.2, ТАТХ-22.1.4 МБҮХ-III	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага бүр монгол хэл, бичгийн	Албан хэрэг хөтөлтийн баримт бичгүүд монгол хэл	Төрийн байгууллагуд	ХБҮЗ	100%	100%	100%	100%	-

3.4.Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага бүр монгол хэл, бичгийн хянан найруулах чиг үүргийг холбогдох ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгайлан зааж, гүйцэтгүүлэх арга хэмжээ авч	хянан найруулах чиг үүргийг холбогдох ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгайлан зааж, гүйцэтгүүлэх арга хэмжээ авч	бичгийн үргийн найруулга алдаагүй нөхцөл бүрдэнэ. Шалгуур үзүүлэлт Хэрэгжилтийн хувь	Хувийн хэвшил							
3.8	МОНГОЛ БИЧГЭЭ ХЭРЭГЛЭХ, СУРАХ, СУДЛАХ АЖЛЫГ ҮР ДҮНГЭЙ, АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛСАН ИРГЭН, ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛАГА, АЖ АХУЙ НЭГЖ, КОМПАНИЙГ ХЭВЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР СУРТАЛЧЛАХ, НИЙТЛЭЛ НЭВТРҮҮЛЭХ БЭЛТГЭЖ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТАНИУУЛАХ, УРАМШУУЛАХ	Туршлагыг түгээн дэлгэрүүлж, урамшуулсан байна. Шалгуур үзүүлэлт: Байгууллагын тоо, Жил тутам аймаг бүр-2 байгууллага, МҮОНТВ 3 хүртэлх байгууллага, ХАУТанхим -2 хүртэлх компанийг шалгаруулж үнэлсэн байна.	Аймаг, нийслэлийн Засаг дарга ХБҮЗ ХАУТанхим МҮОНТВ	БСУГ	47	50	50	50	Орон нутгийн төсөв, хандивын хөрөнгө	
	Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр зэрэгцүүлэн хөтлөх ажлыг амжилттай туршсан төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг урамшуулах	Туршилт хийсэн байгууллагыг урамшуулсан байна. Шалгуур үзүүлэлт: Хос бичгээр албан хэргээ хөтөлж туршсан байгууллагын тоо	Аймаг, нийслэлийн Засаг дарга ХБҮЗ ХАУТанхим МҮОНТВ	-	Тоо	Тоо	Тоо	Тоо	Орон нутгийн төсөв, хандив	
Хөтөлбөрийн зорилт 4. Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох										
4.1	МХТХ-13.1.4 МБҮХ-III-	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	Монгол бичиг, сураалж судлалыг онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх

	4.1. Монгол бичиг, сурвалж судлалыг монгол судлалын бие даасан чиглэл болгож, онол, арга зүйн шинэ түвшинд хүргэх	чиглэлээр судлаачдын хэлэлцүүлэг, шинжилгээний зохион байгуулах	эрдэмтэн дунд эрдэм хурал	түвшинд хүргэх санал, хувилбар боловсруулсан байна. Шалгуур үзүүлэлт: Хамрагдсан судлаачдын тоо, хэвлэгдсэн эмхэтгэл	Соёлын яам	СУГ	1	2	2	Улсын төсөв, ОУБ-ын хөтөлбөр, төсөл
4.2		Гадаад дахь монгол судлалын төвүүдтэй хамтран "Монгол бичгийн өвийг хамгаалах, судлах, сурталчлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх	Монгол бичгийн сургалт, судалгааг онол, арга зүйн шинэчлэл хийх, хиймэл оюун ухааныг ашиглах чиглэлээр эрдэм шинжилгээ, онлол-практикийн бага хурал, олон улсын хурал, симпозиумыг үе шаттай, тогтмол зохион байгуулж хэвших	Хөтөлбөр, төсөл эхлүүлсэн байна. Шалгуур үзүүлэлт: Эхлүүлсэн хөтөлбөр, төслийн тоо, нэр төрөл	БШУЯ Соёлын яам ГЯ ШУА	ХЗХ ШУТС СУГ	1	2	2	Улсын төсөв, ОУБ-ын хөтөлбөр, төсөл
4.3	МХТХ-14.1.1 МБУХ-III 4.2. Монгол бичгийн сургалт, арга зүй, судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний хурлыг жил бүр зохион байгуулах	Монгол бичгийн сургалт, судалгааг онол, арга зүйн шинэчлэл хийх, хиймэл оюун ухааныг ашиглах чиглэлээр эрдэм шинжилгээ, онлол-практикийн бага хурал, олон улсын хурал, симпозиумыг үе шаттай, тогтмол зохион байгуулж хэвших	ЭШХурлын бүтээлийн эмхэтгэл хэвлэгдсэн байна. Шалгуур үзүүлэлт: Жил тутамд 2-оос доошгүй хурал	ШУА ХЗХ МУИС МУБИС ШУТСИС	ХБҮЗ Их сургуулиуд		1	1	1	Улсын төсөв, ОУБ-ын хөтөлбөр, төсөл
4.4	МХТХ-14.1.1 МБУХ-III 4.3. Монгол хэл, бичгийн дурсгал, соёлын өвийг хамгаалах, монгол бичгээрх оюуны өв сан болох олон зүйл	Монгол улсад болон гадаадад буй монгол бичиг сийлээстэй хад чулуу, пайлуур, гэрэлт хөшөө зэрэг түүх соёл, хэл бичгийн үнэт дурсгалыг сургалтад хэрэглэх, судлах,	Хөтөлбөр, төсөл хэрэгжсэн байна. Шалгуур үзүүлэлт: Эхлүүлсэн хөтөлбөр, төслийн тоо, нэр төрөл	БШУЯ ШУТС Их сургуулиуд			1	2	2	Улсын төсөв, ОУБ-ын хөтөлбөр, төсөл

<p>ухааны монгол бичгээрх сурвалж бичгүүдийг сургалтад хэрэглэх, түгээх Шинжлэх ухаан, технологийн сан болон бусад үүсвэрээс жил бүр санхүүжүүлэх</p>	<p>сурталчлах чиглэлээр их дээд сургууль, эрдэмтэн, судлаачдын санаачилсан төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа архивын баримтаас сэдэвчилсэн эмхэтгэл бэлтгэн нийтлэх, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах</p>	<p>Эмхэтгэл хэвлэгдсэн байна. Шалгуур үзүүлэлт: Эмхэтгэлийн тоо</p>	<p>АЕГ БШУЯ Соёлын яам</p>	<p>Их дээд сургууль</p>	<p>1</p>	<p>1</p>	<p>1</p>	<p>1</p>	<p>Улсын төсөв, ОУБ-ын хөтөлбөр, төсөл</p>
<p>4.5</p>	<p>МХТХ-19,20 МБҮХ-III 4.4. Монгол контентыг дэмжиж, төрлийг олшруулах</p>	<p>Шалгуур үзүүлэлт: Хэрэглээнд нэвтрүүлсэн цахим сургалт, контентын төрөл, тоо</p>	<p>ХХМТГ ХБҮЗ ТББ Телевизүүдийн холбоо</p>	<p>Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан</p>	<p>5-аас доошгүй</p>	<p>5-аас доошгүй</p>	<p>5-аас доошгүй</p>	<p>5-аас доошгүй</p>	<p>Хувийн хэвшил Хөрөн-гөөр</p>
<p>4.6</p>	<p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй телевиз, радио, сайтууд нийгмийн хармуцлагын хүрээнд монгол бичгээ өвлүүлэх, хамгаалах, сурталчлах чиглэлээр цахим контентийг санаачлан нэвтрүүлэх, монгол бичгийн хэрэглээг дэмжсэн өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн бүтээлд "Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан"-гаас дэмжлэг үзүүлэх</p>	<p>Шалгуур үзүүлэлт: Хэрэглээнд нэвтрүүлсэн цахим сургалт, контентын төрөл, тоо</p>	<p>ХХМТГ</p>	<p>апликэйшн хөгжүүлэгч иргэд ТББ</p>	<p>тоо</p>	<p>тоо</p>	<p>тоо</p>	<p>тоо</p>	<p>Хандив</p>
<p>4.7</p>	<p>Монгол бичгийн хэрэглээг дэмжсэн мобайл апликэйшн хөгжүүлсэн, портал сайт хөгжүүлсэн хөгжүүлэгч хувь хүн, хуулийн этгээдэд</p>	<p>Шалгуур үзүүлэлт: Хэрэглээнд нэвтрүүлсэн цахим бүтээгдэхүүний, тоо төрөл</p>	<p>ХХМТГ</p>	<p>апликэйшн хөгжүүлэгч иргэд ТББ</p>	<p>тоо</p>	<p>тоо</p>	<p>тоо</p>	<p>тоо</p>	<p>Хандив</p>

4.8		<p>зориулсан "Цахим Үндэстэн" ХХМТГ-ын нэрэмжит гаргаж жил бүр экологийн үеэр урамшуулж байх Монгол бичгийг богино хугацаанд шинэлэг хэлбэр, хялбар аргаар сургах цахим контент, цахим хичээл, теле хичээлийн уралдааныг зохион байгуулж шалгаруулах, шилдэг контентын сан үүсгэх, баяжуулах</p>	<p>"Цахим Үндэстэн" ХХМТГ-ын нэрэмжит гаргаж жил бүр экологийн үеэр урамшуулж байх</p>	<p>Шалгуур үзүүлэлт: Цахим санд төвлөрсөн контентын тоо</p>	<p>БШУЯ ХХМТГ</p>	<p>БМДИ НТБҮТ ТББ Иргэд</p>	<p>10</p>	<p>20</p>	<p>40</p>	<p>60</p>	<p>Улсын төсөв, төсөл, хөтөлбөр</p>
4.9	<p>МХТХ- 11.1.3 МБҮХ-III 4.5. Насан туршийн боловсролын төвүүдэд албан бус сургалтаар иргэдэд монгол бичиг сургах сургалтын эрхзүйн орчин бүрдүүлэх</p>	<p>Насан туршийн боловсролын төвүүдэд байгууллага, хамт олон, иргэдэд зориулсан монгол бичгийн хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах</p>	<p>Сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтыг зохион байгуулсан байна. Шалгуур үзүүлэлт: Сургалтын хөтөлбөр, сургалтад хамрагдсан иргэдийн тоо</p>	<p>Аймаг, нийслэлийн Засаг дарга, НТБҮТ</p>	<p>БШУСЯ НТБҮТ ТББ-ууд</p>	<p>1000</p>	<p>1500</p>	<p>1500</p>	<p>3000</p>	<p>Улсын болон орон нутгийн төсөв</p>	
4.10	<p>МХТХ- 11.1.1 11.1.3 21.7.3 СӨХТХ- 14.1.5 МБҮХ-III 4.6. Гадаадад монгол бичгийг сурталчлах үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Гадаадад зохион байгуулагдах үзэсгэлэн, экспо, шинжлэх ухаан, соёлын арга хэмжээнд монгол бичгийн өв соёл, сурвалж, судалгааг сурталчлах, монгол бичгээр дагнасан үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Үндэсний бичиг соёлын өвийг түгээн дэлгэрүүлсэн байна. Шалгуур үзүүлэлт: Монгол бичгийг сурталчилсан үзэсгэлэн, арга хэмжээний тоо</p>	<p>ГХЯ, БШУЯ СЯ ХБҮЗ</p>	<p>Аймаг, нийслэлийн Засаг дарга</p>	<p>2</p>	<p>2</p>	<p>2</p>	<p>2</p>	<p>Улсын төсөв, ОУБ-ын хөтөлбөр, төсөл</p>	

4.11		Монгол улсын сайдын бичгээ жил бүр зохион байгуулах	Монгол улсын сайдын бичгээ жил бүр зохион байгуулах Элчин сайдын бичгийг сурталчилсан арга хэмжээний тоо	Үндэсний соёлын өвийг түгээн дэлгэрүүлсэн байна. Шалгуур үзүүлэлт: Монгол бичгийг сурталчилсан арга хэмжээний тоо	ГХЯ Монгол Улсын Элчин сайдын яамд	Тухайн улс дахь оюутны холбоо ТББ монгол иргэд.			
------	--	---	---	--	---------------------------------------	---	--	--	--

---000---

ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛБАР

УИХТГ – УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ЕИТ-ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР
ЗГХЭГ – ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
БШУЯ – БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ХНХЯ – ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ГХЯ- ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ
ХХТМГ –ХАРИЛЦАА, ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР
АЕГ-АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
СХЗГ-СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
ХБҮЗ- ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
МОНЦАМЭ- МОНГОЛЫН ЦАХИЛГААН МЭДЭЭ АГЕНТЛАГ
УБЕГ-УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
МХЕГ-МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ҮСХ- ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
ШУА-ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ШУТС-ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САН
СУГ - СОЕЛ УРЛАГИЙН ГАЗАР
ХЗХ-ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН
БХ-БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН
ТҮЗХ-ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
БҮТ-БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ
БМИУЗ – БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
БМДИ- БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ
НТБҮТ- НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
НТБТ-НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ
БСУГ – БОЛОВСРОЛ, СОЕЛ УРЛАГИЙН ГАЗАР
МУБИС - МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
МУИС - МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШУТИС- ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ИДС-ИХ ДЭЭД СУРГУУЛЬ
МСУТ- МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ
ХХ-ХЭВЛЭЛИЙН ХҮРЭЭЛЭН
ТББ- ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
ХАУТ-ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
ОУБ-ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
МБҮХ-III- МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-III



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 4/184

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг 2021 оноос эхлэн мөрдсүгэй.

3. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх шатны сургалтын байгууллагад журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, цэцэрлэг, сургуулийн барилга, байгууламжийн гадаад, дотоод орчныг холбогдох стандарт, шаардлагад нийцүүлэн өөрчлөх, сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Журмын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Дээд боловсролын газар /Г.Батнэмэх/, Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс /Ч.Ганцэцэг/, аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус даалгасугай.

5. Журмын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Г.Энхжаргал/-т даалгасугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

142010727

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020
оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 41/24
дугаар тушаалын хавсралт



БҮХ ШАТНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙН ОНЦЛОГТ ТОХИРОХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, СУРГАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургууль /цаашид “Сургалтын байгууллага” гэх/-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, суралцагч /цаашид суралцагч гэх/-ийн хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2. “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчин” гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдын адил суралцахад шаардагдах нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг ойлгоно.

1.3. Сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бүрдүүлэх ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохион байгуулж болно.

1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасан үйлчилгээ нь энэ журамд хамаарахгүй.

Хоёр. Сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүнд тавих шаардлага

2.1. Сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээнд тохируулж сургалтын орчин бүрдүүлэхэд дор дурдсан стандарт шаардлагыг баримтална:

2.1.1. Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009;

2.1.2. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS:6782:2019;

2.1.3. Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS:6799:2019;

2.1.4. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS:6558:2015;

2.1.5. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS:6781:2019 стандарт.

2.2. Тохирох хэрэглэгдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. суралцагчийн хэрэгцээнд нийцсэн, бусад суралцагчийн адил тэгш нөхцөлөөр сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжийг хангахад чиглэсэн;

2.2.2. суралцагчийн нас, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн, хэрэглэгчийн онцлогт тохируулан өөрчлөх боломжтой, ашиглахад хялбар байх;

2.2.3. мэдээлэл харилцааны технологи, тоног төхөөрөмж, программ хангамж, нэмэлт болон туслах үйлчилгээ нь суралцагчийн онцлог, хэрэгцээг хангахуйц байх.

Гурав. Тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэх

3.1. Бүх шатны сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцахад дэмжлэг болох зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.3-т заасан тохирох хэрэглэгдэхүүн бүхий хүртээмжтэй орчин бүрдүүлнэ.

3.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага нь дараагийн хичээлийн жилд хэрэглэгдэх сургалтын тохирох хэрэглэгдэхүүний хэрэгцээг жил бүрийн 1 дүгээр сард багтаан тодорхойлж, байгууллагын түвшинд шийдвэрлэх боломжгүй тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн судалгааг аймаг, нийслэлийн боловсролын газарт тухайн оны 2 дугаар сард багтаан хүргүүлэх;

3.3. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь энэхүү журмын 3.2-т заасан судалгааг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сард багтаан аймаг, нийслэлийн Засаг даргад болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

3.4. Энэхүү журмын 3.3-д заасан судалгаанд үндэслэн төрийн өмчийн цэцэрлэг сургуулийг сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах, нөхөн хангалт хийх ажлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

3.5. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг харьяалах төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

3.6. Ерөнхий боловсролын сургуульд ашиглах сурах бичгийн агуулгыг алдагдуулахгүйгээр хэлбэрийг өөрчлөх, шаардлагатай бол хялбаршуулан аудио, видео /хадмал орчуулгатай/, цахим хэлбэрт хувиргах, хэвлэн нийлүүлэхэд шаардагдах зардлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

3.7. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн бэлтгэх зардлыг тухайн байгууллагын хичээл практикийн зардлаас шийдвэрлэнэ.

3.8. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд энэхүү журмын 3.1-д заасан орчин, тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх хүрээнд дараах ажлыг зохион байгуулна:

3.8.1. сургалт /лекц, семинар, дадлага ажил/-ын үндсэн болон нэмэлт материал, сурах бичиг нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хүртээмжтэй, шаардлагатай тохиолдолд аудио, видео, цахим, брайл хэлбэрт шилжүүлэх, ашиглах зааврыг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэх;

3.8.2. тухайн жилийн шинээр элсэгчдийн судалгаанд үндэслэн тохирох хэрэглэгдэхүүнийг баяжуулах, нөхөн хангалт хийх арга хэмжээг хичээлийн жил эхлэхээс өмнө зохион байгуулах.

3.9. Энэхүү журмын 3.8-д заасан тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэхтэй холбоотой гарах зардлыг тухайн байгууллага хариуцна.

Дөрөв. Суралцах үйлийг дэмжих

4.1. Бүх шатны сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тухайн орчинд дасан зохицох, суралцах үйлийг дэмжсэн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. багш, ажилтныг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээ, онцлогийг судлах, суралцагчийн онцлогт нийцсэн сургалтын арга зүйг төлөвлөн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.2. суралцагчдын оролцоонд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ойлгох, хүндлэх, нөхөрлөх, дэмжлэг үзүүлэх үзэл санааг хэвшүүлэх, тогтмол таниулан сурталчлах;

4.1.3. суралцагч болон эцэг эх, асран хамгаалагчдад тэгш хамран сургахтай холбоотой зөвлөгөө өгч, суралцагчийн сургалт, хөгжлийн явц, ахицыг тогтмол мэдээлж байх;

4.1.4. сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид өөрийгөө илэрхийлэх боломж бүрдүүлэх, олон нийтэд зориулан тэгш хамран сургахтай холбоотой сургалт, сурталчилгааг зохион байгуулах.

Тав. Сургалтын хэрэглэгдэхүүний бүртгэл, ашиглалт

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээнд нийцүүлэн бүрдүүлсэн сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг байгууллагын эргэлтийн хөрөнгөд бүртгэж, ашиглалтыг дараах байдлаар зохицуулна:

5.1.1. цэцэрлэгийн арга зүйч сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг хариуцан ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нөхөн хангалтын захиалга хийх ажлыг хариуцан зохион байгуулна.

5.1.2. ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж, хэрэгслийн ашиглалт, нөхөн хангалт хийх захиалгыг сургуулийн Дэмжлэгийн баг "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам"-д заасны дагуу зохион байгуулж, хариуцна.

5.1.3. их, дээд, сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд тоног төхөөрөмж, хэрэгслийг суралцагчид ашиглуулах болон хадгалалт,

хамгаалалт, нөхөн хангалтын захиалга өгөх асуудлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний суралцах боломж, эрхийг хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий албан хаагч хариуцан зохион байгуулна.

Зургаа. Бусад

6.1. Сургалтын байгууллага нь суралцагч болон эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл, сурталчилгаа бэлтгэх, түгээх арга хэмжээ зохион байгуулахдаа тусгай хэрэгцээтэй хүний онцлогийг харгалзан тэдэнд тэгш, хүртээмжтэй байдлыг хангана.

6.2. Сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог тохирсон сургалтын орчин бүрдүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага болон олон улсын байгууллага, иргэдийг оролцуулахад орон нутгийн захиргааны байгууллага дэмжлэг үзүүлнэ.

.....oOo.....



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: 263727
И-мэйл: info@mes.gov.mn, Вeб сайт: www.mes.gov.mn

2021.01.07 № 6/48
танай _____-ны № _____-т

**АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА,
НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА ТАНАА**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/199 дүгээр тушаалаар батлагдсан “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг хүргүүлж байна.

Хөтөлбөр болон зөвлөмжийг ерөнхий боловсролын сургуулиудад хүргэж, хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хавсралт 3 хуудастай.

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
ДАРГА Т.НЯМ-ОЧИР



1421100043



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 08/199

Улаанбаатар хот

Үлгэрчилсэн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Бага, дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ерөнхий боловсролын сургуульд дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д, багш нарт сургалт зохион байгуулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д тус тус даалгасугай.
3. Үлгэрчилсэн хөтөлбөрт суурилсан төлөвлөгөөг жил бүр батлан үр дүнтэй зохион байгуулахыг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт даалгасугай.
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/-т даалгасугай

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

142010782

Боловсрол, шинжлэх ухаан сайдын
2020 оны 11 сарын 22 өдрийн
1194 дугаар тушаалын хавсралт



ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Бага, дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл¹ дэх “Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ”, Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлагад “Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт байгаль орчин, эдийн засаг, нийгэм, соёлын уялдаа холбоог хангасан цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, суралцагчдад хандлага, үнэт зүйлс, хэрэглээний чадварыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай”, Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмийн “Сургалтын ажил нь хичээл, хичээлээс гадуурх сургалт, хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах тэдгээртэй холбоотой бусад ажлаас бүрдэнэ”, “Сургууль хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн ажлын төлөвлөгөөтэй ажиллана” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.13. “...хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлнэ” зорилт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/186 оны “Ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвд дугуйлан, секц, клуб ажиллуулах зөвлөмж”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/528 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл батлагдсан.

2018 онд Дэлхийн банк, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгээс “Хичээлээс гадуурх үйл ажиллагааны нөхцөл байдал”-ыг илрүүлэх зорилгоор хийсэн шинжилгээний зарим үр дүнд болон “Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээ”-ний тайлан, Боловсролын хүрээлэнгийн хийсэн “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилтийн нөхцөл байдал”-ын судалгааг үндэслэл болгосон.

Боловсролын хүрээлэнгийн хийсэн “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилтийн нөхцөл байдал”-ын

¹ <http://www.legalinfo.mn/>

Баага, дунд боловсролын тухай хууль, 18 зүйл. **Хичээлээс гадуурх сургалтын ажил**

18.1. Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ.

18.2. Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран төгсгөөно.

18.3. Сургуулийн захиргаа нь хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулна.

18.4. Сургууль хүндэтгэлийн танхим, булантай байж болно.

судалгаагаар Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөлтийг авч үзэхэд сургуулийн хэмжээнд төлөвлөгдсөн ажлын 47.0 хувь нь хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хамгаалах, 17.6 хувь нь эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийн хөгжлийг дэмжих, 35.2 хувь нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх, зөвлөн туслахад чиглэсэн байна. Судалгаанд хамрагдсан сурагчдын 76.0 хувь нь урлагийн үзлэг, 58.1 хувь нь секц дугуйлан, олимпиад, 64.0 хувь нь спортын уралдаан тэмцээнд оролцдог гэж хариулсан байна.

Сургуулиас зохион байгуулж байгаа ажил тэдний сонирхолд нийцсэн үйл ажиллагааг зохион байгуулдаг гэж 81.1 хувь нь хариулсан байгаа нь энэ чиглэлийн үйл ажиллагаа сурагчдад хэрэгцээтэй байгааг илэрхийлж байна.

Хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулдаг багш нарын хувьд улсын хэмжээнд нэгдсэн нэг загвартай болох ба зөвлөмж, гарын авлагатай байх саналуудыг илэрхийлсэн байна.

Иймд энэхүү үлгэрчилсэн хөтөлбөр нь хүүхдийн оролцоонд тулгуурлан сурагчдын танин мэдэхүй, билэг авьяас, оюуны чадвар, бие бялдар, нийгэмшлийн хөгжлийг дэмжих, хичээлээс гадуурх үйл ажиллагааг сургуулийн жилийн болон ангийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэхэд багш нарт чиглэл болно.

ХОЁР. ЗОРИЛГО

Суралцагч өөртөө итгэлтэй, бие бялдар, оюун сэтгэхүй, ёс суртахууны төлөвшилтэй, нийгмийн олон талт харилцаанд зохицон, бусдыг манлайлж, хамт олны хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах, шийдвэр гаргах чадвартай, бүтээлч, санаачилгатай хувь хүн болон хөгжихөд дэмжлэг үзүүлнэ.

ГУРАВ. ЗОРИЛТ

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна.

- Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих;
- Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах;
- Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх;
- Билэг авьяас, оюуны чадварыг хөгжүүлэх
- Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих;
- Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих;
- Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих;
- Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх;

ДӨРӨВ. ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 1. Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих

- Хүмүүжлийн үйл ажиллагаанд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх;
- Хүүхэд хүмүүжүүлэх гэр бүлийн уламжлалт соёл, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурласан хүмүүжлийн ажилд дэмжлэг үзүүлэх;

Зорилт 2. Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах

- Амьдралын аюулгүй байдлыг эрхэмлэдэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах;
- Хүүхдийг идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягт сургах, эрүүл хоол хүнс хэрэглэхийн ач холбогдлыг таниулахад чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

- Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй амьдрах ухааны боловсрол олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

Зорилт 3. Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх

- Хүүхдийг шударга ёс, шударга байдал, нинжин сэтгэлийг эрхэмлэдэг, эцэг эх, багш, ахмад үе, үе тэнгийнхэн болон бусад хүмүүсийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хүүхдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг эрчимжүүлэх;
- Үе тэнгийнхний дундах дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх орчин нөхцөл бүрдүүлэх, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах;
- Замын хөдөлгөөний дүрмийг сурталчлан таниулах, соёлтой оролцох дадал төлөвшүүлэх;

Зорилт 4. Билэг авьяас, оюуны чадварыг хөгжүүлэх

- Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан-танин мэдэхүй, зохион бүтээх чиглэлийн үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх;
- Уламжлалт өв соёл, түүн дотроо соёлын биет бус өвийг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх
- Орчин үеийн цаашилбал дэлхийн урлаг, уран сайхны бүтээлийг сурталчлах зорилготой хүүхдийн урлаг, соёлын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, дэмжин хөгжүүлэх;
- Олон нийтийг хамарсан спортын арга хэмжээнд оролцох, эерэг жишээг сурталчлах, дэлгэрүүлэх;

Зорилт 5. Мэдээллийн технологийн ёс зүйтэй хэрэглээг дэмжих

- Уламжлалт соёл, ёс зүй, гэр бүлийн үнэт зүйлийг мэдээллийн орчинд сурталчлахад дэмжлэг үзүүлэх;
- Интернетийн орчинд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлж болохуйц мэдээллээс хамгаалах төрөл бүрийн арга, орчин нөхцөл бүрдүүлэх;
- Цахим хэрэглээний эерэг жишээг сурталчлах
- Янз бүрийн орчин нөхцөлд өөрийгөө удирдах чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Зорилт 6. Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих

- Хүүхдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэх, тэдний эрх, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх;
- Сурагчдыг нийгэмд тустай үйл ажиллагаанд бүтээлчээр оролцоход дэмжлэг үзүүлэх;
- Боловсролын байгууллагуудтай хүмүүжлийн асуудлаар хамтран ажилладаг эцэг эхийн болон олон нийтийн бусад байгууллагын ажиллагааг хөхүүлэн дэмжих;

Зорилт 7. Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих

- Хүүхдэд эх оронч хүмүүжил олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Суралцагчдад суралцах чиглэл, мэргэжлээ тодорхойлж, ухамсартай сонгоход дэмжлэг үзүүлэх;

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Зорилт 8. Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх

- Хүүхдэд байгаль дэлхий, эх орон газар нутгаа хайрлах хандлага төлөвшүүлэх ажлыг дэмжих, хэрэгжүүлэх;
- Байгаль, экологийн чиглэлээр олон талт үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх;
- Тогтвортой хөгжлийн боловсролыг олгоход чиглэсэн сургалт, үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайн туршлагыг сурталчлах

ТАВ. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.1. Хичээлээс гадуурх сургалтын ажлаар хөгжүүлэх чадвар:

Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар 21 дүгээр зууны суралцагчийн эзэмшвэл зохих дараах цогц чадамж, чадваруудыг хөгжүүлэхэд анхаарна. Үүнд:

А. Бүтээлч сэтгэлгээний:

- Бүтээлчээр сэтгэх чадвар
- Хувиараа бизнес эрхлэх чадвар
- Зохион бүтээх чадвар
- Эргэцүүлэх чадвар
- Тунгаан бодох ойлгох
- Асуудал шийдвэрлэх чадвар
- Шийдвэр гаргах чадвар

Б. Нийгэмшихүйн:

- Зохион байгуулах чадвар
- Багаар ажиллах чадвар
- Хамтарч ажиллах чадвар
- Нийтгэч байх чадвар
- Өөрийгөө бусдын оронд тавьдаг байх, бусдыг өрөвдөх чадвар

В. Харилцаа, хамтын ажиллагааны:

- Харилцааны чадвар
- Хувийн сахилга баттай байх чадвар
- Сэтгэл хөдлөлөө хянах, хүлээцтэй байх чадвар
- Хариуцлагатай байх чадвар
- Ёс зүйтэй байх чадвар
- Бие даан суралцах чадвар
- Дасан зохицох чадвар
- Шаргуу байх чадвар
- Өөрийгөө удирдах чадвар

Г. Мэдээллийн технологийн хэрэглээний:

- Мэдээлэл харилцааны технологиор дамжуулан мэдээлэл олж авах чадвар
- Мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар
- Мэдээллийн технологи, мэдээллийг ёс зүйтэй хэрэглэх чадвар

Дээрх чадварыг эзэмшүүлэхийн тулд багш нар хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлаар практикт ашиглаж болох арга, хэрэгсэл, сургалтын стратеги, үйл ажиллагааг түлхүү сонгох хэрэгтэй юм.

5.2. Үйл ажиллагаа:

Хичээлээс гадуурх сургалтын ажлыг орон нутгийн онцлог, тухайн сургуулийн суралцагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг

бататгах, тэдний авьяас, сонирхлыг дэмжин хөгжүүлэх чиглэлээр төсөлт ажил, туршилт, дадлага, дугуйлан, клуб хичээллүүлэх зэрэг олон хэлбэрээр зохион байгуулж болно. Тухайлбал:

- Дугуйлан, секц нь бүжиг, дуу, хөгжим, баримал, уран зураг болон гар бөмбөг, сагсан бөмбөг, бөх, байт сур, сур харваа, хөнгөн атлетик, усанд сэлэлт зэрэг урлаг, спортын авьяасыг нээж, хөгжүүлэх;
- Клуб нь хувцас, хоолны технологи, шатар, механик элетроникийн авьяас хөгжүүлэх болон мэтгэлцээн, байгаль экологи, хүмүүнлэгийн сайн дурын үйл ажиллагаагаар хувь хүний нийгэмшихүйн хөгжлийг хангах

Тодорхой төрлийн үйл ажиллагааг зохион байгуулахад өөр өөрийн зорилго, чиглэлтэй байх учраас арга зүйн хувьд онцлог ялгаатай байна. Иймд хичээлээс гадуурх сургалтын ажлыг боловсролын түвшин бүрт дараах байдлаар хэлбэржүүлэн хэрэгжүүлэх боломжтой юм.

Ангийн үйл ажиллагаа

- Ангийн зорилго, зохион байгуулалт, анги хамт олны уур амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа
- Хувь суралцагчийн нэр хүнд, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа

Секц, дугуйлангийн үйл ажиллагаа

- Суралцах арга барилыг сайжруулахтай холбоотой үйл ажиллагаа (сэтгэхүй хөгжүүлэх дугуйлан)
- Өөрийн авьяас чадварыг нээж, хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа (ардын урлаг, тайз дэлгэц, бүжиг, найрал дуу, үндэсний болон орчин үеийн хөгжим, дүрслэх урлаг, дизайн, техникийн загвар, гар урлал, загвар зохион бүтээх, загвар өмсөгч, шатар, даам, хөнгөн атлетик, спорт тоглоом, өвлийн спорт, бөх, мэтгэлцээний клуб, мини парламент гэх мэт)

Сургуулийн үйл ажиллагаа

- Тэмдэглэлт болон уламжлалт үйл ажиллагаа
- Амжилтаа тайлагнах үйл ажиллагаа
- Сургуулийн өдөр тутмын дэг, соёл, эрүүл аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа
- Ажил хөдөлмөр, нийгмийн сайн сайхны төлөө хийх үйл ажиллагаа
- Сургууль доторх ургамал хамгаалал
- Сургуулийн цайны газар, сургуулийн цайны газар дахь үүрэг хариуцлагын зохион байгуулалт
- Сургуулийн номын санчдад туслах
- Аялал, зугаалга, эх оронтойгоо танилцах тойрон аялал

Сурагчдын зөвлөлийн үйл ажиллагаа


- Сургууль, орон нутгийн сайн сайхан байдал, хөгжлийг дэмжихэд тодорхой чиглэлийн дагуу хувь нэмрээ оруулахтай холбоотой үйл ажиллагаа (сайн дурын үйл ажиллагаа, эко клуб г.м)

Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааны бүх хэлбэр, чиглэл нь боловсролын үр дүн дээр төвлөрсөн байна. Боловсролын үр дүн нь тухайн үйл ажиллагаанд хүүхэд оролцох замаар ёс суртахуунтай хөгжих явдал юм.

Хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Сэдэв, чиглэл, агуулга, хэлбэрийг сонгох, төлөвлөх, зохион байгуулахдаа суралцагчдын оролцоонд тулгуурлах

- Ажлын үр дүнг үнэлэхдээ тооноос илүү чанарыг, тухайлбал суралцагчдын авьяас, ур чадварт гарсан өөрчлөлтөд тулгуурлах
 - Тайлагнах, үнэлэх арга хэлбэр нь нийтэд ил тод байхаас гадна суралцагчид өөрсдөө оролцож, ахиц дэвшлээ мэдэрч, урам авахаар байх
 - Суралцагчид бие дааж ажиллах, чадварын төлөвшил, нийгэмшилд эерэг нөлөө үзүүлэх, ажил мэргэжлийн баримжаа, арга туршлага хуримтлуулахад анхаарах
- Хичээлээс гадуурх сургалтын ажил нь боловсролын үйлчилгээний хавсарга, туслах хэлбэр биш, харин ч тэрхүү үйлчилгээг өөрчлөх, шинэчлэх, хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж өгдөг байна. Иймээс сургууль, суралцагчдын зорилгыг бодит үр дүн болгоход хичээлээс гадуурх сургалтын ажлыг судлагдахуун болоод бусад үйл ажиллагаа, олон нийтийн байгууллага, хөтөлбөрүүдтэй нягт уялдаатай холбож үзэн хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал,



5.3. Орчин, хэрэглэгдэхүүн

Сургуулиуд хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг хангах, өсвөр үеийнхний оролцоо, хамгааллын асуудлыг цогц байдлаар шийдсэн, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлсэн байна.

Сургалтыг танхимын ба танхимын бус хэлбэрээр хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажил хоорондын интеграцыг ханган зохион байгуулна.

Танхимын орчинд:

- Багаар, бүлгээр уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Урлаг, спорт, хурлын заал, анги танхим дахь үйл ажиллагаа, илтгэл тавих, тайлан бичих, хамгаалах;

Танхимын бус орчинд:

- Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцах аялал экскурс хийх;
- Сургууль, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан үйл ажиллагаа;
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчидтэй хамтарсан төсөлт ажил, судалгаа хийх;
- Бүтээлч санал санаачилга бүхий сайн үйлсийн аян өрнүүлэх;
- Зайн сургалтын хэлбэрүүдийг хөгжүүлэх;

- Орон нутгийн мэргэжлийн байгууллагын байр, танхим, олон нийтийн газар, байгаль орчныг түшиглэн явуулна.

ЗУРГАА. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫГ ҮНЭЛЭХ

Хичээлээс гадуурх сургалтын ажлын үр дүнг үнэлэхдээ уралдаан, тэмцээний хэлбэрийг сонгох нь тийм ч оновчтой биш юм. Харин суралцагчдын ур чадвар, амжилтын ахиц, бүтээлийн чанарын өсөлтийг өөртэй нь харьцуулан үзэж үнэлэх нь зохистой төдийгүй суралцагч урамшдаг байна.

Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлан хичээллүүлж буй үр дүнг дараах хэлбэрээр тодруулж, үнэлгээ хийх боломжтой. Үүнд:

- Сэтгэл ханамжийн судалгаа, ярилцлагыг багш, эцэг эх, суралцагчдаас авах ба мөн өөрийн үнэлгээний хуудсаар үнэлэх
- Хүүхдийн хувийн хөгжилд чиглэсэн хандлагын талаарх найдвартай мэдээллийг олж авахад чиглэсэн сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх, социологийн судалгааны ажлыг явуулах
- Суралцагчдын авьяасаа хөгжүүлж, харилцан суралцаж буй байдлыг бүтээлийн үзэсгэлэн, тайлан тоглолт, бүтээлийн сангаар үнэлэх

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны 12 дугаар сарын 28- ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар АМН, А/628

Тушаал хүчингүй болгох тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Норматив батлах тухай" А/166/ А/559/ 222 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай" А/448/А268 дугаар хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн "1-19 насны хүүхдийн хоногийн хоолны норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг батлах тухай" 225/296 дугаар хамтарсан тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.





